

МОНГОЛ УЛСЫН  
НЭГДСЭН ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ  
НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/01/-НА-СТА –НТГ

2024 он

**МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

**АГУУЛГА**

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ .....	5
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ .....	8
<b>БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ НЬ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ТУСГАСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН БАЙНА .....</b>	<b>9</b>
1.1 Нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг хангаж байгаа ч жил бүр төсвийн тухай хуулийг батлахдаа төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулж байна .....	9
1.2 Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсөв нь төсвийн бодлогын зорилт, Улсын Хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн боловч улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар санхүүжих төсөл, арга хэмжээг төсөвт бүрэн тусгаагүй байна .....	11
<b>БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН ТӨЛӨВЛӨСНӨӨС 1,347.5 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР ДАВАХАД ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭ НЭМЭГДСЭН НЬ ГОЛЛОН НӨЛӨӨЛЖЭЭ .....</b>	<b>15</b>
2.1 Төсвийн орлого уул уурхайн салбараас хэт хамааралтай, эрсдэл бүхий байгаа тул цаашид санхүүгийн хуримтлалыг тогтвортойгоор үүсгэж, үр дүнтэй удирдах шаардлагатай байна .....	15
2.2 Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийг 23,039.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 24,387.0 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 105.8 хувийн гүйцэтгэлтэй байна. ....	17
<b>БҮЛЭГ 3. ТӨСВИЙН НИЙТ ЗАРДАЛД ЭЗЛЭХ УРСГАЛ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН ДУНДЖААР 76.9 ХУВЬТАЙ БАЙГАА НЬ ТӨСВИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ ДУНД БОЛОН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГОТОЙ БҮРЭН УЯЛДАХГҮЙ БАЙНА</b>	<b>25</b>
3.1 Төсвийн зардлын чиглэлээр баримталсан бодлогыг үе шаттай хэрэгжүүлсэн боловч үр дүнг тайлагнаагүй байна .....	25
3.2 Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд арвилан хэмнэлт бий болсон хэдий ч хуульд оруулсан зарим өөрчлөлт нь хуулийн ач холбогдлыг бууруулж байна .....	38
<b>БҮЛЭГ 4. НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ 785.9 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АШИГТАЙ ГАРСАН БАЙНА.....</b>	<b>41</b>
<b>БҮЛЭГ 5. ӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ХӨГЖҮҮЛЖ, ГАДААД ӨРИЙГ БУУРУУЛАХ БОЛОМЖ БАЙНА.....</b>	<b>42</b>
5.1 Засгийн газрын 2023 оны өрийн үзүүлэлтүүд нь өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт заасан зорилтот түвшинтэй нийцэж байна .....	42
5.2 Төгрөгийн ханш чангарснаар 512.7 тэрбум төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүний ашигтай гарсан хэдий ч гадаад бондын эргэн төлөлт, хүүгийн зардлыг шинэ бонд гаргах замаар төлж, өрийн хугацааг уртасгасан байна.....	43
<b>БҮЛЭГ 6. ДАВСАН ОРЛОГЫГ ТАЙЛАНТ ОНД ЗАРЦУУЛАХ ЖУРМЫН ЗОХИЦУУЛАЛТ НЬ ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГЫГ БОДИТОЙ ИЛЭРХИЙЛЭХГҮЙ, ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ БАЙНА.....</b>	<b>49</b>
<b>БҮЛЭГ 7. ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСТ БАЙРШУУЛСАН МЭДЭЭЛЭЛ ХУУЛЬД ЗААСАН ИЖ БҮРЭН, ОЙЛГОМЖТОЙ, АЧ ХОЛБОГДОЛТОЙ БАЙХ ЗАРЧМЫГ БҮРЭН ХАНГАХГҮЙ БАЙНА.....</b>	<b>50</b>
7.1 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3-т заасан төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй байна .....	50
7.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай байна .....	50
<b>БҮЛЭГ 8. ӨМНӨХ ОНЫ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ 60.9 ХУВЬТАЙ БАЙНА.....</b>	<b>52</b>
<b>ХАВСРАЛТ: “УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” СЭДЭВТ АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>53</b>



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан"-г нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Ц.Наранчимэг), Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Д.Энхболд) нарт тус тус даалгасугай.

3. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Л.Оюун-Эрдэнэ), Сангийн сайд (Б.Жавхлан) нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал болон холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх, бэлтгэл ажлыг хангах, аудитын үр дүнд хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Самбууням)-д үүрэг болгосугай.

  
Д.ЗАГДЖАВ

## Товчилсон үгийн жагсаалт

1	ААН	Аж ахуйн нэгж
2	ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
3	АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
4	АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
5	АДБХОБ	Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк
6	АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
7	Ам.доллар	Америк доллар
8	АХБ	Азийн хөгжлийн банк
9	АТГ	Авлигатай тэмцэх газар
10	БНБД	Барилгын норм ба дүрэм
11	БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
12	БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
13	БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
14	БХС	Батлан хамгаалахын сайд
15	БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
16	ГХС	Гадаад харилцааны сайд
17	ГЕГ	Гаалийн ерөнхий газар
18	ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
19	ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
20	ЕС	Ерөнхий сайд
21	ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
22	ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
23	ЗДТГ	Засаг даргын тамгын газар
24	ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
25	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
26	ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид
27	МИАТ	Монголын Иргэний Агаарын Тээвэр
28	МУЗГ	Монгол улсын засгийн газар
29	МУЕС	Монгол улсын ерөнхий сайд
30	МУЕП	Монгол улсын ерөнхий прокурор
31	МУЕТГ	Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар
32	МУНТ	Монгол Улсын нэгдсэн төсөв
33	МУНТГ	Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл
34	МУСНУХАЗТБҮХД	Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга
35	НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
36	НДС	Нийгмийн даатгалын сан
37	НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
38	НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
39	НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
40	НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
41	ОАТ	Онцгой албан татвар
42	ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
43	ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
44	ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
45	ОУ	Олон улс
46	ОУВС	Олон улсын валютын сан
47	ӨҮЦ	Өнөөгийн үнэ цэнэ
48	ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
49	СаС	Сангийн сайд
50	СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
51	СоС	Соёлын сайд
52	СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
53	СХС	Сум хөгжүүлэх сан
54	СЯ	Сангийн яам
55	ТАХ	Төсөл, арга хэмжээ

56	ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
57	ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
58	ТБОНӨҮГ	Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
59	ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
60	ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
61	ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
62	ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
63	ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
64	ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
65	УИХ	Улсын Их Хурал
66	УОК	Улсын онцгой комисс
67	УТӨЗ	Улсын төсвийн ерөнхийлөн захирагч
68	УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
69	ҮАГ	Үндэсний аудитын газар
70	ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
71	ХА	Худалдан авалт
72	ХАА	Хөдөө аж ахуй
73	ХБТТУТХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
74	ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
75	ХК	Хувьцаат компани
76	ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
77	ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
78	ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
79	ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
80	ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
81	ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
82	ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
83	ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
84	ШДНЦХ	Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
85	ШС	Шадар сайд
86	ШУ	Шинжлэх ухаан
87	ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
88	ЭМД	Эрүүл мэндийн даатгал
89	ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
90	ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
91	ЭМС	Эрүүл мэндийн сайд
92	ЭМЯ	Эрүүл мэндийн яам
93	ЭМТ	Эрүүл мэндийн төв

**ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1<sup>1</sup>-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2<sup>2</sup> дахь заалтын дагуу Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

**Аудитын зорилт**


Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн зорилт үр нөлөөтэй хэрэгжсэн, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэсэн.

**Аудитын хамарсан хүрээ**

Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7<sup>3</sup>-д заасны дагуу Сангийн яамны бэлтгэсэн Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, танилцуулгад үндэслэн нийт 3611 төсөвт байгууллага, сангуудын төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл;
- Улсын төсвийн 2023 оны гүйцэтгэл;
- Орон нутгийн 2023 оны төсвийн гүйцэтгэл;
- ЭМДС-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэл;
- НДС-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэл;
- Ирээдүйн өв сан;
- Төсвийн тогтворжуулалтын сан;
- Нэмэлт төсвийн 2023 оны гүйцэтгэлийн тайлан;
- Засгийн газрын өрийн үзүүлэлтүүд, гадаад зээлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр;
- Татварын зарлагын тайлан;
- Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын 1140 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл;
- ТЕЗ-дын 2023 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтүүд;
- Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт;
- Өмнөх оны зөвлөмжийн биелэлт. т

Дүрслэл 1. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн байгууллагын тоо



Тайлбар:

- \* Төсвийн ерөнхийлөн захирагч
- \*\* Төсвийн байгууллага, төсвийн гүйцэтгэлийн тайлан
- \*\*\*Гүйцэтгэлээр санхүүжих байгууллага - 2,496

<sup>1</sup> Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.

<sup>2</sup> Төрийн аудитын төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэг сарын дотор аудит хийж, Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлэх

<sup>3</sup> Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах

### Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит, тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Гүйцэтгэлийн аудитын зарчим", MNS 6817-6:2020 "Нийцлийн аудитын тулгуур зарчим", MNS 6817-7:2020 "Гүйцэтгэлийн аудитын стандарт", MNS 6817-8:2020 "Нийцлийн аудит", Монгол Улсын Ерөнхий аудиторын А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын дагуу гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал", 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан "Нийцлийн аудитын заавар, аргачлал"-ын дагуу төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан батлуулж, аудитын горим сорилыг хэрэгжүүлэв. Үүнд, Сангийн яам болон бусад холбогдох яам, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, судалгаа, тоон мэдээлэл авах, түүвэрлэлт, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ, харьцуулалт хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитын тайланд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн гүйцэтгэл, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээ, Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнг нэгтгэсэн болно. Аудитын холбогдох мэдээлэл, ажлын баримтыг хавсаргав.

### Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон уг хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон уг хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын багц хуулиуд;
- Өрийн удирдлагын тухай хууль;
- Ирээдүйн өв сангийн тухай хууль;
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Татварын багц хуулиуд;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль;
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай хууль;
- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Тухайн жилийн төсвийн бодлого, чиглэл, зарчим;
- Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд.



Улсын Их Хурлын болон Засгийн газрын дараах тогтоол, шийдвэрүүдийг 2023 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж ажилласан байна. Үүнд:

- Улсын Их Хурлын 2020 оны "Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" 52 дугаар тогтоол;
- Улсын Их Хурлын 2020 оны "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 24 дүгээр тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам" 29 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2022 оны "Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 448 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2022 оны "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 203 дугаар тогтоол.

#### **Аудитын багийн бүрэлдэхүүн**

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитыг Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд нар удирдаж, аудитын менежер Н.Анхбаяр, Ч.Болд, С.Нацагдорж, Ц.Хосжаргал, П.Чанцалдулам, Л.Мөнхцацрал, Ю.Энхтуяа нар үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор, аудиторууд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Аудитын хамрах хүрээнд зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хөндлөнгийн мэргэжлийн шинжээчээр дүгнэлт гаргуулан, үр дүнг аудитын дүгнэлтэд ашиглалаа.

**ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитын танилцуулгад дурдсан эдийн засгийн макро түвшний үзүүлэлтүүдийг Монголбанкны 2023 оны жилийн тайлан, Үндэсний Статистикийн хорооноос гаргасан “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан”-ийн 2023 оны урьдчилсан гүйцэтгэл, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн танилцуулга 2019-2023 он, Засгийн газраас өргөн барьсан Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээс тоймлон авч үзсэн болно.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн өмнөх оноос 36.0 хувиар өсөж 23,294.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 24.0 хувиар өсөж 22,509.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 785.9 тэрбум төгрөгийн ашигтай байна.

Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд 2022 оны сүүлийн хагаст бий болсон нүүрсний экспортын сэргэлтийг хадгалж, дэлхийн зах зээлд бий болсон түүхий эдийн үнийн бууралтыг ил тод, нээлттэй өрсөлдөөнт биржийн арилжаанд шилжүүлж, уул уурхайн салбар, түүнийг дагасан тээвэр, худалдаа үйлчилгээний салбарыг эрчимжүүлснээр нэрлэсэн ДНБ-ий хэмжээ өмнөх оноос 15,020.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 68,871.7 тэрбум төгрөгт, эдийн засгийн бодит өсөлт 7.0 хувьд хүрчээ.

Эдийн засгийн өсөлтийн 4.4 нэгж хувийг уул уурхай, тээврийн салбар бүрдүүлж, тайлант онд уул уурхайн салбар 23.4 хувь, тээврийн салбар 39.3 хувийн өсөлттэй байсан бол зудын нөхцөл байдал, малын зүй бус хорогдлоор тоо толгой буурснаас хөдөө аж ахуйн салбар 8.9 хувиар агшсан байна.

Монгол Улс 2023 онд 163 улстай худалдаа хийж, нийт бараа эргэлт 24,437.1 сая ам.долларт хүрсэн байна. Экспортын хэмжээ өмнөх оноос 21.1 хувиар өсөж 15,186.9 сая ам.доллар, импортын хэмжээ 6.3 хувиар нэмэгдэж 9,250.2 сая ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 5,936.6 сая ам.долларын ашигтай байна.

Засгийн газрын “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2022 оны 362 дугаар тогтоолоор гааль, татварын автомат бүрдүүлэлтийн системийг бий болгож нүүрсийг уул уурхайн биржээр дамжуулан хилийн үнээр нээлттэй борлуулж, боомтуудын нэвтрүүлэх чадварыг сайжруулснаар төлбөрийн тэнцэл өмнөх оноос 2,184.2 сая ам.доллараар өсөж, 1,457.0 сая ам.долларын ашигтай гарснаар гадаад валютын нөөц оны эцэст 4,921.0 сая ам.долларт хүрчээ.

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляц 2023 оны эцэст улсын хэмжээнд 7.9 хувьд хүрч, өмнөх оноос 5.3 нэгж хувиар буурсан байна.

Экспортыг нэмэгдүүлэх хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд гадаад валютын нөөц нэмэгдэж, төгрөгийн ханш тогтвортой, гадаад шалтгаантай инфляцын дарамт буурснаар инфляц оны эцэст улсын хэмжээнд 7.9 хувьтай байгаа нь мөнгөний бодлогын зорилтот түвшинд хүрсэн байна.

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл өмнөх оноос 3.7 хувиар өсөж 34,569.5 сая ам.долларт хүрсэн бол, Засгийн газрын өр нэрлэсэн үнээр 8,105.1 сая ам.доллар буюу ДНБ-ий 40.0 хувьтай тэнцсэн байна.

**БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ НЬ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ТУСГАСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН БАЙНА**

**1.1 Нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг хангаж байгаа ч жил бүр төсвийн тухай хуулийг батлахдаа төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулж байна**

1.1.1 Монгол Улсын нэгдсэн тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, түүнд нийцүүлсэн төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах харилцааг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хуулиар тус тус зохицуулж байна.

1.1.2 Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг анх баталснаас хойш 14 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд зарим заалтуудын хэрэгжилтийг удаа дараа хойшлуулж байгаа нь тус хуулийн үзэл баримтлалтай нийцэхгүй байна.

1.1.3 Засгийн газраас экспортын голлох бүтээгдэхүүн болон нүүрсний олборлолт, тээвэрлэлт, хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд үүсээд байсан хүндрэл, бэрхшээлийг арилгах хүрээнд БНХАУ-тай хамтран ажилласнаар “уурхайн ам” нөхцөлөөр хямд зарагдаж байсан нүүрсийг уул уурхайн биржээр дамжуулан “хил” нөхцөлөөр ил тод, нээлттэй борлуулж эхэлсэн байна. Үүний үр дүнд Монгол Улсын 2023 оны эхний 4 сарын экспортолсон нүүрсний хэмжээ өмнөх оны эхний 9 сарын хэмжээтэй дүйцэж, эдийн засгийн өсөлт 6.0 хувьд хүрэх, төсвийн тэнцвэржүүлсэн орлого давж биелэх хүлээлттэй байсныг үндэслэн Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4<sup>4</sup>-т заасан үндэслэлээр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулан баталжээ.

1.1.4 Засгийн газраас хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн албан хаагчдын орлогын баталгааг сайжруулах, иргэдийн амьдрах орчныг дээшлүүлэх, хотын түгжрэлийг бууруулах, гол дагуух дэд бүтэц болон нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх “Холбоос зам” төслийн 187.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт нийслэлийн төсвөөс төвлөрүүлэх дүнгээс бууруулан санхүүжүүлэх зэрэг төсөв хооронд зохицуулалт хийх шаардлага бий болсноор төсөвт нийт 1,896.1 тэрбум төгрөгийн тодотгол хийсэн байна.

1.1.5 Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан Монгол Улсын 2023 оны анх баталсан болон тодотгосон төсвийн эдийн засгийн үзүүлэлтүүд нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангасан байна.

**Хүснэгт 1. Монгол Улсын 2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлт**

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл			Өөрчлөлт /өмнөх түвшнээс/	
	Анх баталсан /2022.05.27/	Өөрчлөн баталсан /2022.11.11/	Тодотгол /2023.06.15/	Анх баталснаас	Өөрчлөн баталснаас
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4=3-1</b>	<b>5=3-2</b>
1 ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.0	5.0	6.0	1.0	1.0
2 Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	8.0	10.0	2.0	2.0
3 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	17,312.2	19,049.6	20,781.9	3,469.7	1,732.3
ДНБ-д эзлэх хувь	32.7	34.9	34.5	1.8	(0.4)

<sup>4</sup> төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх.

4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	19,219.1	20,475.3	22,371.4	3,152.3	1,896.1
	ДНБ-д эзлэх хувь	36.3	37.6	37.2	0.9	(0.4)
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	1,305.6	2,561.8	4,211.7	2,906.1	1,649.9
	ДНБ-д эзлэх хувь	2.5	4.7	7.0	4.5	2.3
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	(1,906.8)	(1,425.7)	(1,589.5)	317.3	(163.8)
	ДНБ-д эзлэх хувь	(3.6)	(2.6)	(2.6)	1.0	-
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	4,484.4	5,359.7	5,616.2	1,131.8	256.5
	ДНБ-д эзлэх хувь	8.5	9.8	9.3	0.8	(0.5)
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, ӨҮЦ-ээр /тэрбум төгрөг/	34,428.4	35,434.5	39,125.5	4,697.1	3,691.0
	ДНБ-д эзлэх хувь	65.0	65.0	65.0	-	-
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	604.8	1,961.2	2,209.0	1,604.2	247.8
	-ДНБ-д эзлэх хувь	1.1	3.6	3.7	2.6	0.1

Эх сурвалж: Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хууль

1.1.6 Монгол Улсын Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг анх 1,906.8 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 3.6 хувьтай тэнцүү байхаар баталсан боловч төсвийн тэнцвэржүүлсэн орлого давж биелэх, эдийн засгийн өсөлт 6.0 хувьд хүрэх хүлээлт бий болсон тул алдагдлыг бууруулж ДНБ-ий 2.6 хувьтай тэнцүү буюу 1,589.5 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тодотгон баталсан байна.

1.1.7 Мөн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээг 2,906.1 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн орлогыг 3,469.7 тэрбум төгрөг, нийт зарлагын дээд хэмжээг 3,152.3 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлыг 1,131.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ. Төсвөөс санхүүжүүлэх нийгмийн халамжийн зардал 1,604.2 тэрбум төгрөгөөр өссөн нь өмнөх онд Ирээдүйн өв санд төлөвлөж, зарцуулсан хүүхдийн мөнгийг нийгмийн халамжийн зардалд шилжүүлснээс шалтгаалжээ.

1.1.8 Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 23,294.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 22,509.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 785.9 тэрбум төгрөгийн ашигтай байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2<sup>5</sup>, 19 дүгээр зүйлийн 19.9<sup>6</sup>-д заасан тусгай шаардлагыг хангасан байна.

<sup>5</sup> Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;

<sup>6</sup> Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 12.5 хувиас, 2021 онд 8.8 хувиас, 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.

1.1.9 Тайлант оны нэгдсэн төсвийн нийт зарлага 4,349.4 тэрбум төгрөгөөр буюу 24.0 хувиар өссөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3<sup>7</sup>-т заасан тусгай шаардлагыг хангасан байна.

1.1.10 Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд Засгийн газрын өрийн ӨҮЦ-ээр илэрхийлсэн үлдэгдэл 26,582.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 38.6 хувийг эзэлж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4<sup>8</sup>, 19 дүгээр зүйлийн 19.3<sup>9</sup>-т заасан тусгай шаардлагыг хангасан байна.

**Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуулийг жил бүр төсвийн тухай хуулийг батлахдаа өөрчлөлт оруулж байгаа нь эдийн засгийн үзүүлэлтүүдийг урьдчилан тооцож, батлах ач холбогдлыг бууруулж байна**

1.1.11 УИХ-аас анх баталсан төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан жил бүрийн төсвийн тухай хуулийг баталж байна.

1.1.12 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг 2021 оны 5 дугаар сард УИХ-ын нэгдсэн чуулганаар анх баталж, 2021 оны 11 дүгээр сард 1 удаа нэмэлт өөрчлөлт, 2022 онд 2 удаа тодотгосон байна.

1.1.13 Тодотголоор анх баталснаас нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 2,797.0 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 3,294.0 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 497.0 тэрбум төгрөг, Засгийн газрын өрийн нийт хэмжээ /ӨҮЦ-г 6,466.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нийгмийн халамжийн зардлын төсвөөс санхүүжүүлэх нийт хэмжээг 297.6 тэрбум төгрөгөөр бууруулсан байна.

**1.2 Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсөв нь төсвийн бодлогын зорилт, Улсын Хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн боловч улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар санхүүжих төсөл, арга хэмжээг төсөвт бүрэн тусгаагүй байна**

**Төсвийн жилийн бодлогын зорилт хэрэгжиж тодорхой үр дүнд хүрсэн боловч зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь түвшин тодорхойгүй байна**

1.2.1 Монгол Улсын Засгийн газраас 2023 онд баримтлах 8 бодлого, тэргүүлэх чиглэлийн хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

1.2.2 Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах төсөв, мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж эдийн засгийг тогтворжуулах зорилтын хүрээнд Засгийн газраас төрийн хэмнэлтийг хэрэгжүүлэх, импортын дарамтыг бууруулах, ашигт малтмалыг биржээр дамжуулан борлуулах, төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн төслүүдийг тэргүүн ээлжид дуусгах зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 785.9 тэрбум төгрөг, төлбөрийн тэнцэл 1,457.0 сая ам.долларын тус тус ашигтай, гадаад валютын нөөц 4,921.0 сая ам.доллар болж өссөн байна.

1.2.3 Мөн өмнөх онд 13.2 хувьтай байсан инфляцын хурд саарч 2023 оны эцэст 7.9 хувь болж Төв банкны зорилтот түвшинд хүрсэн, эдийн засаг 7.0 хувиар өсөж, нэрлэсэн ДНБ-ий хэмжээ 68,871.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

1.2.4 Засгийн газраас боомтын сэргэлтийг эрчимжүүлж, эдийн засгийн сэргэлтийг дэмжих, уул уурхайн голлох бүтээгдэхүүний Экспортын биет хэмжээг цар тахлын өмнөх түвшинд хүргэж нэмэгдүүлэх бодлогын хүрээнд ашигт малтмалыг тээвэрлэх, экспортлох үйл ажиллагаа, боомтын хүчин чадал, хил нэвтрэх тээврийн зохицуулалтыг сайжруулан, мөн уул

<sup>7</sup> тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;

<sup>8</sup> Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх.

<sup>9</sup> Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 оны төсвийн жилд 58.3 хувиас, 2016 оны төсвийн жилд 88 хувиас, 2017 оны төсвийн жилд 85 хувиас, 2018 оны төсвийн жилд 80 хувиас, 2019 оны төсвийн жилд 75 хувиас, 2020 оны төсвийн жилд 70 хувиас, 2021 болон 2022 оны төсвийн жилд 70 хувиас, 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна.

уурхайн биржийн тогтолцоог нэвтрүүлснээр нүүрсний экспорт 2019 онтой харьцуулахад 2 дахин их буюу 69.6 сая тонн, зэсийн баяжмал 1.5 сая тонн, төмрийн хүдрийн баяжмал 5.7 сая тонн, жоншны экспорт 1.1 сая тоннд хүрсэн байна.

1.2.5 Уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалт, төрийн өмчит компаниудын үйл ажиллагааг ил тод болгох бодлогын хүрээнд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг боловсруулж батлуулсан байна. Засгийн газрын "Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг батлах тухай" 2023 оны 223 дугаар тогтоолоор хайлуур жонш, төмөр, нүүрсийг уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалахаар шийдвэрлэсэн байна. Тайлант онд Хөрөнгийн биржийн нийт 299 арилжаагаар уул уурхайн 15.6 сая тонн бүтээгдэхүүнийг борлуулснаас 95.7 хувийг нүүрс, 4.3 хувийг төмрийн баяжмал эзэлсэн байна.

1.2.6 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох замаар иргэд олон нийтийн хяналтыг сайжруулж компанийн засаглал, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2023 оны 108 дугаар тогтоолоор "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрмийг шинэчлэн баталж, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нүүрс борлуулалтын болон бусад үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг компанийн цахим хуудсанд байршуулсан байна.

1.2.7 Уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэг шат ахиулах бодлогын хүрээнд ашигт малтмал баяжуулах, боловсруулах нэмүү өртөг шингэсэн ашигт малтмалын баяжмал, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, мөн малчин, мал бүхий этгээдийн борлуулсан анхан шатны боловсруулалтад ороогүй арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөөврийг НӨАТ-аас чөлөөлөх зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсныг Улсын Их Хурал хэлэлцэн 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталжээ.

1.2.8 Засгийн газрын "Жагсаалт батлах тухай" 2023 оны 107 дугаар тогтоолоор ноос, ноолуур боловсруулах, нэхмэл, сүлжмэл, оёмол бүтээгдэхүүний үйлдвэр, арьс, ширний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн импортын барааны гаалийн албан татварыг 100 хувь хөнгөлсөн байна.

1.2.9 Эдийн засгийн хөгжлийг хязгаарлаж буй эрчим хүч, тээврийн салбаруудад либералчлал хэрэгжүүлэх, банкны салбарын реформ, өрсөлдөөнийг дэмжих бодлогын хүрээнд эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх 59 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 447.0 тэрбум төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 446.5 тэрбум төгрөгийг зарцуулсан, Засгийн газрын "Агаарын тээврийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2023 оны 201 дүгээр тогтоолоор орон нутгийн нислэгийг дэмжих зорилгоор 8.6 тэрбум төгрөгийн татаас олгож, дотоодын нислэгийн тийзийн үнийг 2-3 дахин бууруулснаар зорчигч тээврийн тоо 3.5 дахин нэмэгдсэн байна.

1.2.10 Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 2023 онд системийн нөлөө бүхий 5 арилжааны банк олон нийтэд нээлттэй хувьцаат компани болж өөрчлөгдсөн байна.

1.2.11 Эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг бүрдүүлэхийн тулд хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, хөнгөн үйлдвэрлэл зэрэг салбарын Хувийн хэвшил, бизнесийн үйл ажиллагааг дэмжиж эдийн засгийг төрөлжүүлэх бодлогын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн зориулалттай шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 2027 он хүртэл 100 хувь хөнгөлөх хуулийн төсөл, Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, холбогдох хуулийн төслүүдийг боловсруулсныг УИХ баталжээ. Мөн Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны төсвийн урсгал зардалд 86.9 тэрбум төгрөг, шаардагдах зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 135.5 тэрбум төгрөгийг баталснаас 26.4 тэрбум төгрөгийг хүүгийн татаасаар олгосон байна.

1.2.12 Санхүүжилтийн эх үүсвэр, төрлийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж

батлуулсан, Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагуудаас санал авахаар хүргүүлсэн байна.

1.2.13 **Боомт, тээвэр логистикийн үйл ажиллагааг сайжруулах** бодлогын хүрээнд, БНХАУ-ын 341.2 сая юанийн буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 60.7 тэрбум төгрөгийн санхүүжилттэй “Хилийн боомтын дэд бүтэц төсөл”-ийн хөрөнгөөр хэрэгжих Гашуунсухайт боомтод төмөр замын чингэлэг терминал, ачаа болон зорчигч тээврийн барилга байгууламжийн гүйцэтгэл 60.0 хувь, Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн терминал байгуулах төсөл, арга хэмжээ 55.0 хувьтай байна.

*Улсын Хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжих төсөл, арга хэмжээний 84.5 хувийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар баталсан байна*

1.2.14 Улсын төсөв нь хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг бөгөөд Улсын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх эрхзүйн зохицуулалттай байна<sup>10</sup>.

1.2.15 Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор “Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-г баталж, ТЕЗ-дын хэрэгжүүлэх 201 шалгуур үзүүлэлт бүхий 75 төсөл, арга хэмжээг 15,137.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

1.2.16 Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд 156 шалгуур үзүүлэлт бүхий төсөл, арга хэмжээг улсын төсөв болон гадаад зээлийн эх үүсвэрээс 3,534.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан нь нийт санхүүжилтийн эх үүсвэрийн 23.3 хувь байна.

1.2.17 Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний 123 шалгуур үзүүлэлт бүхий төсөл, арга хэмжээг 2,984.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 2,752.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

*Хүснэгт 2. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн уялдаа*

Төсөл, арга хэмжээний тоо /шалгуур үзүүлэлт/	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд туссан	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай тусгаагүй
156	123	33

*Эх сурвалж: “Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн” сэдэвт аудитын тайлан*

1.2.18 Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан улсын төсөв болон гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжих төсөл, арга хэмжээний санхүүжилтийн 84.5 хувийг Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар баталсан нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг дэмжсэн боловч Төсвийн тухай хууль болон ХБТТУТХ-ийн төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагуудын ялгаатай байдлаас шалтгаалан тухайн жилийн төсөвт бүрэн тусгахгүй байна.

1.2.19 Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний санхүүжилт 65.0 хувийн хэрэгжилттэй буюу 9,839.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

*Хүснэгт 3. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэл /тэрбум төгрөг/*

№	Эх үүсвэр	Баталсан санхүүжилт	Санхүүжилтийн хувийн жин	Санхүүжилтийн гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	Улсын төсөв	1,887.7	12.4	2,427.4	128.6
2	Гадаадын зээл тусламж	1,646.5	10.9	1,050.0	63.8
3	Гадаадын хөрөнгө оруулалт	3,004.8	19.9	2,730.4	90.9
4	Төр, хувийн хэвшлийн түншлэл	4,197.2	27.7	-	-
5	Орон нутгийн төсөв	420.0	2.8	129.8	30.9
6	Дотоодын хөрөнгө оруулалт	1,786.0	11.8	1,973.2	110.5

<sup>10</sup> Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3 улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

7	Монгол Улсын Хөгжлийн банк	51.4	0.3	83.5	162.5
8	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	1,243.4	8.2	1,443.8	116.1
9	Бусад	900.0	6.0	0.9	0.1
	<b>Нийт</b>	<b>15,137.0</b>	<b>100.0</b>	<b>9,839.0</b>	<b>65.0</b>

Эх сурвалж: УАГ-ГНАГ, Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн аудитын тайлан

1.2.20 Монгол Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх төр-хувийн хэвшлийн түншлэл, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрийг бодитой тодорхойлоогүй, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцоолоогүй, хариуцах эзэнгүй баталсан нь ХБТТУТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.10-д заасан нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийн шаардлагыг хангахгүй байна<sup>11</sup>.

1.2.21 Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө 70.8 хувьтай хэрэгжсэн бөгөөд төсөл, арга хэмжээний суурь түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тодорхойлоогүйгээс төлөвлөсөн төсөл, арга хэмжээ зорилтот түвшинд хүрэхгүй, улмаар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй, нийгэм, эдийн засагт үзүүлэх ач холбогдлыг бууруулж байна<sup>12</sup>.

<sup>11</sup> санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх;

<sup>12</sup> Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар, "Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүн" сэдэвт аудитын тайлан



**БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА  
ТУСЛАМЖИЙН ДҮН ТӨЛӨВЛӨСНӨӨС 1,347.5 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР ДАВАХАД ЭДИЙН  
ЗАСГИЙН ӨСӨЛТ, ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭ НЭМЭГДСЭН НЬ ГОЛЛОН НӨЛӨӨЛЖЭЭ**

2.1 Төсвийн орлого уул уурхайн салбараас хэт хамааралтай, эрсдэл бүхий байгаа тул цаашид санхүүгийн хуримтлалыг тогтвортойгоор үүсгэж, үр дүнтэй удирдах шаардлагатай байна

2.1.1 Засгийн газраас 2023 онд төсвийн орлогын чиглэлээр 3 бодлогыг хэрэгжүүлэхээр төсвийн баримт бичгийг боловсруулан, УИХ-д өргөн барьсан байна.

2.1.2 Төсвийн орлогын чиглэлээр баримталсан бодлогын хэрэгжилтийг нэгтгэн тайлагнаж, үр дүнг үнэлж дүгнээгүй, зарим арга хэмжээ хэрэгжээгүй байна.

2.1.3 *“Боомтын сэргэлтийг эрчимжүүлэн экспортоос орох төсвийн орлогыг нэмэгдүүлэх”* бодлогын хүрээнд Гашуунсүхайд-Ганц мод боомтын төмөр замыг холбох, Цагаандэл-Уул, Хавирга боомтыг нээх арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, бусад боомтуудад өргөтгөл, шинэчлэлийн ажлуудыг өмнөх оноос үргэлжлүүлэн хэрэгжүүлжээ.

2.1.4 Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын нийгмийн хариуцлагын хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгөх хандив, тусламжийг *“Уул уурхайн төсөл хөтөлбөрөөс орон нутгийн иргэдийн хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх”* бодлогын дагуу ОНХС-д төвлөрүүлэхээр Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулжээ.

*“Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд үйл ажиллагаа явуулж буй тухайн сум, дүүргийн иргэдийг ажлын байраар хангадаг байх”* арга хэмжээний хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл тодорхойгүй байна.

2.1.5 *“Далд эдийн засгийг бууруулж, татварын суурийг нэмэгдүүлэх”* бодлогын хүрээнд бараа бүтээгдэхүүн, ашигт малтмалыг үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, импортын үе шат бүрээр мэдээллийн санд бүртгэх журам баталж, экспорт, борлуулалт, тээвэр зуучийн эрх шилжүүлсэн гэрээнүүдийг бүртгэх системийн хөгжүүлэлтийг хийсэн байна. Мөн цахим төлбөрийн баримтын системийн хамрагдалтыг сайжруулах, худалдааны төвүүдийн төлбөрийн баримт олголтыг эрчимжүүлэх, хяналт тавих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлжээ.

**Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний орлого төлөвлөснөөс 32.5 хувиар давж, өмнөх оноос 56.2 хувиар өссөн нь ашигт малтмалын олборлолт, экспортын биет хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.**

2.1.6 Уул уурхайн бүтээгдэхүүнийг нээлттэй арилжих замаар борлуулалт, тээвэрлэлтэд хяналт тавих цогц системийг бий болгох, зах зээлийн бодит үнэ тогтоох боломжоор хангах, улс орны эдийн засгийн өсөлтөд тус салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор нэвтрүүлж буй *“Уул уурхайн бүтээгдэхүүний бирж”*-ийн тогтолцоог дэмжиж ажиллахаар төлөвлөсөн байна.

2.1.7 Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор *“Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”* баталж, 2023 оны 223 дугаар тогтоолоор биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг нүүрс, төмрийн хүдэр, хайлуур жонш байхаар тогтоожээ.

2.1.8 Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2023 онд 299 удаагийн арилжаагаар нийт 15.6 сая тонн бүтээгдэхүүн борлуулснаас нүүрс 14.9 сая тонн, төмрийн хүдэр 0.7 сая тонн байна<sup>13</sup>.

2.1.9 Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний орлого өмнөх оноос 56.2 хувиар өсөж, эдийн засгийн 7.0 хувийн өсөлтийн 2.6 нэгж хувийг эзэлж байна<sup>14</sup>.

2.1.10 Тайлант онд уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний орлого 8,616.6 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 2,114.3 тэрбум төгрөгөөр буюу 32.5 хувиар давж биелсэн байна.

<sup>13</sup> Монголын хөрөнгийн биржийн 2023 оны уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны тойм

<sup>14</sup> Үндэсний статистикийн хороо ДНБ-ий 2023 оны урьдчилсан гүйцэтгэл

2.1.11 Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний орлогын 48.9 хувийг АМНАТ, 25.4 хувийг ААНОАТ, 6.6 хувийг ногдол ашиг, 4.0 хувийг гаалийн татвар хураамж, 15.1 хувийг бусад татвар, хураамж эзэлж байна.

2.1.12 АМНАТ-ийн орлогыг 3,217.8 тэрбум төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 4,210.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн, 31.3 тэрбум төгрөгийн авлага үүсгэн, Төсвийн тогтворжуулалтын санд 583.7 тэрбум төгрөг, улсын төсөвт 3,658.2 тэрбум төгрөгийг тус тус хуваарилсан байна.

2.1.13 Нэгдсэн төсвийн нийт орлогын 35.3 хувийг уул уурхай, газрын тосны салбарын орлого бүрдүүлж байгаагаас гол нэр төрлийн эрдэс баялаг<sup>15</sup> болох нүүрс 19.4 хувийг, зэсийн баяжмал 11.2 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 4. Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний орлого бүрдүүлэлт /тэрбум төгрөг/

№	Бүтээгдэхүүн	х/н	Биет хэмжээ			Үнэ, ам доллар/нэгж			Орлого /тэрбум төгрөг/		
			2022 он		2023 он	2022 он		2023 он	2022 он		2023 он
			Гүйц	Төлөв	Гүйц	Гүйц	Төлөв	Гүйц	Гүйц	Төлөв	Гүйц
1	Нүүрс	сая .тн	31.8	50.0	69.6	204.4	140.0	127.8	2,260.7	2,649.0	4,723.8
2	Зэсийн баяжмал	сая .тн	1.5	1.5	1.5	8,813.9	8,670.0	8,482.8	2,425.6	2,547.3	2,742.6
3	Алт, тушаасан (цэвэр жингээр)	тн, \$/унц	17.7	20.7	12.4	1,857.9	1,840.0	1,840.5	258.2	287.6	311.7
4	Төмрийн хүдэр	сая .тн	4.7	8.4	5.7	82.6	84.0	77.9	56.5	270.4	117.5
5	Боловсруула агүй нефть	сая .бар	2.6	6.5	12.4	92.8	82.0	77.1	160.9	425.0	304.2
6	Бусад								354.2	323.0	416.8
<b>Дүн</b>									<b>5,516.0</b>	<b>6,502.3</b>	<b>8,616.6</b>

Бүтээгдэхүүний орлого бүрдүүлэлт

Эх сурвалж: Сангийн яам

2.1.14 Уул уурхайн салбарын голлох нэр төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын биет хэмжээ өмнөх оноос 1.2-4.8 дахин, төлөвлөснөөс 1.4-1.9 дахин нэмэгдсэн ч нэгжийн үнэ өмнөх оны гүйцэтгэлээс 0.9-37.5 хувиар буурсан, төлөвлөснөөс 2.2-8.7 хувиар бага байна.

2.1.15 Гадаадын шууд хөрөнгө оруулалтад уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 75.1 хувийг эзэлж байгаа нь 2019 оноос 2.6 хувиар, өмнөх оноос 0.3 хувиар нэмэгдсэн, гадаад худалдааны экспортод уул уурхай эрдэс баялгийн бүтээгдэхүүн 86.6 хувийг эзэлж, 2019 оноос 2.9 хувиар, өмнөх оноос 2.5 хувиар өссөн<sup>16</sup> үзүүлэлттэй байна.

2.1.16 Уул уурхайн салбарын орлогоос Төсвийн тогтворжуулалтын санд 2011 оноос, Ирээдүйн өв санд 2017 оноос эхлэн хуримтлал үүсгэж байгаа нь тухайн жилийн ДНБ-ий 0.01-5.7 хувийг эзэлж байна.

<sup>15</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2."гол нэр төрлийн эрдэс баялаг" гэж тухайн жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг нь бүрдүүлж байгаа тухайн төрлийн эрдэс баялгийг;

<sup>16</sup> Монгол банкны статистик мэдээ

Хүснэгт 5. Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв санд 2011-2023 онд үүсгэсэн хуримтлал /тэрбум төгрөг/

Он	Нийт орлого ба тусламжийн дүн	ДНБ	Хуримтлал			Эзлэх хувь	
			Ирээдүйн өв сан	Төсвийн тогтворжуулалтын сан	Дүн	Нийт орлого ба тусламжид	ДНБ-д
2011	4,468.2	13,173.8		241.0	241.0	5.4	2.2
2012	4,975.8	16,688.4		94.7	94.7	1.9	0.7
2013	5,986.9	19,174.2		46.9	46.9	0.8	-
2014	6,316.5	22,227.0		39.9	39.9	0.6	0.2
2015	5,983.4	22,894.8		2.3	2.3	0.1	-
2016	5,835.0	23,931.3			-	-	-
2017	7,958.3	28,010.7	357.7	325.7	683.4	8.6	2.5
2018	10,172.8	32,582.6	620.7	207.0	827.7	8.1	2.5
2019	12,040.3	37,839.2	1,040.2	94.6	1,134.8	9.4	3.1
2020	10,450.2	37,453.3	914.1	66.2	980.3	9.4	2.7
2021	14,306.4	43,555.5	967.0	627.9	1,594.9	11.2	4.3
2022	18,521.6	53,851.5	1,670.3	1,394.6	3,064.9	16.6	5.7
2023	24,387.0	68,871.7	416.2	675.9	1,092.1	4.5	1.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

2.1.17 Төсвийн тогтворжуулалтын санд 2011-2023 онд нийт 3,816.7 тэрбум төгрөгийн, Ирээдүйн өв санд 5,986.2 тэрбум төгрөгийн хуримтлал үүсгэн, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, Хүний хөгжил сангийн өглөгийг барагдуулах, хүүхдийн мөнгөн хуримтлал олгох зэргээр нийт 5,461.6 тэрбум төгрөгийг зарцуулж, тайлант оны эцэст 4,341.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.2 Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийг 23,039.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 24,387.0 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 105.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.1 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн төлөвлөснөөс 1,347.5 тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 5,865.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хүснэгт 6. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022 оны гүйц	2023 он				Өмнөх оноос өөрчлөлт
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>18,521.5</b>	<b>23,039.5</b>	<b>24,387.0</b>	<b>1,347.5</b>	<b>105.8</b>	<b>5,865.5</b>
Төсвийн тогтворжуулалтын сан	1,394.6	501.6	675.9	174.3	134.7	(718.7)
Ирээдүйн өв сан	-	540.0	416.2	(123.8)	77.1	416.2
<b>Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн*</b>	<b>17,126.9</b>	<b>21,997.9</b>	<b>23,294.9</b>	<b>1,297.0</b>	<b>105.9</b>	<b>6,168.0</b>
Татварын орлого	15,459.0	19,760.7	21,484.2	1,723.5	108.7	6,025.2
Татварын бус орлого	1,667.9	2,237.2	1,810.7	(426.5)	80.9	142.8
<b>Төсвийн бүрэлдэхүүнээр:</b>						
Улсын төсвийн орлого	11,629.7	15,184.6	16,085.2	900.6	105.9	4,455.5
Орон нутгийн төсвийн орлого	3,022.4	4,616.5	4,891.3	274.8	106.0	1,868.9
ЭМДС-ийн орлого	1,224.7	1,603.5	1,586.8	(16.7)	99.0	362.1
НДС-ийн орлого	3,512.5	4,175.2	4,271.6	96.4	102.3	759.1
Ирээдүйн өв сангийн орлого	1,626.3					(1,626.3)

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт /\*цэвэр дүнгээр/

2.2.2 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн 88.1 хувийг татварын орлого, 7.4 хувийг татварын бус орлого, 2.8 хувийг Төсвийн тогтворжуулалтын санд, 1.7 хувийг Ирээдүйн өв санд төвлөрүүлэх орлого эзэлж байна.

Дүрслэл 1. Нийт орлого ба тусламжийн дүн, төрлөөр, тэрбум төгрөгөөр /тэрбум төгрөгөөр/



2.2.3 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн төлөвлөснөөс 1,347.5 тэрбум төгрөгөөр буюу 5.8 хувиар давж биелсэн нь АМНАТ 1,024.1 тэрбум төгрөг, ААНОАТ 780.6 тэрбум төгрөг, ХХОАТ 213.6 тэрбум төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 117.2 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 108.6 тэрбум төгрөгөөр тус тус давсан нь голлон нөлөөлсөн байна.

2.2.4 Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 21,997.9 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 23,294.9 тэрбум төгрөгт хүрч, 105.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.5 Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 59.9 хувийг улсын, 18.3 хувийг орон нутгийн, 15.9 хувийг НДС-ийн, 5.9 хувийг ЭМДС-ийн орлогоос тус тус бүрдүүлжээ.

2.2.6 Тайлант оны нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн ДНБ-ий 33.8 хувьтай тэнцэж, төлөвлөснөөс 1.9 нэгж хувь, өмнөх оноос 1.4 нэгж хувиар өссөн байна.

2.2.7 Эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор татварын орлого төлөвлөснөөс 1,723.5 тэрбум төгрөгөөр буюу 8.7 хувиар давж биелсэн бол татварын бус орлогын төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэн батлахгүй байгаагаас шалтгаалан 426.5 тэрбум төгрөгөөр буюу 19.1 хувиар тасарсан байна.

2.2.8 Улсын төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 105.9 хувь, орон нутгийн төсвийн орлого 106.0 хувь, ЭМДС-ийн орлого 99.0 хувь, НДС-ийн орлого 102.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.9 Тайлант онд Сангийн яамнаас орон нутгийн төсвийн суурь орлогыг 2,903.1 тэрбум төгрөгөөр баталсан нь өмнөх оноос 601.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.2.10 Сангийн яамнаас хянасан суурь орлогыг тухайн шатны ИТХ нь 1,713.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 4,616.5 тэрбум төгрөгөөр баталснаас 4,891.3 тэрбум төгрөг бүрдүүлж, 106.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 7. Орон нутгийн 2023 оны нийт орлого ба тусламж /тэрбум төгрөг/

Аймаг, нийслэл	Орлого				Аймаг, нийслэл	Орлого			
	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Архангай	55.2	55.5	0.4	100.7	Орхон	279.9	287.0	7.1	102.5
Баян-Өлгий	44.9	44.8	(0.1)	99.8	Өвөрхангай	64.2	68.9	4.6	107.2
Баянхонгор	67.8	69.6	1.7	102.5	Өмнөговь	1050.2	1085.8	35.6	103.4
Булган	73.8	74.4	0.6	100.7	Сүхбаатар	75.1	68.3	(6.8)	90.9
Говь-Алтай	54.2	53.5	(0.8)	98.6	Сэлэнгэ	86.0	82.6	(3.5)	96.0
Говьсүмбэр	18.7	20.6	1.8	109.8	Төв	94.7	101.2	6.4	106.8
Дархан-Уул	53.8	63.6	9.9	118.3	Увс	52.9	53.7	0.8	101.5
Дорноговь	148.8	124.5	(24.3)	83.7	Улаанбаатар	2001.6	2205.0	203.4	110.2
Дорнод	81.7	83.0	1.2	101.5	Ховд	71.4	92.5	21.1	129.6
Дундговь	47.6	52.7	5.2	110.8	Хөвсгөл	70.4	73.5	3.1	104.4
Завхан	55.3	61.0	5.6	110.2	Хэнтий	68.1	69.7	1.7	102.5
<b>Нийт дүн</b>						<b>4,616.5</b>	<b>4,891.3</b>	<b>274.8</b>	<b>106.0</b>

2.2.11 Орон нутгийн төсвийн нийт орлого, тусламжийн 45.1 хувийг Улаанбаатар хот, 22.2 хувийг Өмнөговь аймаг, 5.9 хувийг Орхон аймаг, 2.5 хувийг Дорноговь аймаг, 24.3 хувийг бусад аймгууд бүрдүүлсэн байна.

2.2.12 Орон нутгийн нийт орлого ба тусламжийн орлогын 78.1 хувийг татварын орлого, 21.9 хувийг татварын бус орлого эзэлж байна.

**Төсвийн тогтворжуулалтын санд 675.9 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 416.2 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна**

2.2.13 Төсвийн тогтворжуулалтын санд 501.6 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр ААНОАТ-ын орлогоос 92.2 тэрбум төгрөг, АМНАТ-ийн орлогоос 583.7 тэрбум төгрөг, нийт 675.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.2.14 Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлого төлөвлөснөөс 34.7 хувиар буюу 174.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь ашигт малтмалын экспортын биет хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалжээ.

2.2.15 Сангийн сайдын 2023 оны 236 дугаар тушаалаар Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгөөс 100.0 тэрбум төгрөгийг 2024 оны эхний улиралд багтаан буцаан төвлөрүүлэхээр Монгол Улсын Хөгжлийн банканд байршуулсан байна.

2.2.16 Ирээдүйн өв санд тайлант онд 540.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 416.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

2.2.17 ТӨБЗГ-ын 2023 оны 341 дүгээр тогтоолоор Ирээдүйн өв санд төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогоос 552.0 тэрбум төгрөг бүрдүүлэхээс 416.2 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 24.6 хувиар тасарсан байна.

2.2.18 Төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлого тасарсан нь Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2022 оны цэвэр ашигт ногдуулсан 135.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

2.2.19 Төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогыг төвлөрүүлээгүй нь “Эрдэнэс Тавантолгой ХК-ийн төрийн өмчид ногдох хувьцааны ашгийн орлогоос Эрдэнэс Тавантолгой ХК, Эрдэнэс Монгол ХХК, түүний нэгдлийн болон бусад төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд хооронд үүссэн өр, авлагад суутган тооцох”-ыг УИХ-аас даалгасантай холбоотой байна.

2.2.20 Сангийн сайдын 2023 оны 241 дүгээр тушаалаар Ирээдүйн өв сангийн төрийн санд хуримтлагдсан хөрөнгөөс Монголбанк дахь Ирээдүйн өв сангийн харилцах дансанд 1,300.0 тэрбум төгрөгийг тусгаарлаж, хүү тооцох замаар арвижуулахаар шийдвэрлэн, байршуулсан боловч банкны үйлчилгээний талаар харилцан тохиролцсон гэрээг Монголбанктай өнөөг хүртэл байгуулаагүй байна.

**Татварын орлого 1,723.5 тэрбум төгрөгөөр давсан нь ашигт малтмалын экспортын биет хэмжээ нэмэгдсэн нь нөлөөлсөн байна**

2.2.21 Татварын орлогод 19,760.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 21,484.2 тэрбум төгрөгийн буюу 108.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 8. Монгол улсын 2023 оны нэгдсэн төсвийн татварын орлого /тэрбум төгрөг/

д/д	Дансны нэр	2022 оны гүйц	2023 он			
			Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
1	<b>Татварын орлого*</b>	<b>15,459.0</b>	<b>19,760.7</b>	<b>21,484.2</b>	<b>1,723.5</b>	<b>108.7</b>
1.1	Орлогын албан татвар	3,826.5	4,712.9	5,702.6	989.7	121.0
1.2	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	3,038.3	3,842.2	3,950.8	108.6	102.8
1.3	Хөрөнгийн албан татвар	237.6	382.1	394.8	12.7	103.3
1.4	Нэмэгдсэн өртгийн албан татвар	3,946.2	4,771.9	4,777.0	5.1	100.1
1.5	Онцгой албан татвар	847.8	972.0	790.1	(181.9)	81.3
1.6	Тусгай зориулалтын орлого	19.4	20.0	21.6	1.6	108.0
1.7	Гадаад үйл ажиллагааны орлого	1,255.5	1,644.0	1,465.4	(178.6)	89.1
1.8	Бусад татвар (Төлбөр, хураамж)	2,287.7	3,415.6	4,381.9	966.3	128.3
<b>Төсвийн бүрэлдэхүүнээр:</b>						
1	Улсын төсвийн татварын орлого	8,917.8	12,459.0	13,715.0	1,256.0	110.1
2	Орон нутгийн төсвийн татварын орлого	2,362.4	3,459.6	3,818.3	358.7	110.4

3	ЭМДС-ийн орлого	1,224.7	1,603.5	1,586.8	(16.7)	99.0
4	НДС-ийн орлого	2,668.6	3,400.8	3,507.2	106.5	103.1
5	Ирээдүйн өв сан	1,140.5			-	-


Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт, /цэвэр дүнгээр/

2.2.22 Улсын төсвийн татварын орлого 10.1 хувь буюу 1,256.0 тэрбум төгрөг, орон нутгийн татварын орлого 10.4 хувь буюу 358.7 тэрбум төгрөг, НДС-ийн орлого 3.1 хувь буюу 106.5 тэрбум төгрөгөөр тус тус давж, ЭМДС-ийн орлого 1.0 хувиар буюу 16.7 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

2.2.23 Татварын орлогын өсөлтөд орлогын албан татвар 989.7 тэрбум төгрөг, бусад татвар 966.3 тэрбум төгрөг, НДС-ийн орлого 108.6 тэрбум төгрөгөөр давсан нь голлон нөлөөлжээ.

2.2.24 Нэгдсэн төсвийн татварын нийт орлогын 26.5 хувийг орлогын албан татвар, 22.2 хувийг НӨАТ, 20.4 хувийг бусад татвар, 18.4 хувийг НДС-ийн орлого, 6.8 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 3.7 хувийг орлогын албан татвар, 1.9 хувийг хөрөнгийн татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлогоос бүрдүүлсэн байна.

Дүрслэл 2. Татварын орлогын дүн, төрлөөр /тэрбум төгрөгөөр/



2.2.25 Төсвийн орлогыг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн сууриар хөтөлж байгаагаас санхүүгийн тайланд тусгагдаагүй, 2000-2022 онд үүссэн 2,562.2 тэрбум төгрөгийн татварын авлагын үлдэгдэл байна.

2.2.26 Татварын авлагын үлдэгдэлд 2-оос дээш жил болсон 1,567.9 тэрбум төгрөгийн авлагаас 702.0 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах талаар зохих арга хэмжээг авсан, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдээс авах 349.8 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах талаар зохих арга хэмжээ аваагүй, бусад 516.1 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхойгүй байна.

2.2.27 Орлогын албан татварын орлого 5,702.6 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 21.0 хувиар буюу 989.7 тэрбум төгрөгөөр давсан нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- Улсын төсвийн ААНОАТ-ын орлого 630.7 тэрбум төгрөгөөр давсан нь өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнэ өмнөх онтой харьцуулахад 7.9 хувиар, татвар төлөгч аж ахуйн нэгжийн ногдолтой тайлан 17.7 хувиар өссөн;
- Орон нутгийн ХХОАТ-ын орлого 213.6 тэрбум төгрөгөөр давсан нь цалин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн байна.

2.2.28 Орон нутгийн төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсан аймгуудад 2022 онд ААНОАТ-ын орлогын 40.0 хувийг урьдчилан тооцож, 133.5 тэрбум төгрөг олгосныг 2023 оны ААНОАТ-ын гүйцэтгэлээс хасаж тайлагнасан байна.

2.2.29 Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлого 3,950.8 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 2.8 хувиар буюу 108.6 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь төрийн албан хаагчдын цалин өссөн, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.2.30 ЭМДС-ийн орлого 1,586.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөснөөс 16.6 тэрбум төгрөгөөр тасарчээ.

- 2.2.31 ЭМДС-ийн нийт орлогын 38.9 хувийг ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл, 15.9 хувийг төр хариуцах иргэдийн шимтгэл, 43.2 хувийг төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт, 1.8 хувийг бусад даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогоос бүрдүүлсэн байна.
- 2.2.32 Сүүлийн 3 жилийн статистикаас үзэхэд өмнөх оноос 2022 онд даатгуулагчийн тоо 143,416 хүнээр, даатгалын орлого 2,234.2 тэрбум төгрөгөөр, 2023 онд даатгуулагчийн тоо 39,717 хүнээр, даатгалын орлого 364.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.
- 2.2.33 ЭМД-д даатгуулагчдын 24.3 хувийг ажил олгогч шимтгэлийг хариуцах, 6.9 хувийг өөрөө хариуцах, 68.8 хувийг төр хариуцах иргэд эзэлж байна.
- 2.2.34 ЭМД-ын эрсдэлийн санг 40.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж байгуулахаар төлөвлөж нэг өдөр байршуулаад, буцаан зарцуулж байгаагаас үзэхэд эрсдэлийн сан болон төсвийг бодитой төлөвлөөгүй, ЭМДС-ийн орлого хүрэлцэхгүй байгаагаас шалтгаалсан байна.
- 2.2.35 НДС-ийн шимтгэл, хураамжийн орлого 3,507.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 106.4 тэрбум төгрөгөөр давсан байна.
- 2.2.36 Засгийн газрын “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг тухайн оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлсэн, тайлант онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 550.0 мянган төгрөг болгосонтой уялдуулан сангийн орлого нэмэгдсэн байна.
- 2.2.37 Мөн НДС-ийн орлого давж биелсэн нь тайлант онд нийгмийн даатгалд 58,653 ААНБ бүртгэгдэж, өмнөх оноос 3,199 ААНБ-аар нэмэгдсэн, албан журмын болон сайн дурын даатгалд 1,344,639 даатгуулагч хамрагдсанаас шалтгаалжээ.
- 2.2.38 Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 104.2 тэрбум төгрөгийн авлага үүссэнээс 25.0 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг хүлээн авч, 11.0 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг худалдаж, 68.2 тэрбум төгрөгийн авлага барагдаагүй байна.
- 2.2.39 Капитал банкны эрх хүлээн авагчаас 25.0 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг хүлээн авч, 9.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг борлуулсан, 15.9 тэрбум төгрөгийн хөрөнгө борлуулаагүй байгаа нь сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.
- 2.2.40 Хөрөнгийн албан татварын орлого 382.1 тэрбум төгрөг төлөвлөснөөс 394.8 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, 103.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь үл хөдлөх хөрөнгийн татвар 14.6 тэрбум төгрөг, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 4.3 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэнтэй холбоотой байна.
- 2.2.41 Нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 4,771.9 тэрбум төгрөг төлөвлөснөөс 4,777.0 тэрбум төгрөгийг бүрдүүлж, 100.1 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь дотоодын барааны НӨАТ 206.0 тэрбум төгрөгөөр давсан, НӨАТ-ын буцаан олголтоос 17.2 тэрбум төгрөгийн хэмнэлт үүссэн, импортын барааны НӨАТ 218.1 тэрбум төгрөгөөр тасарсан зэргээс шалтгаалсан байна.
- 2.2.42 Онцгой албан татварын орлого 972.0 тэрбум төгрөг төлөвлөснөөс 790.1 тэрбум төгрөгийг бүрдүүлж, 181.9 тэрбум төгрөгөөр тасарсан нь дизелийн түлшний онцгой албан татварыг “0” хувиар тогтоосон, дотоодын архи, тамхины борлуулалт, импортын архи, тамхины тоо хэмжээ буурсан зэргээс шалтгаалжээ.
- 2.2.43 Тусгай зориулалтын орлого 20.0 тэрбум төгрөг төлөвлөснөөс 1.6 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь дизель түлшний импортын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.
- 2.2.44 Гадаад үйл ажиллагааны орлого 1,644.0 тэрбум төгрөг төлөвлөснөөс 1,465.4 тэрбум төгрөгийг бүрдүүлж, 178.6 тэрбум төгрөгөөр тасрахад импортын гаалийн албан татварын чөлөөлөлт өмнөх оноос 132.4 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.
- 2.2.45 Бусад татвар (Төлбөр, хураамж)-ийн орлого 4,381.9 тэрбум төгрөг төвлөрч, 128.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь АМНАТ 854.6 тэрбум төгрөг, бусад татвар 62.5 тэрбум төгрөг, агаарын бохирдлын төлбөр болон бусад татвар хураамж 19.4 тэрбум төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 16.8 тэрбум төгрөг, рашаан ус ашигласны төлбөр 16.5 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэнтэй холбоотой байна.

- Гаалийн ерөнхий газар нь хойшлуулсан гаалийн албан татвар болон НӨАТ-ын хугацаа хэтэрсэн 36.0 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулаагүй;
- Гаалийн ерөнхий газрын харьяа орон нутгийн гаалийн газруудад бүртгэлтэй түр горимын зориулалттай нийт нэр бүхий 30 хувь хүн, хуулийн этгээдээс арилжааны банканд 2018 оноос өмнө байршуулсан 0.7 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Бүрдүүлэлтийн дараах хяналт шалгалтын газраас 2010-2023 онуудад хийсэн хяналт шалгалтаар илэрсэн 8.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, торгуулийн авлагыг харилцагч бүрээр тооцоо үүсгэн бүртгэлд тусгаагүй, үүнээс 8 иргэн, хуулийн этгээдийн хаяг байршил тодорхойгүйгээс 0.1 тэрбум төгрөгийн авлага найдваргүй болох эрсдэл үүссэн.

2024.05.20  
 С.Сүхбаатар  
 Т.Сүхбаатар

2.2.46 АМНАТ-ийн орлогод 3,658.2 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 30.5 хувиар давж биелсэн нь ашигт малтмалын экспортын биет хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.2.47 Бусад татварын орлогод 133.1 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 88.5 хувиар давсан нь экспортын хэмжээ нэмэгдсэн, нөхөн бүрдүүлэлтийн дараах хяналт шалгалтын орлогын гүйцэтгэл өмнөх оноос 11.5 хувиар өссөн зэрэг нь голлон нөлөөлжээ.

Орон нутгийн төсвийн бусад татварын орлогод нийслэл хотын албан татвар 2.9 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь өмнөх оны авлагыг барагдуулсан, өргөн хэрэглээний барааны үнэ өссөн зэргээс шалтгаалсан байна.

2.2.48 **Татварын зарлага** тайлант оны татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 1,053.4 тэрбум төгрөгт хүрч татварын нийт орлогын 4.9 хувьтай тэнцэж байна.

2.2.49 ААНОАТ-ын тухай хуулийн дагуу чөлөөлсөн орлого 264.6 тэрбум төгрөг, хөнгөлөлт 160.0 тэрбум төгрөг, ХХОАТ-ын тухай хуулиар чөлөөлсөн орлого 10.0 тэрбум төгрөг, хөнгөлөлт 194.8 тэрбум төгрөг, НӨАТ-ын тухай хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлт 281.1 тэрбум төгрөгт тус тус хүрчээ.

2.2.50 Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиар бүх төрлийн хүнсний будаа, ургамлын тос, үр тариа, тэжээл болон бусад барааны 24.2 тэрбум төгрөг, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар 14.5 тэрбум төгрөгийн татварыг тус тус чөлөөлөн, импортын бараанд 104.2 тэрбум төгрөгийн НӨАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн байна.

2.2.51 Хуулийн шинэчлэлээр татвар төлөгчийн хуулиар эдлэх эрхийг нэмэгдүүлж, төлсөн татвараас буцаан авах боломжийг нэмэгдүүлснээр буцаан олголт өмнөх оноос 19.6 хувиар өсөж 457.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

**Татварын бус орлого тасарсан нь гадаад тусламжаар хэрэгжих зарим төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, навигац, газрын тосны бүтээгдэхүүний орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс шалтгаалжээ**

2.2.52 Татварын бус орлогод 2,237.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,810.7 тэрбум төгрөг бүрдүүлж 19.1 хувиар тасарсан байна.

Хүснэгт 9. Монгол Улсын 2023 оны татварын бус орлого /тэрбум төгрөг/

д/д	Үзүүлэлт	2022 оны гүйц	2023 он			
			Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>1,667.9</b>	<b>2,237.2</b>	<b>1,810.7</b>	<b>(426.5)</b>	<b>80.9</b>
2.1	Нийтлэг татварын бус орлого	1,364.2	1,618.7	1,451.7	(167.0)	89.7
2.2	Хөрөнгийн орлого	4.1	19.4	8.2	(11.2)	42.3
2.3	Тусламжийн орлого	299.6	599.1	350.8	(248.3)	58.6
<b>Төсвийн бүрэлдэхүүнээр:</b>						
1	Нэгдсэн төсвийн орлого	1,667.9	2,237.2	1,810.7	(426.5)	80.9
2	Улсын төсвийн татварын бус орлого	1,317.3	2,725.6	2,370.2	(355.4)	87.0
3	Орон нутгийн төсвийн татварын бус орлого	660.0	1,157.0	1,073.0	(84.0)	92.7
4	Нийгмийн даатгалын сангийн орлого	843.9	774.4	764.3	(10.1)	98.7
5	Ирээдүйн өв сан	485.8				

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт



2.2.53 Улсын төсвийн татварын бус орлого 355.4 тэрбум төгрөг, орон нутгийн татварын бус орлого 84.0 тэрбум төгрөгөөр тасарсан нь гадаад тусламжаар хэрэгжих зарим төсөл арга, хэмжээ бүрэн хэрэгжээгүй, навигацийн орлогын төлөвлөлтөд олон улсын нөхцөл байдлыг тооцоолоогүй, газрын тосны орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүйтэй холбоотой байна.

2.2.54 **Нийтлэг татварын бус орлого** 1,618.7 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 1,451.7 тэрбум төгрөгийг бүрдүүлж, 167.0 тэрбум төгрөгөөр тасарсан нь навигацийн орлого 145.0 тэрбум төгрөг, газрын тосны орлого 120.8 тэрбум төгрөгөөр, хувьцааны ногдол ашиг 7.1 тэрбум төгрөг, бусад орлого 7.1 тэрбум төгрөг, хүү торгуулийн орлого 6.6 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн зэрэг нь голлон нөлөөлжээ.

2.2.55 Навигацийн орлого 145.0 тэрбум төгрөг буюу 96.7 хувиар тасарсан нь ачаа тээврийн эргэлт 42.9 хувь, буулт, хөөрөлт 75.8 хувийн гүйцэтгэлтэй, төлөвлөлтөд олон улсын нөхцөл байдлын нөлөөллийг тооцоолж батлуулаагүй, газрын тосны орлого 120.8 тэрбум төгрөг буюу 28.4 хувиар тасарсан нь нэг баррель газрын тосны үнэ төлөвлөснөөс 6.0 хувиар буурсан, төсвийг үндэслэлгүй төлөвлөж баталснаас шалтгаалсан байна.

2.2.56 Хувьцааны ногдол ашгийн орлого 182.3 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 7.1 тэрбум төгрөгөөр тасарсан нь эрх бүхий байгууллагаас тогтоосон орлогыг дутуу төвлөрүүлсэн, ногдуулалт хийх зарим зохицуулалт тодорхойгүй зэргээс шалтгаалжээ. Тухайлбал,

- Төрийн банк ХК-ийн 2022 оны цэвэр ашигт ногдуулсан 48.1 тэрбум төгрөгийн ногдол ашгаас 24.4 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлж, ногдуулалтад үүссэн маргаантай асуудлыг шийдвэрлээгүй байна. ТӨБЗГ-аас хуулийн дагуу ТЕЗ-аас санал авч төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг тогтоосон ч Төрийн банк ХК-аас Санхүү төсвийн асуудал харууцсан төрийн захиргааны төв байгууллагын хувьцаа эзэмшлийн хувиар ногдол ашиг хуваарилж, төвлөрүүлсэн;
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдээс төрд ногдох хувьцааны ногдол ашиг хуваарилах зохицуулалт тодорхой бус байгаагаас цэвэр ашигтай ажилласан хуулийн этгээдүүдэд ногдол ашгийг жигд хуваарилаагүй байна. Тухайлбал, 2022 оны жилийн эцэст 40 хуулийн этгээд 305.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байхад ТЕЗ нараас санал авч 20 хуулийн этгээдээс ногдол ашгийн хуваарилалтаар 59.7 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилж улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтоосон;
- Эрдэнэс Монгол ХХК нь Засгийн газрын 2023 оны 108 дугаар тогтоолоор баталсан компанийн дүрмийн дагуу өөрийн нэгдлийн 5 компаниас борлуулалтын орлогын 2 хүртэл хувиар тооцон 170.2 тэрбум төгрөгийн менежментийн төлбөр авсан нь зарцуулах зорилго үр ашиг тодорхойгүй, төлбөрийн хувь хэмжээний тооцоолол хийгээгүй;
- ТӨБЗГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар Цемент шохой ТӨХК-аас улсын төсөвт төвлөрүүлээгүй 5.8 тэрбум төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт нөхөн төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон;

2.2.57 Нийгмийн шинж чанартай төслүүдэд Эрдэнэс Тавантолгой ХК 47.8 тэрбум төгрөг төлөвлөснөөс 15.7 тэрбум төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 71.3 тэрбум төгрөг төлөвлөснөөс 31.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

2.2.58 Төсөвт байгууллагын өөрийн орлого 474.1 тэрбум төгрөг буюу 132.8 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь 250 байгууллага батлагдсан төлөвлөгөөг 80.5 тэрбум төгрөгөөр давуулсан, орлогын төлөвлөгөөгүй 115 байгууллага 21.7 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлсэн зэрэгтэй холбоотой байна.

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар баталсан төсөвт байгууллагын өөрийн орлогыг 67 байгууллага 8.9 тэрбум төгрөг;
- Нийслэлийн нийтийн тээврийн газар төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 2.9 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдүүлсэн;

2.2.59 **Хөрөнгийн орлого** 8.2 тэрбум төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 42.2 хувь буюу 11.2 тэрбум төгрөгөөр тасарсан нь Орхон аймагт шинээр баригдсан орон сууц, автомашины зогсоол бүрэн борлуулагдаагүйтэй холбоотой байна.

2.2.60 **Тусламжийн орлого** 599.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 350.8 тэрбум төгрөг төвлөрч 248.3 тэрбум төгрөгөөр дутуу биелэхэд улсын төсвийн тусламжийн орлого 236.9 тэрбум төгрөг, орон нутгийн тусламжийн орлого 11.4 тэрбум төгрөгөөр тасарсан нь нөлөөлжээ.

- Хэрэгжих эсэх нь тодорхойгүй нэр бүхий 3 төсөл арга хэмжээнд 19.0 тэрбум төгрөг төлөвлөсөн;
- Төлөвлөгөөнд тусгасан нэр бүхий 2 төсөл арга хэмжээнд 3.3 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан боловч төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаагүй;
- Засгийн газар, Европын холбооны хэлэлцээрийн хүрээнд 2020 оноос эхлэн хэрэгжиж буй 1 төслийн 23.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төлөвлөгөөнд тусгаагүй.

2.2.61 **Төсөв хоорондын шилжүүлэг** Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар улсын төсвөөс орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгийг 257.3 тэрбум төгрөг, ОНХС-д олгох шилжүүлгийг 369.9 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,016.0 тэрбум төгрөгөөр баталсан байна.

2.2.62 Гүйцэтгэлээр ОНХС-д 362.6 тэрбум төгрөг, санхүүгийн дэмжлэгт 257.3 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт 1,010.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлжээ.

2.2.63 Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг 5.8 тэрбум төгрөгөөр дутуу байгаа нь Дорноговь аймаг 5.5 тэрбум төгрөг, Сэлэнгэ аймаг 0.3 тэрбум төгрөгөөр тасалснаас шалтгаалсан байна.

2.2.64 Дорноговь аймаг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 4 төсөл арга хэмжээний 3.8 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиглуулах асуудлыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд шинээр газар олгох үйл ажиллагааг түр зогсоосон зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

2.2.65 **Өмч хувьчлалын орлого** 3.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1.6 тэрбум төгрөг төвлөрч 2.3 тэрбум төгрөгөөр тасарсан нь Нийслэл өмчийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулаагүйгээс шалтгаалжээ. Тухайлбал,

- Нийслэлийн СХД дэх ахуйн үйлчилгээний барилга, Мал эмнэлгийн лаборатори, Монгол шуудангийн 21 дүгээр салбар зэрэг барилга, байгууламжийг худалдан борлуулахаар тооцон өмч хувьчлалын төсвийг баталсан.
- Нийслэл өмч хувьчлалын орлогыг татварын бус орлогын дүнд оруулж төсөв баталсан.
- Нийслэлийн ИТХ-ын 2023 оны 115 дугаар тогтоолоор өмч хувьчлалын орлогыг 2.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн боловч нийслэлийн өмчийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулаагүйгээс өмч хувьчлалын орлого тасарсан байна.

Сүхбаатар / 2024.05.20

**БҮЛЭГ 3. ТӨСВИЙН НИЙТ ЗАРДАЛД ЭЗЛЭХ УРСГАЛ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН ДУНДЖААР 76.9 ХУВЬТАЙ БАЙГАА НЬ ТӨСВИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ ДУНД БОЛОН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГОТОЙ БҮРЭН УЯЛДАХГҮЙ БАЙНА**

**3.1 Төсвийн зардлын чиглэлээр баримталсан бодлогыг үе шаттай хэрэгжүүлсэн боловч үр дүнг тайлагнаагүй байна**

3.1.1 Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд төсвийн зарлагын чиглэлээр 5 бодлогыг хэрэгжүүлэхээр төсвийн баримт бичгийг боловсруулан, УИХ-д өргөн барьж баталжээ.

3.1.2 “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор төрийн албан хаагчдын цалин хөлсний системийг бүтээмж, ажлын үр дүнтэй уялдуулан шинэчилж, цалин хөлсийг нэмэгдүүлэх” бодлогын хүрээнд цалингийн тогтолцоог адил үнэлэмж бүхий нэг шатлалтай болгосон, орон нутгийн нэмэгдэл олгох эрх зүйн орчин бүрдсэн байна.

3.1.3 Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа зарим салбаруудад хүрэх үр дүнгийн гүйцэтгэл, үйлчилгээний чанарт нь үндэслэн санхүүжилт хуваарилах тогтолцоог үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилтын хүрээнд эрүүл мэнд, боловсролын салбарт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог үргэлжлүүлж, соёлын салбарт эхлүүлсэн байна.

3.1.4 Хүүхдийн мөнгийг зорилтот бүлэгт чиглүүлэх зорилтын хүрээнд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 91.0 хувьд сар бүр 100.0 мянган төгрөгийг үргэлжлүүлэн олгохоор баталсныг төсвийн тодотголоор бүх хүүхдэд олгохоор шийдвэрлэсэн байна.

3.1.5 “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Засгийн газрын 2022 оны 341, 342, 343 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хороо, Боомтын сэргэлтийн Үндэсний хороо, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хороог тус тус шинээр байгуулж, тайлант онд нийт зарлага ба цэвэр зээлийг 457.3 тэрбум төгрөгөөр төлөвлөж 78.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.1.6 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх бодлогын хүрээнд төсвийг төлөвлөхдөө хуульд заасан хязгаарлалтыг баримталсан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

*Төсвийн орлогын өсөлттэй уялдуулан зарлага жил бүр тэлж байгаад анхаарч, төсвийн зарлагын өсөлтийг зохистой түвшинд барих шаардлагатай байна*

3.1.7 Нийт зарлага ба цэвэр зээлийг 24,211.0 тэрбум төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 22,509.0 тэрбум төгрөгийг зарцуулсан нь ДНБ-ий 32.7 хувьтай тэнцэж байна.

3.1.8 “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хууль”-д нэгдсэн төсвийн нийт зарлагыг анх 19,219.1 тэрбум төгрөгөөр баталсныг хуульд 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулан 3,152.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 22,371.4 тэрбум төгрөгөөр баталсан байна.

3.1.9 Засгийн газрын “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн хязгаарыг батлах тухай” 2022 оны 258 дугаар тогтоолоор улсын төсвийн хязгаарыг 12,366.7 тэрбум төгрөг, НДС-ийн төсвийн хязгаарыг 3,682.7 тэрбум төгрөг, ЭМДС-ийн төсвийн хязгаарыг 1,321.5 тэрбум төгрөгөөр баталж, Сангийн яамнаас орон нутгийн төсвийн суурь зарлагыг 1,516.0 тэрбум төгрөгөөр хянасан байна.

3.1.10 Засгийн газраас УИХ-д өргөн барьсан 2023 оны төсвийн төсөлд ТЕЗ-дын төсвийн зарлагын хязгаараас улсын төсвийн зарлагыг 3,130.1 тэрбум төгрөг, ЭМДС-ийн төсвийг 74.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1<sup>17</sup>-д заасантай нийцэхгүй байна.

3.1.11 Нийт зарлага ба цэвэр зээлийг анх 20,475.3 тэрбум төгрөгөөр баталсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 2,315.7 тэрбум төгрөг буюу 12.8 хувиар нэмэгдсэн байна.

<sup>17</sup> Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана: ... 27.1.4. жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх...

3.1.12 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны нийт зарлага ба цэвэр зээлийг 20,475.3 тэрбум төгрөгөөр баталж, төсвийн жилд 1 удаа тодотгол хийж, 1,896.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 22,371.4 тэрбум төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 10. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөлт /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Төсвийн хязгаар	УИХ-д өргөн барьсан	УИХ-аас баталсан	УИХ-аас тодотгосон	Зөрүү	Хувь
А	1	2	3	4	5=2-1	6=2/1
<b>НЭГДСЭН ТӨСӨВ*</b>	-	<b>20,475.3</b>	<b>20,475.3</b>	<b>22,371.4</b>	-	-
Улсын төсөв	12,366.7	15,496.8	15,480.8	16,949.9	3,130.1	125.3
Орон нутгийн төсөв	1,516.0	3,064.5	3,162.3	3,530.3	1,548.5	202.1
НДС-ийн төсөв	3,682.7	3,679.7	3,679.7	4,084.3	(3.1)	99.9
ЭМДС-ийн төсөв	1,321.5	1,396.4	1,396.4	1,518.5	74.8	105.7

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

/\*цэвэр дүнгээр/

3.1.13 Орон нутгийн ИТХ бүрэн эрхийн хүрээнд Сангийн яамнаас хянасан төсвийн суурь зарлагыг 1,839.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

3.1.14 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийг 24,211.0 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 22,509.0 тэрбум төгрөгийг зарцуулж, 93.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.1.15 Нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл өмнөх оноос 4,349.4 тэрбум төгрөгөөр өссөн нь урсгал зарлага 2,862.1 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 1,384.8 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардал 102.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 11. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022 оны гүйц	2023 он				Өмнөх оноос зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>18,159.6</b>	<b>24,211.0</b>	<b>22,509.0</b>	<b>1,702.0</b>	<b>93.0</b>	<b>4,349.4</b>
<b>Урсгал зарлага</b>	<b>14,229.3</b>	<b>18,057.6</b>	<b>17,091.4</b>	<b>966.2</b>	<b>94.6</b>	<b>2,862.1</b>
Бараа, үйлчилгээний зардал	3,806.0	5,471.5	5,085.4	386.1	92.9	1,279.4
Хүү	797.8	1,154.5	1,150.0	4.5	99.6	352.2
Татаас ба урсгал шилжүүлэг	9,625.5	11,431.6	10,856.0	575.6	95.0	1,230.5
<b>Хөрөнгийн зардал</b>	<b>3,803.4</b>	<b>6,216.8</b>	<b>5,188.2</b>	<b>1,028.6</b>	<b>83.5</b>	<b>1,384.8</b>
<b>Эргэж төлөгдөх цэвэр зээл</b>	<b>126.9</b>	<b>(63.4)</b>	<b>229.4</b>	<b>(292.8)</b>	<b>(49.8)</b>	<b>102.5</b>
<b>Төсвийн бүрэлдэхүүнээр:</b>						
Улсын төсөв	11,359.9	16,949.9	16,079.7	870.2	94.9	4,719.8
Орон нутгийн төсөв	2,919.0	5,240.1	4,336.3	903.8	82.8	1,417.3
НДС-ийн төсөв	3,413.9	4,084.3	4,034.9	49.4	98.8	621.0
ЭМДС-ийн төсөв	1,472.8	1,518.4	1,598.0	(79.6)	105.2	125.2
Ирээдүйн өв сан	1,488.1					(1,488.1)

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан


/\*цэвэр дүнгээр/

3.1.16 Нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэлийн 60.5 хувийг улсын, 14.5 хувийг орон нутгийн, 7.1 хувийг ЭМДС-ийн, 17.9 хувийг НДС-ийн төсөв тус тус эзэлж байна.

3.1.17 Нийт зарлага ба цэвэр зээл төлөвлөснөөс 1,702.0 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь урсгал зарлагыг 966.2 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлыг 1,028.6 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, эргэж төлөгдөх цэвэр зээл 292.8 тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна.

3.1.18 Төсвийн бүрэлдэхүүн хэсгээр авч үзэхэд улсын төсвийг 870.2 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийг 903.8 тэрбум төгрөг, НДС-ийн төсвийг 49.4 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, ЭМДС-ийн төсвийн эргэн төлөгдөх цэвэр зээл 79.6 тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна.

Дүрслэл 3. Нийт зарлага ба цэвэр зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/




3.1.19 Нийт зарлага ба цэвэр зээлийн зардлын гүйцэтгэлийн 75.9 хувийг урсгал зарлага, 23.1 хувийг хөрөнгийн зардал, 1.0 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардал тус тус эзэлж байна.

3.1.20 Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өмнөх оноос 24.0 хувиар өссөн,

сүүлийн 5 жилийн дунджаар ДНБ-д эзлэх төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 34.5 хувьтай байгаа нь хөгжиж буй орнуудын үзүүлэлттэй харьцуулахад өндөр байна.

Дүрслэл 5. Төсвийн зарлагын өсөлт, ДНБ-д эзлэх хувь /2019-2023 он/



3.1.21 Засгийн газраас экспортыг эрчимжүүлж, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлснээр уул уурхайн салбарын голлох бүтээгдэхүүн нүүрс, зэсийн баяжмалын экспортын орлогын өсөлттэй уялдуулан нийт зарлага ба цэвэр

зээлийн зардал жил бүр хурдацтай тэлж байгааг цаашид анхаарч, төсвийн зарлагын өсөлтийг зохистой түвшинд барих шаардлагатай байна.

3.1.22 Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийг 16,949.9 тэрбум төгрөгөөр баталж өмнөх оны гүйцэтгэлээс 49.2 хувиар буюу 5,590.0 тэрбум төгрөгөөр өссөн нь урсгал зарлагыг 3,477.3 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлыг 1,187.7 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардлыг 54.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.1.23 Улсын төсвийн зарлага 16,079.7 тэрбум төгрөг буюу 94.9 хувийн гүйцэтгэлтэй гарч, төлөвлөснөөс 870.2 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

3.1.24 Тайлант онд УТЕЗ-дын 107 хөтөлбөрийн 242 арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсвийн 20.6 хувийг ерөнхий төлөвлөлт, санхүү төсвийн харилцаанд, 18.9 хувийг боловсрол, шинжлэх ухааны салбарт, 18.2 хувийг нийгмийн хамгааллын салбарт, 8.3 хувийг эрүүл мэндийн хөтөлбөрт, 7.3 хувийг эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдалд, 4.5 хувийг зам тээврийн салбарт, 22.2 хувийг бусад салбарын хөтөлбөрт тус тус зарцуулсан байна.

3.1.25 Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн зардал 4,336.3 тэрбум төгрөг буюу 82.8 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь урсгал зарлага 277.4 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 599.1 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардал 27.3 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

3.1.26 ОНТЕЗ-дын 77 хөтөлбөрийн 151 арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсвийн 54.8 хувийг ...гүйцэтгэх засаглалын удирдлагад, 17.6 хувийг засаг захиргааны түвшин хоорондын шилжүүлэгт, 6.3 хувийг зам тээврийн салбарт, 6.1 хувийг барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн салбарт, 4.9 хувийг боловсрол, шинжлэх ухааны салбарт, 10.3 хувийг бусад салбарын хөтөлбөрт тус тус зарцуулсан байна.

3.1.27 ЭМДС-ийн нийт зарлага ба цэвэр зээлийн зардлыг 1,518.4 тэрбум төгрөгөөр төлөвлөж, 1,598.0 тэрбум төгрөг буюу 105.2 хувийн гүйцэтгэлтэй, өмнөх оноос 8.3 хувь буюу 125.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.1.28 НДС-ийн нийт зарлага ба цэвэр зээлийн зардал 4,084.3 тэрбум төгрөгөөр буюу тэтгэвэр тэтгэмжийн зардалд 4,106.7 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 46.0 тэрбум төгрөгийг зарцуулж, эргэн төлөгдөх цэвэр зээлээс 68.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр баталжээ. Сангийн зардлын нийт гүйцэтгэл 4,034.9 тэрбум төгрөг буюу 98.8 хувьтай байна.

**Нийт зарлага ба цэвэр зээлийн 75.9 хувийг урсгал зарлага эзэлж байгаа нь нийгмийн халамж, цалин хөлсний шинэчлэл, хүрэх үр дүнгийн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээс шалтгаалжээ**

3.1.29 Нийт урсгал зарлагыг 18,057.6 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 17,091.4 тэрбум төгрөг зарцуулж, 94.6 хувийн гүйцэтгэлтэй, өмнөх оноос 2,862.1 тэрбум төгрөгөөр өссөн нь бараа, үйлчилгээний зардал 33.6 хувиар, татаас ба урсгал шилжүүлгийн зардал 12.8 хувиар нэмэгдсэнээс тус тус шалтгаалжээ.

Хүснэгт 12. Урсгал зардлын эдийн засгийн ангилал

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022 оны гүйц	2023 он				Өмнөх оны зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
А	1	2	3	4=2-3	5=3/2	6=3-1
<b>Урсгал зарлага</b>	<b>14,229.3</b>	<b>18,057.6</b>	<b>17,091.4</b>	<b>966.2</b>	<b>94.6</b>	<b>2,862.1</b>
Бараа, үйлчилгээний зардал	3,806.0	5,471.5	5,085.4	386.1	92.9	1,279.4
Хүү	797.8	1,154.5	1,150.0	4.5	99.6	352.2
Татаас	537.0	797.8	579.7	218.1	72.7	42.7
Урсгал шилжүүлэг	9,088.5	10,633.8	10,276.3	357.5	96.6	1,187.8
Нийт зарлага ба цэвэр зээлд эзлэх хувь	78.4	74.6	75.9		-	(2.5)
<b>Төсвийн бүрэлдэхүүнээр:</b>						
Улсын төсөв	8,483.3	12,574.1	11,960.5	613.6	95.1	3,477.2
Орон нутгийн төсөв	1,856.1	3,309.2	3,031.8	277.4	91.6	1,175.7
НДС-ийн төсөв	3,415.6	4,152.7	4,036.1	116.6	97.2	620.5
ЭМДС-ийн төсөв	1,480.1	1,603.4	1,602.8	0.6	100.0	122.7
Ирээдүйн өв сан	1,488.1	-			-	(1,488.1)

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/цэвэр дүнгээр /

3.1.30 Нийт урсгал зарлагын гүйцэтгэлийн 29.8 хувийг бараа үйлчилгээний зардал, 6.7 хувийг хүүгийн зардал, 3.4 хувийг татаас санхүүжилт, 60.1 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

3.1.31 Урсгал зарлагын гүйцэтгэлийг 2019 онтой харьцуулахад 8,864.8 тэрбум төгрөгөөр буюу 2.1 дахин, сүүлийн 5 жилийн дунджаар 18.6 хувийн өсөлттэй байна.

**Төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэвэр, зарим тэтгэмжийг нэмэгдүүлсэн нь бараа, үйлчилгээний зардал өмнөх оноос 1,279.4 тэрбум төгрөгөөр өсөхөд голлон нөлөөлсөн байна**

3.1.32 Бараа, үйлчилгээний зардал 5,085.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1,279.4 тэрбум төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин хөлсний тогтолцоонд шинэчлэл хийснээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 39.7 хувиар, зарим төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалтын шинэчлэлтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлснээр 28.9 хувиар нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.1.33 Бараа, үйлчилгээний зардлын 45.8 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал, 54.2 хувийг бараа үйлчилгээний бусад зардал эзэлж байна.

3.1.34 УИХ-ын "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай" 2022 оны 23 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 489, 491, 2023 оны 241 дүгээр тогтоолоор цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 661.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.1.35 Төрийн албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээг төрийн захиргааны албан хаагчид 39.3 хувь, төрийн тусгай албан хаагчид 39.4 хувь, төрийн үйлчилгээний албан хаагчид

32.7 хувь, төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчид 69.2 хувиар тус тус нэмэгдүүлж, олон сүлжээ шатлал бүхий харилцан адилгүй, тэгш бус үнэлэмжтэй цалингийн тогтолцоог адил үнэлэмж бүхий нэг шатлалтай болгосон байна.

Дүрслэл 7. Шинэчлэн баталсан цалингийн доод хэмжээ



3.1.36 Төрийн албан хаагчийн орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, хүн амын төвлөрлийг сааруулах зорилгын хүрээнд орон нутгийн нэмэгдэл олгох хувь хэмжээг улсын төсвөөс 20.0 хувь, орон нутгийн төсвөөс 80.0 хүртэл хувиар олгохоор шийдвэрлэж 35.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

3.1.37 Засгийн газрын 2023 оны 52 дугаар хуралдааны тэмдэглэлээр төсвийн байгууллагын ажилтныг

урамшуулах асуудлыг хэлэлцэн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагаас бусад байгууллагын цалингийн сангийн хэмнэлтээс ажлын үр дүн, бүтээмжид үндэслэн нийт 23,602 албан хаагчид 25.7 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон байна.

3.1.38 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардлаас 69 төсөл хөтөлбөрийн 184.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь бараа үйлчилгээний зардлыг 5.1 хувиар өсгөсөн байна.

3.1.39 Албан тушаалтны буруутай шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан 146 ажилтанд шүүхийн шийдвэрээр 1.6 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосныг Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1<sup>18</sup>-д заасны дагуу буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна.

3.1.40 Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтөөр "Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих" чиг үүргийг Төрийн албаны зөвлөлд шилжүүлснээр, тайлант онд 85 албан тушаалтны буруутай шийдвэрээр төрийн албанаас үндэслэлгүй халагдсан 98 албан хаагчийн 1.0 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх шүүхийн шийдвэрийн гарснаас 0.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.1.41 Батлагдсан төсвөөс зардлын эдийн засгийн ангилал зөрчин нийт 23.3 тэрбум төгрөгийн биет болон биет бус хөрөнгө бэлтгэсэн байна. Тухайлбал,

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 10.2 тэрбум төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардлаас 10.1 тэрбум төгрөг;
- Нормативт зардлаас 2.8 тэрбум төгрөг;
- Хангамж, бараа материалын зардлаас 0.2 тэрбум төгрөг.

3.1.42 Зарим ТЕЗ-дын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтай холбоотой дараах зөрчлүүд байна. Тухайлбал:

- Зардлын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой 1.2 тэрбум төгрөг /ХЗДХС 0.4 тэрбум төгрөг, БОАЖС 0.02 тэрбум төгрөг, ХНХС 0.4 тэрбум төгрөг, Баян-Өлгий аймаг 0.06 тэрбум төгрөг, Баянхонгор аймаг 0.2 тэрбум төгрөг, Өвөрхангай аймаг 0.06 тэрбум төгрөг/
- Эдийн засгийн ангилал зөрчин зориулалт бусаар зарцуулсан 1.5 тэрбум төгрөг /БОАЖС 0.07 тэрбум төгрөг, ГХС 0.03 тэрбум төгрөг, ЦХХХС 0.1 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.05 тэрбум төгрөг, ХНХС 0.9 тэрбум төгрөг, Архангай аймаг 0.3 тэрбум төгрөг, Баянхонгор аймаг 0.01 тэрбум төгрөг, Дорноговь аймаг 0.05 тэрбум төгрөг, Дундговь аймаг 0.05 тэрбум төгрөг /;

Нэгдсэн төсвийн нийт хүүгийн зардал ДНБ-ий 1.7 хувь, нийт орлогын 4.9 хувийг тус тус эзэлж байна

3.1.43 Хүүгийн зардлыг 1,154.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 1,150.0 тэрбум төгрөгийг зарцуулж, 99.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

<sup>18</sup> Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.

Хүснэгт 13. Хүүгийн зардлын эдийн засгийн ангилал

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022 оны гүйц	2023 он				Өмнөх оны зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
A	1	2	3	4=2-3	5=3/2	6=3-1
<b>Хүүгийн зардал</b>	<b>797.8</b>	<b>1,154.5</b>	<b>1,150.0</b>	<b>4.5</b>	<b>99.6</b>	<b>352.2</b>
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	693.7	1,055.8	1,054.5	1.3	99.9	360.8
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	104.1	98.7	95.5	3.2	96.8	(8.6)
<b>Төсвийн бүрэлдэхүүнээр:</b>						
Улсын төсөв	808.0	1,093.5	1,092.6	0.9	99.9	284.6
Орон нутгийн төсөв	24.8	61.0	57.4	3.6	94.1	32.6


Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1.44 Нийт хүүгийн зардлын 91.7 хувийг гадаад зээлийн хүүгийн үйлчилгээний төлбөр, 8.3 хувийг дотоод зээлийн хүүгийн үйлчилгээний төлбөр эзэлж байна.

3.1.45 Улсын төсвөөс гадаад үнэт цаасны хүүгийн үйлчилгээний төлбөрт 553.0 тэрбум төгрөг, Засгийн газрын зээлийн хүүгийн үйлчилгээний төлбөрт 459.9 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасны хүүгийн үйлчилгээний төлбөрт 79.7 тэрбум төгрөгийг төлжээ.

3.1.46 Орон нутгийн төсвөөс гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт 41.5 тэрбум төгрөг, дотоод зээлийн үйлчилгээний төлбөрт 15.9 тэрбум төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

Хүснэгт 3. Хүүгийн зардал /тэрбум төгрөг/



3.1.47 Зээлийн үйлчилгээний төлбөр 1,150.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 44.1 хувиар өссөн нь Засгийн газрын гадаад зээлийн хүүгийн үйлчилгээний төлбөр 154.0 хувиар, гадаад үнэт цаасны хүүгийн үйлчилгээний төлбөр 11.4 хувиар өссөнтэй холбоотой байна.

Татаас ба урсгал шилжүүлгийн зардал өмнөх оноос 45.5 хувиар өссөн нь үр дүнгийн гүйцэтгэлд суурилсан санхүүжилт болон хүүхдийн мөнгөн тэтгэмжийг урсгал шилжүүлгийн зардлаар төлөвлөж, зарцуулсантай холбоотой байна

3.1.48 Татаас ба урсгал шилжүүлгийн зардлыг 11,431.6 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 10,856.0 тэрбум төгрөгийг зарцуулж, 95.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 14. Татаас ба урсгал шилжүүлэг

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022 оны гүйц	2023 он				Өмнөх оны зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
A	1	2	3	4=2-3	5=3/2	6=3-1
<b>Татаас ба урсгал шилжүүлэг</b>	<b>9,625.5</b>	<b>11,431.6</b>	<b>10,856.0</b>	<b>575.6</b>	<b>95.0</b>	<b>1,230.5</b>
Татаас	537.0	797.8	579.7	218.1	72.7	42.7
Урсгал шилжүүлэг	9,088.5	10,633.8	10,276.3	357.5	96.6	1,187.8
<b>Төсвийн бүрэлдэхүүнээр:</b>						
Улсын төсөв	4,986.5	7,659.4	7,253.5	405.9	94.7	2,267.0
Орон нутгийн төсөв	650.1	1,478.1	1,394.2	83.9	94.3	744.1
НДС-ийн төсөв	3,385.6	4,106.7	3,994.0	112.7	97.3	608.4
ЭМДС-ийн төсөв	1,427.0	1,553.2	1,552.8	0.4	100.0	125.8

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1.49 Татаас ба урсгал шилжүүлгийн зардал өмнөх оноос 1,230.5 тэрбум төгрөгөөр өссөн нь Нийгмийн халамжийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Монгол Улсын 0-18 хүртэлх насны



иргэн бүрд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг урсгал шилжүүлгийн зардлаас санхүүжүүлэн 1,520.1 тэрбум төгрөг олгосноос шалтгаалжээ.

3.1.50 Улсын төсвөөс НДС-д 764.4 тэрбум төгрөг, цахилгаан, дулаан, эрчим хүчний алдагдлыг нөхөх, шөнийн тарифын хөнгөлөлтөд 72.5 тэрбум төгрөг, хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн урамшуулал, хүүгийн хөнгөлөлтөд 117.2 тэрбум төгрөг, бусад салбарын татаас санхүүжилтэд 79.0 тэрбум төгрөг, нийт 1,033.1 тэрбум төгрөгийн татаас олгосон байна.

3.1.51 Нийслэлийн төсвөөс нийтийн тээврийн алдагдлыг бууруулахад 165.6 тэрбум төгрөг, нийтийн тээврээр хөнгөлөлттэй зорчих иргэдийн төлбөрт 18.3 тэрбум төгрөг, дулааны цахилгаан станцуудын алдагдлыг бууруулахад 4.5 тэрбум төгрөг, зээлийн хүүгийн татаас 12.4 тэрбум төгрөг, бусад татаас 20.1 тэрбум төгрөг, нийт 220.9 тэрбум төгрөгийн татаас олгосон байна.

3.1.52 Нийт урсгал шилжүүлгийн зардал 10,276.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 13.1 хувиар өссөн байна. Урсгал шилжүүлгийн 38.9 хувийг нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж, 20.7 хувийг нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, 35.0 хувийг Засгийн газрын урсгал шилжүүлэг, 5.4 хувийг бусад урсгал шилжүүлэг эзэлж байна.

3.1.53 Улсын төсвийн урсгал шилжүүлгийн зардлын гүйцэтгэл 6,220.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 38.3 хувиар өссөн нь хүүхдийн мөнгөн тэтгэмжийг Ирээдүйн өв сангаас санхүүжүүлж байсныг холбогдох хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлсэн нь голлон нөлөөлжээ.

3.1.54 Орон нутгийн төсвийн урсгал шилжүүлгийн зардлын гүйцэтгэл 1,173.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 695.2 тэрбум төгрөгөөр өсөхөд Засгийн газрын дотоод шилжүүлэг голлон нөлөөлсөн байна.


3.1.55 Засаг даргын нөөц хөрөнгөөс бараа материал, үндсэн хөрөнгө бэлтгэсэн, суудлын автомашинд засвар үйлчилгээ хийж, сэлбэг хэрэгсэл худалдан авсан, тэмцээн уралдаан болон үйл ажиллагааны тогтмол зардалд зарцуулсан зэрэг 1.2 тэрбум төгрөгийг зориулалт бусаар зарцуулжээ.

**Нийгмийн халамжийн сангийн зардлын дийлэнх хувийг амьжиргаа харгалзахгүй олгодог мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшууллын шинжтэй зардал эзэлж байна**

3.1.56 Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан иргэний тоо буурахгүй байгаа нь хөдөлмөр эрхлэх чадвартай, орлого багатай иргэдийг халамжаар бус ажил эрхлэлтээр дэмжихэд чиглэсэн "Халамжаас-хөдөлмөрт" шилжих зорилттой нийцэхгүй байна.

3.1.57 Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардлын гүйцэтгэл 2,125.8 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт урсгал зардлын 12.4 хувь, ДНБ-ий 3.1 хувьтай тэнцэж байна.

**Дүрслэл 8. Улсын төсвийн урсгал зардал болон нийгмийн халамжийн сангийн зардалд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн эзлэх хувь**



3.1.58 Нийгмийн халамжийн үйлчилгээнд 2023 онд нийт 2,023,792 иргэнд 2,117.9 тэрбум төгрөгийг зарцуулснаас хүүхдийн мөнгөн тэтгэмжид 1,305,322 хүүхдэд 1,520.1 тэрбум төгрөг буюу 71.8 хувийг, бусад халамжийн үйлчилгээнд 718,470 иргэнд 597.8 тэрбум төгрөг буюу 28.2 хувийг зарцуулжээ.

3.1.59 Засгийн газрын 2023 оны 237 дугаар тогтоолоор

байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмжийг 37.0-151.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, сар бүр 275.0-325.0 мянган төгрөг олгосноор нийгмийн халамжийн зардал 597.8 тэрбум төгрөгийг зарцуулж, өмнөх оноос 87.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

3.1.60 Нийгмийн халамжийн сангаас одонтой эхчүүдэд олгох тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж, насны хишиг зэрэг дэмжлэг, урамшууллын шинжтэй 1,578.3 тэрбум төгрөгийн зардлыг төлөвлөн зарцуулж байгаа нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1<sup>19</sup>-т заасантай нийцэхгүй байна.

3.1.61 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 13 хөтөлбөр, арга хэмжээнд 92.9 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс, 61.0 тэрбум төгрөгийг зарцуулж, 65.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилд зуучлах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүйтэй холбоотой байна.

3.1.62 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн 7 хөтөлбөр, арга хэмжээнд 43,637 иргэнийг хамруулж, 52.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

**Эмнэлгийн тусламж үйлчилгээг бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх эх үүсвэр дутагдалтайгаас бүрэн санхүүжүүлээгүй, 218.3 тэрбум төгрөгийн өртэй байна**

3.1.63 ЭМДС-ийн нийт урсгал зарлага 1,603.4 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 1,602.8 тэрбум төгрөгийг зарцуулж, 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 15. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага

/тэрбум төгрөгөөр/

Зарлагын төрөл	2022 он		2023 он			Өмнөх оны зөрүү
	Гүйц	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
ЭМДС-аас санхүүжих эмийн үнийн хөнгөлөлт	67.3	90.0	90.0	-	100.0	22.7
Улсын төсвийн санхүүжилт анхан шат нэг иргэн	181.2	272.5	272.4	0.1	100.0	91.2
Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг	16.3	43.3	36.8	6.5	85.0	20.5
Анхан шатны тусламж	41.3	67.2	47.7	19.5	71.0	6.4
Сум, өрхийн ЭМТ-д ЭМД-аас олгох санхүүжилт	10.8	16.8	27.3	(10.5)	162.5	16.5
Төр хариуцах эмийн санхүүжилт		10.5	9.5	1.0	90.5	9.5
Эрүүл мэндийн байгуулагд олгох тусламж үйлчилгээний санхүүжилт	1,109.8	1,052.3	1,068.5	(16.2)	101.5	(41.3)
ЭМД-ын шимтгэлийн илүү төлөлтийн буцаалт	0.3	0.4	0.3	0.1	60.0	-
Үйл ажиллагааны зардал	13.3	10.4	10.3	0.1	99.0	(3.0)
Эрсдэлийн сан	40.0	40.0	40.0	-	100.0	-
<b>Нийт дүн</b>	<b>1,480.3</b>	<b>1,603.4</b>	<b>1,602.8</b>	<b>0.7</b>	<b>99.9</b>	<b>122.5</b>

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.1.64 Тайлант оны гүйцэтгэлээр эрүүл мэндийн байгууллагуудад олгох тусламж үйлчилгээний санхүүжилтэд 1,462.2 тэрбум төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 90.0 тэрбум төгрөг, үйл ажиллагааны урсгал зардалд 10.3 тэрбум төгрөг, шимтгэлийн илүү төлөлтийн буцаалтад 0.3 тэрбум төгрөг, эрсдэлийн санд 40.0 тэрбум төгрөг, нийт 1,602.8 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

3.1.65 Эм, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсний төлбөрт 1,769.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоос гүйцэтгэлээр 1,612.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, эх үүсвэр дутагдалтайгаас шалтгаалан 485,653 иргэнд үйлчилгээ үзүүлсний төлбөр 157.7 тэрбум төгрөгийг олгоогүй өглөг үүссэн, мөн он дамжсан 60.6 тэрбум төгрөг, нийт 218.3 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байна.

<sup>19</sup> "нийгмийн халамж" гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 2.3 хувиар давуулж бүрдүүлсэн ч Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 68.2 тэрбум төгрөгийн авлага, Чингис хаан банканд байршиж буй 94.9 тэрбум төгрөгийн сангийн хөрөнгө эрсдэлтэй байна

3.1.66 НДС-ийн нийт урсгал зарлага 4,036.1 тэрбум төгрөг зарцуулж, 97.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 16. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага

/тэрбум төгрөг/

Даатгалын сангийн төрөл	2022 оны		2023 он			Өмнөх оны зөрүү
	гүйц	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
Тэтгэвэр	3,031.3	3,728.5	3,617.0	111.5	97.0	585.7
Тэтгэмж	165.9	230.0	212.5	17.5	92.4	46.6
ҮОМШӨ	35.9	45.2	41.5	3.7	91.8	5.6
Ажилгүйдэл	78.7	80.3	110.2	(29.9)	137.2	31.5
Үйл ажиллагааны зардал	31.2	47.1	43.2	3.9	91.7	12.0
ДТШ-ийн 50 хувийн буцаалт	72.7	21.6	11.7	9.9	54.2	(61.0)
<b>Нийт дүн</b>	<b>3,415.7</b>	<b>4,152.7</b>	<b>4,036.1</b>	<b>116.6</b>	<b>97.2</b>	<b>620.4</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны мэдээлэл

3.1.67 Тайлант онд ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо 30,088 хүн болж өмнөх оноос 428 хүнээр буурсан ч ажилгүйдлийн даатгалын сангийн зардалд 29.9 тэрбум төгрөгийг илүү зарцуулсан байна.

3.1.68 Тэтгэврийн даатгалын сангаас 2023 онд өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр болон бусад зардалд 3,728.5 тэрбум төгрөг зарцуулахаас 3,617.0 тэрбум төгрөг зарцуулж, сангийн зарлага 111.5 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь тэтгэвэр авагчдын тооны цэвэр өсөлт төлөвлөснөөс 6,495 хүнээр буурсантай холбоотой байна.

3.1.69 Тайлант оны 1 дүгээр сард 2022 оны 12 дугаар сарын өөрөө хариуцан төлсөн шимтгэлийн буцаан олголтыг 310,994 даатгуулагчид 11.7 тэрбум төгрөгийг олгожээ.

3.1.70 Тэтгэмжийн даатгалын сангаас 248,660 даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмжид 212.5 тэрбум төгрөг зарцуулж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46.6 тэрбум төгрөг буюу 28.0 хувиар өссөн байна.

3.1.71 Тайлант онд 7,364 даатгуулагчид тахир дутуу, тэжээгчээ алдсан, ХЧТА, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувиллын зардалд ҮОМШӨ-ний даатгалын сангаас 41.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж, өмнөх оноос 5.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.1.72 Тайлант онд ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо өмнөх оноос 428 хүнээр буурсан ч ажилгүйдлийн даатгалын сангийн зардалд 29.9 тэрбум төгрөгийг илүү зарцуулсан нь аж ахуйн нэгж, байгууллагын даатгуулагчдын дундаж цалингийн өсөлттэй холбоотой бөгөөд ажилгүйдлийн тэтгэмжийн дундаж хэмжээ өмнөх оноос 42.9 хувиар өссөн нь уг зардлын төсөв хэтрэхэд нөлөөлсөн байна.

**Хөрөнгийн зардлын санхүүжилтийн гүйцэтгэлийг 76.5 тэрбум төгрөгөөр бууруулан тайлагнасан байна**

3.1.73 Хөрөнгийн нийт зардлыг 6,216.8 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 5,188.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, 83.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 17. Монгол Улсын 2023 төсвийн хөрөнгө оруулалтын зардал

/тэрбум төгрөг/

№	Үзүүлэлт	Нэгдсэн		Улсын		Орон нутаг	
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
	<b>Хөрөнгийн зардал</b>	<b>6,216.8</b>	<b>5,188.2</b>	<b>4,381.4</b>	<b>3,951.9</b>	<b>1,835.4</b>	<b>1,236.3</b>
1	Барилга байгууламж	4,242.9	3,730.3	3,553.0	3,263.3	689.9	467.0
2	Их засвар	203.7	172.3	106.1	104.8	97.6	67.5
3	Хөрөнгийн бусад зардал	1,770.2	1,285.6	722.3	583.8	1,047.9	701.8

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1.74 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 4,381.4 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 3,951.9 тэрбум төгрөг зарцуулсан нь 90.2 хувийн санхүүжилтийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 18. Улсын төсвийн хөрөнгийн зардал

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2022 оны Гүйц	2023 он				ДНБ-д эзлэх хувь		
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү	Төлөв	Гүйц	
Барилга байгууламж	2,371.5	3,553.0	3,263.3	91.8	(289.7)	5.2	4.7	
Их засвар	53	106.1	104.8	98.8	(1.3)	0.2	0.2	
Тоног төхөөрөмж	214.9	577.5	450.9	78.1	(126.6)	0.8	0.7	
Бусад хөрөнгө	116.8	136	124	91.2	(12.0)	0.2	0.2	
Стратегийн нөөц хөрөнгө	8.1	8.9	8.9	100.0	-	0	0	
<b>Хөрөнгийн зардал</b>	<b>2,764.3</b>	<b>4,381.4</b>	<b>3,951.9</b>	<b>90.2</b>	<b>(429.5)</b>	<b>6.4</b>	<b>5.7</b>	
Үүнээс	Хөрөнгө оруулалтын зардал	1,237.3	2,686.0	2,529.3	94.2	(156.7)	3.9	3.7
	Концесс	302.4	279.6	251.6	90.0	(28.0)	0.4	0.4
	Хөрөнгийн зардал /ТАХ/	1,224.5	1,415.8	1,171.0	82.7	(244.8)	2.1	1.7


Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1.75 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 3,951.9 тэрбум төгрөг зарцуулснаас хөрөнгө оруулалтын зардалд 2,529.3 тэрбум төгрөг, концесс 251.6 тэрбум төгрөг, гадаад зээл тусламж болон дотоод эх үүсвэрээс санхүүжсэн хөрөнгийн төсөл арга хэмжээ 1,171.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс Улсын төсвийн хөрөнгийн зардлаас барилга байгууламжийн зардалд 3,263.3 тэрбум төгрөг, их засварын зардалд 104.8 тэрбум төгрөг, бусад хөрөнгийн зардалд 583.8 тэрбум төгрөгийг зарцуулсан гэж тайлагнасан байна.

3.1.76 Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргын төсөвт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд батлагдсан төсвөөс эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн "Нийтийн тээврийн автобус" худалдан авахаар гүйцэтгэгчид 260.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, хөрөнгийн зардлын санхүүжилтийг 76.5 тэрбум төгрөгөөр бууруулан тайлагнасан байна.

3.1.77 Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 3,951.9 тэрбум төгрөг буюу 24.6 хувийг улсын төсвийн хөрөнгийн зардал эзэлж байна.

Дүрслэл 9. Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн ба хөрөнгийн зардал /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1.78 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд 2,686.0 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 83.2 хувь буюу 2,233.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, 13.8 хувь буюу 371.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Засгийн газрын 2023 оны 456 дугаар тогтоолоор барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, 3 хувь буюу 80.2 тэрбум төгрөг нь тендерийн хэмнэлт болон гэрээ байгуулагдаагүй ажлын санхүүжилт байна.

3.1.79 Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд тусгасан төсөл арга хэмжээний хэрэгжилтийг анх хэрэгжиж эхэлсэн хугацаагаар нь авч үзэхэд 10 ба түүнээс дээш жил үргэлжилсэн 178.8 тэрбум төгрөгийн өртөгтэй 16 төсөл, арга хэмжээ байна.

3.1.80 Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн 4 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 279.6 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 251.6 тэрбум төгрөг олгосон байна.

3.1.81 Гадаад болон дотоод эх үүсвэрээр 1,284.5 тэрбум төгрөгийн 110 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 58 төсөл, арга хэмжээнд нийт 1,043.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

3.1.82 Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн санхүүжилтийн 26.8 хувийг тусламжаар, 73.2 хувийг зээлээр санхүүжүүлсэн бөгөөд ТЕЗ нар хүрсэн үр дүн, түүний танилцуулгыг бэлтгэж Сангийн яаманд ирүүлээгүй байна.

3.1.83 ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн зардалтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- ТЕЗ-ийн хөрөнгө оруулалтын арга хэмжээний төсвийн төслийн жагсаалтад тэргүүлэх зэлжид эрэмбэлэгдээгүй, салбарын бодлоготой бүрэн уялдаагүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын нэгдсэн судалгаа тооцоолол хийгдээгүйгээс төсөл, арга хэмжээний төсвийг хэт олон жижиглэсэн, ТЕЗ-ийн төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүйгээр бусад салбарын төрийн байгууллага болон аж ахуй эрхлэгч иргэдийн зээмшилд ашиглагдах хөрөнгө бэлтгэсэн, хөрөнгө оруулалтын зардлын эдийн засгийн ангиллыг өөрчилж бусад ангилалд зарцуулсан, иргэн аж ахуй нэгжид тараах зориулалт бүхий төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн зэрэг зөрчлүүд байна. / Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 1.7 тэрбум төгрөг, Дорнод аймаг 0.7 тэрбум /;
- Ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, бүртгэлд тусгаагүй 84.9 тэрбум төгрөгийн хөрөнгө байна. /БХБС-ын 81.8 тэрбум төгрөг, Эрчим хүчний сайдын 3.1 тэрбум төгрөг/;
- Барилгын ажил дууссан боловч урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэлтэй 0.3 тэрбум төгрөгийн хөрөнгө байна. / Эрчим хүчний сайд/
- Гүйцэтгэгч байгууллага гэрээнд заасан хугацаанд зуухыг нийлүүлээгүй хугацааг сунгасан, хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй байна. /Шадар сайд/;
- Төсөл, арга хэмжээний хэмнэлт, цуцлагдсан тендерийн зарцуулагдаагүй үлдэгдэл санхүүжилт 1.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй / БХБС-ын 0.2 тэрбум төгрөг, Соёлын сайдын 1.0 тэрбум төгрөг/
- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон гэрээний үүрэг зөрчигдөж 12.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын 5 төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй байна. / Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир спортын үндэсний хороо/
- Хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлыг төсөвт төлөвлөөгүй, баталсан урсгал зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй. /Монгол Улсын Ерөнхий прокурор 2.8 тэрбум төгрөг/
- Үнийн өсөлт болон ажлын тоо хэмжээний зөрүү тооцуулж магадлалаар оруулах шалтгаанаар ажлыг зогсоож тайлант онд төлөвлөсөн ажил хийгдээгүй байна. / Эрчим хүчний сайдын 0.3 тэрбум төгрөг/
- Урьдчилгаа олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй зогссон /Эрчим хүчний сайдын 14.5 тэрбум төгрөг/
- Дээд шүүхийн барилгын урсгал засварын сүүлийн блокийн ажил эхлээгүй байхад Ажлын хэсгийн хуралдааны шийдвэрээр Рэд Лайн ХХК-д 0.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. /Шүүхийн сахилгын хороо/

3.1.84 Орон нутгийн төсвийн хөрөнгийн зардалд 1,835.4 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 1,236.3 тэрбум төгрөгийг зарцуулж, 67.4 хувийн гүйцэтгэлтэй буюу өмнөх оноос 197.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

3.1.85 Орон нутгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн зардалтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Архангай: Аймгийн ИТХ-ийн 2023 оны 17 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар 1.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 24 их засварын ажлыг гүйцэтгэхээр баталж, эдгээр ТАХ-ний зураг төсөв, ажлын даалгаврыг төсөв баталсны дараа боловсруулсан;
- Булган аймаг: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим төсөл хөтөлбөрийг хөгжлийн бодлогын зорилтын арга хэмжээтэй уялдуулж төлөвлөөгүй;
- Орхон аймаг: Гадаадын зээлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй "Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл" төслийн хэрэгжилт 98.0 хувийн гүйцэтгэлтэй, улсын комисс хүлээж аваагүй, өмчлөгчийн асуудлыг шийдвэрлээгүй, нийт зээлийн өр төлбөрийн дүн тодорхойгүй тул урьдчилж гарсан зардлаар тайлагнасан;
- Дорнод аймаг: ТЕЗ-ийн багцад хамаарахгүй улсын төсвийн байгууллагуудад орон нутгийн төсвөөс нийт 590.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөн зарцуулсан;
- Өмнөговь аймаг: Архив донтох өвчтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх наркалогийн төвийг шинээр байгуулахаар төсөв батлагдсан боловч гүйцэтгэлээр арга хэмжээний зориулалтыг өөрчлөн 0.9 тэрбум төгрөгийн техник, тоног төхөөрөмж худалдан авч, хөрөнгийг бүртгэлд тусгаагүй;
- Сүхбаатар аймаг: "Шинэ суурьшлын бүс байгуулах" 3.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний барилгын ажлыг газрын зөвшөөрөлгүй, магадлалаар баталгаажаагүй зураг төсвөөр эхлүүлсэн.

3.1.86 ОНХС-ийн хөрөнгөөр 10,339 төсөл, арга хэмжээнд 575.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр бүрэн хэрэгжсэн 7,867 төсөл, арга хэмжээнд 401.0 тэрбум төгрөг, дутуу хэрэгжсэн 845 төсөл, арга хэмжээнд 75.5 тэрбум төгрөгийг зарцуулж, хэрэгжээгүй 94.3 тэрбум төгрөгийн 1,666 төсөл, арга хэмжээ байна. /Хавсралт 4/

3.1.87 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл өмнөх оноос 6,969 төсөл, арга хэмжээ буюу 332.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн орлого өссөнтэй холбоотой байна. /Хавсралт 5/

3.1.88 ОНХС болон төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Дундговь аймаг: ОНХС-ийн дансанд төвлөрүүлэх 281.4 сая төгрөгийн хандив, тусламжийг аймаг, сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, урсгал зардалд зарцуулсан;
- Сэлэнгэ аймаг: Орон нутгийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс 50 төсөл, арга хэмжээ буюу 32.1 хувь нь бүрэн хэрэгжээгүй, иргэдээс санал авч эрэмбэлээгүй, зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийгдээгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр өргөн мэдүүлээгүй, ИТХ-аар батлалгүйгээр төсвийн төлөвлөлтөд тусгасан.

**Дампуурсан банк, хадгаламж зээлийн хоршоодод мөнгөө хадгалуулсан иргэдэд учирсан хохирлоос үүссэн авлагыг жил бүрийн төсөвт эргэн төлөгдөх цэвэр зээлээр баталдаг боловч эргэн төлөлт хийгдээгүй байна**

3.1.89 Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардалд дотоод эх үүсвэрээс 216.8 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 283.0 тэрбум төгрөг олгох, өмнөх онуудад олгосон зээлээс 563.2 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна.

3.1.90 Гүйцэтгэлээр дотоод эх үүсвэрээс 150.5 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 282.4 тэрбум төгрөг, нийт 432.9 тэрбум төгрөгийн зээл олгож, өмнөх онуудад олгосон зээлээс 203.5 тэрбум төгрөгийг буцаан төвлөрүүлсэн нь төлөвлөснөөс 359.7 тэрбум төгрөгөөр дутуу байна.

Хүснэгт 19. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл

/тэрбум төгрөг/

ТӨЗ	Байгууллага, хөтөлбөрийн нэр	2023 оны			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
<b>Олгосон зээл, үүнээс</b>		<b>216.8</b>	<b>150.5</b>	<b>66.3</b>	<b>69.4</b>
ХХААХҮС	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл	12.8	5.0	7.8	39.1
	Байгаль орчныг хамгаалах, ЖДҮ-ийг хөгжүүлэх 2 үе шаттай зээлийн төсөл	21.7	21.7	-	100.0
	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	50.0	35.6	14.4	71.2
БХБС	Түрээсийн орон сууц" хөтөлбөр	5.0	5.0	-	100.0
БШУС	Боловсролын зээлийн сан	31.8	15.1	16.7	47.5
ОНТӨЗ	Сум хөгжүүлэх сан, ЖДҮХС, бусад	95.5	68.1	27.4	71.3
<b>Буцаан төлөгдсөн зээл, үүнээс</b>		<b>(563.2)</b>	<b>(203.5)</b>	<b>(359.7)</b>	<b>36.1</b>
ХХААХҮС	Хөдөө аж ахуйн корпорац ТӨХХК	(47.5)	(21.7)	(25.8)	45.7
	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл	(22.0)	(10.0)	(12.0)	45.5
	Байгаль орчныг хамгаалах, ЖДҮ-ийг хөгжүүлэх 2 үе шаттай зээлийн төсөл	(28.2)	(14.4)	(13.8)	51.1
Сангийн сайд	ААНБ болон улс, орон нутгийн төсөвт байгууллагууд, төсөл хөтөлбөр, Татан буугдсан банкнуудаас авах авлага.	(261.5)	(139.8)	(121.7)	53.5
БШУС	Боловсролын зээлийн сан	(30.0)	(11.6)	(18.4)	38.7
ХЗДХС	Банк, хадгаламж зээлийн хоршооны ажлын алба	(20.6)		(20.6)	-
ХНХС	Нийгмийн даатгалын сан	(68.4)	(1.2)	(67.2)	1.8
Эрүүл мэндийн сайд	Эрүүл мэндийн даатгалын сан	(85.0)	(4.8)	(80.2)	5.6
<b>Эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн</b>		<b>(346.4)</b>	<b>(53.0)</b>	<b>(293.4)</b>	<b>15.3</b>
Үүнээс:	Гадаад эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх зээлийн дүн	283.0	282.4	0.6	99.8
	Эргэж төлөгдөх зээлийг хассан цэвэр зээлийн дүн	(63.4)	229.4	(292.8)	(361.8)

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1.91 Нэгдсэн төсвийн эргэж төлөгдөх гадаад цэвэр зээлийг 283.0 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 282.4 тэрбум төгрөг буюу 99.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.1.92 Дотоод эх үүсвэрээс нийт 216.8 тэрбум төгрөгийн эргэж төлөгдөх зээл олгохоор төлөвлөснөөс 69.4 хувь буюу 150.5 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Үүнд:

- ЖДҮХС-аас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлд 50.0 тэрбум төгрөг төсөвлөснөөс, гүйцэтгэлээр 265 аж ахуйн нэгж, иргэнд 35.6 тэрбум төгрөг;
- Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслөөс 12.8 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөж, ноос, ноолуур, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын 2 ААН-д 5.0 тэрбум төгрөг;
- Байгаль орчныг хамгаалах, ЖДҮ-ийг хөгжүүлэх 2 үе шаттай зээлийн төслөөс 21.7 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөж, 51 зээлдэгчид 21.7 тэрбум төгрөг;
- Боловсролын зээлийн сангаас 31.8 тэрбум төгрөгийн сургалтын зээл олгохоор төлөвлөснөөс 15.1 тэрбум төгрөгийг олгосон байна. Үүнээс гадаад суралцагсдын 103 зээлд 9.3 тэрбум төгрөг, оюутны хөгжлийн зээлд 3271 оюутанд 5.8 тэрбум төгрөг;
- БХБЯ-аас түрээсийн орон сууц хөтөлбөрийн санхүүжилтэд "ТОСК" ТӨХХК-д 5.0 тэрбум төгрөг;
- Хоршоо хөгжүүлэх сан болон ЖДҮХС-аас 42.4 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөснөөс 23.4 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.

3.1.93 Улсын төсөвт буцаан төвлөрүүлэх эргэж төлөгдөх зээлийн төлөлтийг 563.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 36.1 хувь буюу 203.5 тэрбум төгрөгийг төлүүлж, 63.9 хувь буюу 359.7 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. /Сангийн сайд 121.7 тэрбум төгрөг, ХХААХҮС 51.6

тэрбум төгрөг, Боловсролын зээлийн сан 18.4 тэрбум төгрөг, ХЗДХС 20.6 тэрбум төгрөг, ЭМДС 80.2 тэрбум төгрөг, НДС 67.2 тэрбум төгрөг/ Тухайлбал,

- Засгийн газраас олон улсын банк санхүүгийн байгууллага, түншлэгч улс орнуудаас авсан хөнгөлөлттэй зээлээс дотоодын байгууллагад дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлт төлөвлөснөөс 41.6 тэрбум төгрөгөөр дутуу;
- Хадгаламж зээлийн хоршоодод мөнгөө хадгалуулсан иргэдэд учирсан хохиролд төсвөөс олгосон 20.6 тэрбум төгрөг, Зоос банкны эрх хүлээн авагчаас авах авлага 58.5 тэрбум төгрөг, Анод банкнаас авах авлага 22.5 тэрбум төгрөг, нийт 101.6 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг жил бүр төлөвлөж байгаа боловч төлөлт хийгдээгүй;
- Капитал банкны эрх хүлээн авагчаас авах ЭМДС болон НДС-ийн нийт 153.4 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулахаар төлөвлөснөөс 147.4 тэрбум төгрөгийн авлага төлөгдөөгүй байна.

**ТЕЗ-дын хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийн хүрсэн үр дүнг үнэлээгүй байна**

3.1.94 Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт"-д 38 УТЕЗ-ийн хэрэгжүүлэх 92 хөтөлбөрийн хүрээнд 309 арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 16,949.9 тэрбум төгрөгийг зарцуулахаар баталжээ.

3.1.95 Төсвийн тодотголоор 283.3 тэрбум төгрөгөөр нийт зарлагыг нэмэгдүүлсэн боловч холбогдох ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээнд өөрчлөлт оруулж, шинэчлэн батлаагүй байна.

3.1.96 ТЕЗ-дын хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 21 арга хэмжээний хэрэгжилт 10.0-50.0 хувь, 9 хөтөлбөрийн 28 арга хэмжээний хэрэгжилт 50.0-80.0 хувь, 70 хөтөлбөрийн 257 арга хэмжээний хэрэгжилт 80.0-100.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.1.97 Зарим хөтөлбөр, арга хэмжээний үр дүнг төлөвлөж батлахдаа гадаад, дотоод хүчин зүйлийг бүрэн тооцож төлөвлөгөөгүйгээс дараах төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд:

- ЗЗХС: Шинээр нэмэгдэх бүсийн тээвэр логистикийн төв байгуулах;
- БОАЖС: Дулааны станцад шинээр суурилуулсан утаа шүүгчийн тоо /PM2.5 тоосонцор мкг/м3/ бохирдлын эрсдэлийг бууруулна;
- ХХААХУС: "Дархан арьс ширний цогцолбор" УТП-ын дэд бүтэц, үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцыг 60.0 хувьд хүргэхээр төлөвлөсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

3.1.98 ТЕЗ-дын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийн хэрэгжилтийг тайлагнасан боловч үр дүнг үнэлээгүй байна.

**3.2 Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд арвилан хэмнэлт бий болсон хэдий ч хуульд оруулсан зарим өөрчлөлт нь хуулийн ач холбогдлыг бууруулж байна**

**Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан зарим арга хэмжээний холбогдох дүрэм журмыг боловсруулаагүй нь санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах үндсэн зорилтод нийцэхгүй байна**

3.2.1 Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсанаас хойш нэмэлт, өөрчлөлт оруулах, мөрдөх хугацааг хойшлуулах, хасах зэргээр хуулийн зарим зүйл заалтыг нийт 4 удаа өөрчилсөн байна.

3.2.2 Хуулийн өөрчлөлтөөр нэр бүхий байгууллагын үндсэн чиг үүрэг, хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс автомашин ашиглах, хэвлэл захиалгын зардал гаргах, дэд болон орлогч даргатай байхыг зөвшөөрсөн байна.

3.2.3 Тэвчиж болох зарим зардлыг хүлээн зөвшөөрсөн, хуулийн зарим заалтуудын хэрэгжих хугацааг хойшлуулсан өөрчлөлтүүд нь төрийн бүх шатны байгууллагуудад санхүүгийн сахилга



батыг мөрдүүлж, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хуулийн үндсэн зорилтын ач холбогдлыг бууруулж байна.

**Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас тогтоосон зарим арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна**


3.2.4 Засгийн газрын "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2022 оны 203, 204 дүгээр тогтоолыг баталж, тухайн онд багтаан хэрэгжүүлэх үүргийг холбогдох газруудад өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй байна.

- Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоолын 2-т "Төрийн албан хаагчийн албан ажлын ерөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, техник хэрэгслийн нийтлэг жишигт өөрчлөлт оруулах санал", 3-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишиг тогтоох талаар санал"-ыг тус тус боловсруулж 2022 оны 02 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг ТӨБЗГ-т даалгасныг хэрэгжүүлээгүй;
- Засгийн газрын 2022 оны "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 204 дүгээр тогтоолоор эрх бүхий байгууллагуудын тээврийн хэрэгсэлтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан зааж, үүрэгжүүлснээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4<sup>20</sup> дэх заалтын дагуу тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаарт шилжүүлэх арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй, төрийн болон орон нутгийн 2,561 байгууллагын нэр дээр нийт 18,876 тээврийн хэрэгслийн 52.6 хувь буюу 9,936 нь дугаарын дэвсгэр өнгийг өөрчлөөгүй;
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 1-т заасны дагуу ТӨБЗГ-с 2022 онд 17.2 тэрбум төгрөгийн балансын үнэтэй 329 автомашин, 2023 онд 7.4 тэрбум төгрөгийн балансын үнэтэй 156 автомашин, нийт 24.6 тэрбум төгрөгийн балансын үнэ бүхий 486 автомашиныг татан төвлөрүүлж, Засгийн газрын автобааз УТҮГ болон тусгай хэрэгцээт байгууллагад шилжүүлэх, дуудлага худалдаагаар худалдан борлуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагууд хяналт тавиагүй;
- Байгууллагуудын авто тээврийн хэрэгслийн бүртгэлд тавих дотоод хяналт сул, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын мэдээллийн санд татан буугдсан, үйл ажиллагаа нь зогссон, хувийн хэвшлийн байгууллагын нэр дээр нийт 152 ширхэг автомашин бүртгэлтэй байна.

3.2.5 Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчдын ашиглах автомашины хэрэгцээ шаардлага, тоо хэмжээг тогтоож өгөөгүйгээс зарим аймагт хэрэгцээ, шаардлагаас давсан автомашин ашиглаж, төсвийн үргүй зардал гаргах нөхцөл бүрдсэн байна.

3.2.6 Хуулийн хүрээнд хэмнэсэн зардлын дүн 2022 онд 83.2 тэрбум төгрөг, 2023 онд 122.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 39.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Дүрслэл 10. Төрийн хэмнэлтийн хуулиар хэмнэсэн зардлууд /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын судалгаа

<sup>20</sup>Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.

3.2.7 Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу 2023 онд 774 байгууллага цахим дэлгүүрээс 153.6 тэрбум төгрөгийн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авахаар төлөвлөсөн боловч 85.2 тэрбум төгрөгийн худалдан авалт хийж, төлөвлөгөөний биелэлт 44.5 хувиар тасарсан байна.

3.2.8 Цахим дэлгүүрийн бараа, бүтээгдэхүүний сонголт бага, өртөг өндөр, захиалга цуцлагддаг, чанарын шаардлага хангадаггүй зэргээс шалтгаалж хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.

3.2.9 Төрийн аудитын байгууллагаас 6,711 байгууллагын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 56.8 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Сүхбаатар

**БҮЛЭГ 4. НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ 785.9 ТЭРБУМ  
ТӨГРӨГИЙН АШИГТАЙ ГАРСАН БАЙНА**

4.1.1 Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийг 2,213.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 785.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна<sup>21</sup>.

Хүснэгт 20. Нэгдсэн төсвийн тэнцэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Нэгдсэн		Улсын		Орон нутаг		ЭМДС		НДС	
	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>23,039.6</b>	<b>24,387.1</b>	<b>16,226.2</b>	<b>17,177.3</b>	<b>4,616.5</b>	<b>4,891.3</b>	<b>1,603.5</b>	<b>1,586.8</b>	<b>4,175.2</b>	<b>4,271.6</b>
Төсвийн тогтворжуулалтын сан	501.6	675.9	501.6	675.9	-	-	-	-	-	-
Ирээдүйн өв сан	540.0	416.2	540.0	416.2	-	-	-	-	-	-
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	21,997.9	23,294.9	15,184.6	16,085.2	4,616.5	4,891.3	1,603.5	1,586.8	4,175.2	4,271.6
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	24,211.0	22,509.0	16,949.9	16,079.8	5,240.2	4,336.3	1,518.5	1,598.0	4,084.3	4,035.0
<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>(1,171.5)</b>	<b>1,878.1</b>	<b>(723.7)</b>	<b>1,097.6</b>	<b>(623.6)</b>	<b>555.0</b>	<b>85.0</b>	<b>(11.2)</b>	<b>90.9</b>	<b>236.6</b>
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>(2,213.1)</b>	<b>785.9</b>	<b>(1,765.3)</b>	<b>5.4</b>	<b>(623.6)</b>	<b>555.0</b>	<b>85.0</b>	<b>(11.2)</b>	<b>90.9</b>	<b>236.6</b>

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.1.2 Тайлант онд Засгийн газрын үнэт цаасны борлуулалтаас 670.3 тэрбум төгрөг, Засгийн газрын гадаад зээлээс 417.5 тэрбум төгрөг, Төсвийн тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдлээс 501.6 тэрбум төгрөг, төсөвт хамаарах харилцах болон хадгаламжийн данснуудын цэвэр өөрчлөлтөөс 623.6 тэрбум төгрөг, нийт 2,213.0 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

4.1.3 Гүйцэтгэлээр Засгийн газрын гадаад үнэт цаасны борлуулалтаас 97.2 тэрбум төгрөг, гадаад зээлээс 944.2 тэрбум төгрөг, өмч хувьчлалын орлогоос 2.5 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, өмнөх онуудад авч ашигласан Засгийн газрын дотоод үнэт цаасны төлбөрт 801.3 тэрбум төгрөгийг төлж, харилцах болон хадгаламжийн данснуудын цэвэр өсөлт 1,028.5 тэрбум төгрөгт хүрснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 785.9 тэрбум төгрөгийн ашигтай илэрхийлэгдсэн байна.

<sup>21</sup> Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хоорондын давхардсан 3,540.0 тэрбум төгрөгийн орлого, зарлагын шилжүүлгийг цэвэрлэн тайлагнасан байна.

**БҮЛЭГ 5. ӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ХӨГЖҮҮЛЖ, ГАДААД ӨРИЙГ БУУРУУЛАХ БОЛОМЖ БАЙНА**

**5.1 Засгийн газрын 2023 оны өрийн үзүүлэлтүүд нь өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт заасан зорилтот түвшинтэй нийцэж байна**

5.1.1 Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6<sup>22</sup> дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2023 оны 104 дүгээр тогтоолоор “Засгийн газрын 2023 оны зээллэгийн төлөвлөгөө”-г баталсан байна.

5.1.2 Засгийн газрын өрийн багцын үзүүлэлтүүдийн харьцаа 2023 оны гүйцэтгэлээр зохистой түвшинд байгаа хэдий ч Засгийн газрын нийт өрийн үлдэгдэлд гадаад валютаар илэрхийлсэн өр 98.5 хувийг эзэлж байгаа нь төгрөгийн ханш суларсан үед ханшийн зөрүүнээс алдагдал хүлээх эрсдэлтэй байна.

5.1.3 Монгол Улсын нийт өр тайлант оны эцэст 56,312.0 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 30,773.6 тэрбум төгрөг буюу 54.6 хувийг Засгийн газрын өр эзэлж байна.

Хүснэгт 21. Засгийн газрын өрийн үлдэгдэл

/тэрбум төгрөг/


ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2019.12.31	2020.12.31	2021.12.31	2022.12.31	2023.12.31	Зөрүү /2023-2022/	Эзлэх хувь
<b>I. Засгийн газрын дотоод өр</b>	<b>1,399.6</b>	<b>1,136.6</b>	<b>657.3</b>	<b>1,035.5</b>	<b>234.1</b>	<b>(801.4)</b>	<b>0.8</b>
1.1 Үнэт цаас	1,399.6	1,136.6	657.3	1,035.5	234.1	(801.4)	0.8
<b>II. Засгийн газрын гадаад өр</b>	<b>20,728.0</b>	<b>24,851.4</b>	<b>24,693.3</b>	<b>29,641.6</b>	<b>30,274.6</b>	<b>633.0</b>	<b>98.3</b>
2.1 Үнэт цаас	7,927.2	8,354.0	8,175.6	9,359.8	9,371.7	11.9	30.5
2.2 Зээл	12,800.8	16,497.4	16,517.7	20,281.8	20,902.9	621.1	67.8
<b>III. Засгийн газрын өрийн баталгаа</b>	<b>1,076.3</b>	<b>1,060.4</b>	<b>876.5</b>	<b>812.9</b>	<b>29.5</b>	<b>(783.4)</b>	<b>0.1</b>
<b>IV. Барих-шилжүүлэх төрлийн концесс</b>	<b>995.7</b>	<b>850.2</b>	<b>673.9</b>	<b>463.5</b>	<b>230.9</b>	<b>(232.6)</b>	<b>0.8</b>
<b>V. Орон нутгийн зээллэг</b>			<b>17.2</b>	<b>12.3</b>	<b>4.5</b>	<b>(7.8)</b>	<b>0.0</b>
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)</b>	<b>24,199.6</b>	<b>27,898.6</b>	<b>26,918.2</b>	<b>31,965.8</b>	<b>30,773.6</b>	<b>(1,192.2)</b>	<b>100.0</b>
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)</b>	<b>20,525.6</b>	<b>23,024.3</b>	<b>21,837.3</b>	<b>27,691.6</b>	<b>26,582.9</b>	<b>(1,108.7)</b>	
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	75.0%	70.0%	70.0%	70.0%	65.0%		
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	54.2%	61.5%	50.8%	52.4%	38.6%		
Засгийн газрын өр/ДНБ	64.0%	74.5%	62.6%	60.5%	44.7%		
<b>Дотоодын нийт бүтээгдэхүүн (оны үнээр)</b>	<b>37,839.2</b>	<b>37,453.3</b>	<b>43,018.6</b>	<b>52,867.4</b>	<b>68,871.7</b>		
<b>Ам долларын эцсийн ханш</b>	<b>2,733.5</b>	<b>2,849.5</b>	<b>2,848.8</b>	<b>3,444.6</b>	<b>3,410.7</b>		

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

5.1.4 Засгийн газрын өрийн үлдэгдлийн 98.3 хувийг гадаад өр, 0.8 хувийг дотоод өр, 0.8 хувийг “барих-шилжүүлэх” төрлийн концесс, 0.1 хувийг Засгийн газрын өрийн баталгаа тус тус эзэлж байна.

<sup>22</sup> стратегийн баримт бичиг болон зээллэгийн дээд хэмжээнд үндэслэн тухайн төсвийн жилийн зээллэгийн төлөвлөгөөг батлах;

Дүрслэл 11. Тогтвортой байдлын хязгаар



5.1.5 Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл ДНБ-ий 38.6 хувьтай тэнцэж байгаа нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл<sup>23</sup>-д заасан хэмжээнээс 12,542.6 тэрбум төгрөгөөр, ДНБ-д эзлэх хувиас 26.4 нэгж хувиар тус тус бага буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон төсвийн тусгай шаардлагыг<sup>24</sup> хангасан байна.

5.2 Төгрөгийн ханш чангарснаар 512.7 тэрбум төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүний ашигтай гарсан хэдий ч гадаад бондын эргэн төлөлт, хүүгийн зардлыг шинэ бонд гаргах замаар төлж, өрийн хугацааг уртасгасан байна

5.2.1 Тайлант хугацаанд Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт 3,853.6 тэрбум төгрөг төсөвлөснөөс, гүйцэтгэлээр үндсэн төлбөрт 2,152.6 тэрбум төгрөг, хүү болон шимтгэлийн төлбөрт 1,092.6 тэрбум төгрөг, нийт 3,245.2 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан байна.

Хүснэгт 22. Засгийн газрын 2023 оны өрийн үзүүлэлтийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/

Д/д	Засгийн газрын өрийн үйлчилгээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Зөрүү	Хувь
			Улсын төсвөөс	Дахин санхүүжилтээр		
А	В	1	2	3	4=1-2	5=2/1
1	Үндсэн төлбөр	2,760.2	2,152.6	2,966.5	607.6	78.0
1.1	Дотоод үнэт цаас	1,137.5	801.4		336.1	70.5
1.2	Гадаад үнэт цаас	465.7	391.4	2,966.5	74.3	84.0
1.3	Гадаад зээл	1,157.0	959.8		197.2	83.0
2	Хүүгийн төлбөр	1,093.4	1,092.6	-	0.8	99.9
2.1	Гадаад зээл	460.1	460.0		0.1	100.0
2.2	Гадаад үнэт цаас	553.6	553.0		0.6	99.9
2.3	Дотоод үнэт цаас	79.7	79.6		0.1	99.9
3	Нийт төлбөр	3,853.6	3,245.2	2,966.5	608.4	84.2

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

5.2.2 Өрийн зохицуулалтын хүрээнд 3,455.1 тэрбум төгрөг буюу 1,000.0 сая ам.доллаароор Сенчири-2 болон Сенчири-3 үнэт цааснуудыг гаргаж, 2,966.5 тэрбум төгрөг буюу 856.4 сая ам.долларын үнэт цаасны үлдэгдлийг төлсөн байна.

5.2.3 Засгийн газрын өрийн үндсэн төлбөрт улсын төсвөөс 2,152.6 тэрбум төгрөг төлсөн нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд<sup>25</sup> заасан хязгаарт багтаж байна.

5.2.4 Засгийн газрын өрийн үлдэгдэл өмнөх оноос 1,192.2 тэрбум төгрөг буюу 3.7 хувиар буурсан байна.

<sup>23</sup> Монгол Улсын хуулийн 2023 оны 6 дугаар сарын 15-ний өдрийн өөрчлөлтөөр Нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийн 1 дүгээр зүйлийн 8. Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр 39,125.5 тэрбум төгрөг, Дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувь 65.0 хувь;

<sup>24</sup> Монгол Улсын 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хуулийн өөрчлөлтөөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т "Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 оны төсвийн жилд 58.3 хувиас, . . . 2021 болон 2022 оны төсвийн жилд 70 хувиас, 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна";

<sup>25</sup> Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 13 дугаар зүйл "Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2023 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 2,760,217.3 сая төгрөг байна"

Хүснэгт 23. Засгийн газрын 2023 оны өрийн үзүүлэлт

/тэрбум төгрөг/

Д/д	Засгийн газрын өрийн хэрэгсэл	Эхний үлдэгдэл	Ашиглалт болон буцаалт	Эргэн төлөлт	Ханшийн зөрүү	Эцсийн үлдэгдэл	Хүүгийн төлбөр
<b>1.</b>	<b>Засгийн газрын дотоод өр</b>	<b>1,035.5</b>	<b>-</b>	<b>801.4</b>	<b>-</b>	<b>234.1</b>	<b>79.6</b>
1.1	Үнэт цаас	1,035.5		801.4		234.1	79.6
<b>2.</b>	<b>Засгийн газрын гадаад өр</b>	<b>29,641.6</b>	<b>5,394.1</b>	<b>4,317.7</b>	<b>(443.4)</b>	<b>30,274.6</b>	<b>688.3</b>
2.1	Үнэт цаас	9,359.8	3,455.1	3,357.9	(85.3)	9,371.7	553.0
2.2	Зээл	20,281.8	1,939.0	959.8	(358.1)	20,902.9	135.3
<b>3.</b>	<b>Засгийн газрын өрийн баталгаа</b>	<b>812.9</b>		<b>720.6</b>	<b>(62.8)</b>	<b>29.5</b>	<b>460.0</b>
<b>4.</b>	<b>Барих шилжүүлэх төрлийн концесс</b>	<b>463.5</b>	<b>25.5</b>	<b>251.6</b>	<b>(6.5)</b>	<b>230.9</b>	<b>-</b>
<b>5.</b>	<b>Орон нутгийн зээллэг</b>	<b>12.3</b>		<b>7.8</b>		<b>4.5</b>	
	<b>Дүн</b>	<b>31,965.8</b>	<b>5,419.6</b>	<b>6,099.1</b>	<b>(512.7)</b>	<b>30,773.6</b>	<b>1,227.9</b>

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

5.2.5 Тайлант онд төгрөгийн ам.доллартой /USD/ харьцах ханш 33.9 төгрөг, зээлжих тусгай эрхтэй /SDR/ харьцах ханш 8.2 төгрөгөөр тус тус чангарсан, экспорт сайжирч төсвийн орлого нэмэгдсэний үр дүнд гадаад валютын ханшийн зөрүүнээс 512.7 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Дүрслэл 12. Ханшийн алдагдлын статистик

/тэрбум төгрөг/



Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг иргэд, аж ахуйн нэгжид зориулан хөгжүүлэх боломжийг ашиглаагүй байна

5.2.6 Засгийн газрын нийт өрийн дүнд дотоод үнэт цаасны үлдэгдлийн эзлэх хувь 2018 оноос жил дараалан буурсан бөгөөд 2023 онд 801.4 тэрбум төгрөгийг эргэн төлж, 234.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нэрлэсэн үнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн багцын 0.8 хувийг эзэлж байна.

Дүрслэл 13. Засгийн газрын дотоод үнэт цаасны статистик

/тэрбум төгрөг/



5.2.7 Засгийн газрын дотоод үнэт цаасыг 2017 оны 10 дугаар сараас хойш зах зээлд олон нийтэд арилжаалаагүй байна.

Дүрслэл 14. Монголын хөрөнгийн биржээр арилжаалсан үнэт цаасны статистик /тэрбум төгрөг/



5.2.8 Хөрөнгийн биржээр 2021 онд 1,414.2 тэрбум төгрөгийн компанийн бонд арилжаалснаас 692.5 тэрбум төгрөг буюу 49.0 хувийг Эрдэнэс Тавантолгой ХК-ийн бонд эзэлж байна.

5.2.9 Төрийн банк, Голомт банк, Монголын Хөрөнгийн бирж ХК 2022 онд нийт 156.1 тэрбум төгрөгийн IPO гаргасан бол 2023 онд Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк нийт 302.6 тэрбум төгрөгийн IPO гаргасан байна.

Хүснэгт 24. Арилжааны банканд байрших хадгаламжийн үзүүлэлт /тэрбум төгрөг/

Төрөл	2017 он	2023 он	Өсөлт хувь
<b>ААН, иргэдийн хадгаламж</b>	<b>9,615.7</b>	<b>21,112.0</b>	<b>219.6</b>
Хугацаагүй хадгаламж	2,036.9	3,213.1	157.7
Төгрөгийн хадгаламж	1,618.8	2,648.2	163.6
Гадаад валютын хадгаламж	418.1	564.9	135.1
Хугацаатай хадгаламж	7,578.8	17,898.9	236.2
Төгрөгийн хадгаламж	5,827.7	13,698.0	235.0
Гадаад валютын хадгаламж	1,751.1	4,200.9	239.9

Хүснэгт 25. Санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн үзүүлэлт /тэрбум төгрөг/

Төрөл	2017 он	2023 он	Өсөлт хувь
	Нийт хөрөнгө		
Банк	28,769.8	57,069.7	198.4
ББСБ	969.2	4,672.2	482
Даатгал	244.7	551.4	225.3
ХЗХ	153.1	306.5	200.2
Төрөл	Нийт ашиг		
Банк	252.5	1,294.2	512.5
ББСБ	66.8	432.1	646.8
Даатгал	13.2	11.8	89.4
ХЗХ	5.5	10.9	198.2

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

5.2.10 Санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн үзүүлэлтийг Засгийн газрын үнэт цаасны арилжаа зогссон 2017 онтой харьцуулахад хөрөнгө дунджаар 276.5 хувиар, ашиг 361.7 хувиар өссөн, арилжааны банкинд дахь хадгаламж 219.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

5.2.11 Дээрх судалгаанаас үзэхэд дотоодын зах зээлд Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг иргэд, аж ахуйн нэгжид зориулан хөгжүүлэх, төсвийн алдагдлыг санхүүжүүлж буй гадаад өр, хүүгийн зардлыг бууруулах боломж байна.

5.2.12 Гадаад үнэт цаас, зээлийн эх үүсвэрээс 1,224.5 тэрбум төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 5,359.1 тэрбум төгрөг бүрдүүлж, Засгийн газрын гадаад өр өмнөх оноос 633.0 тэрбум төгрөгөөр өсөж, 30,274.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

5.2.13 Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл өмнөх оноос 11.9 тэрбум төгрөгөөр өсөж 9,371.7 тэрбум төгрөгт хүрч, нэрлэсэн үнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн багцын 30.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт 26. Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл

/тэрбум төгрөг/

Галаад үнэт цаас	Гарга сан огноо	Хүүгийн хувь	Эргэн төлөх он	Эхний үлдэгдэл		Гаргалт /тэрбум төгрөг/	Ханшийн өөрчлөлт	Эргэн төлөлт /тэрбум төгрөг/	Эцсийн үлдэгдэл		Хүүгийн төлбөр	
				сая ам.доллар	тэрбум төгрөг				сая ам.доллар	тэрбум төгрөг	сая ам.доллар	тэрбум төгрөг
Гэрэгэ	2017-01-11	5.625	2023	517.2	1,781.6		15.9	1,797.5	-		12.2	42.6
Хуралдай	2017-3-09	8.750	2024	600.0	2,066.8		(3.4)	1,484.5	169.8	578.9	45.6	159.0
Номад	2020-10-07	5.125	2026	600.0	2,066.8		(19.7)	75.7	578.0	1,971.4	30.9	107.6
Сенчири-2027	2021-7-07	4.450	2027	500.0	1,722.3		(16.9)		500.0	1,705.4	17.5	60.2
Сенчири-2031	2021-7-07	3.500	2031	500.0	1,722.3		(16.9)		500.0	1,705.4	22.3	76.6
Сенчири-2	2023-01-19	8.650	2028			2,256.3	(39.2)	0.2	650.0	2,216.9	31.1	107.0
Сенчири-3	2023-12-05	7.875	2029			1,198.8	(5.1)		350.0	1,193.7		
<b>Дүн</b>				<b>2,717.2</b>	<b>9,359.8</b>	<b>3,455.1</b>	<b>(85.3)</b>	<b>3,357.9</b>	<b>2,747.8</b>	<b>9,371.7</b>	<b>159.6</b>	<b>553.0</b>

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

5.2.14 Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн 2 дугаар зорилт<sup>26</sup>, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйл<sup>27</sup> -ийг үндэслэн гадаад үнэт цаасны төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх ачааллыг жигдлэх, өрийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор өрийн зохицуулалтын хүрээнд 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр 5 жилийн хугацаатай, 8.650 хувийн хүүтэй 650.0 сая ам.долларын “Сенчири-2”, 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр 5.5 жилийн хугацаатай, 7.875 хувийн хүүтэй 350.0 сая ам.долларын “Сенчири-3” гадаад бонд гаргаж, өрийг дахин санхүүжүүлэн гадаад өрийн хугацааг уртасгасан байна.

Үүнд:

- “Гэрэгэ” бондын /5.625 хувийн хүү/ 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдөр төлж дуусгах хугацаатай эргэн төлөлтөөс 90.8 сая ам.долларын үндсэн төлбөрийг улсын төсвөөс, 426.4 сая ам.долларын үндсэн төлбөр, 1.9 сая ам.долларын хүүгийн төлбөрийг “Сенчири-2” бондоор төлж барагдуулсан;
- “Хуралдай” бондын /8.750 хувийн хүү/ 2024 оны 3 дугаар сарын 9-нд төлж дуусах хугацаатай эргэн төлөлтөөс 207.5 сая ам.долларын үндсэн төлбөр, 6.6 сая ам.долларын хүүгийн төлбөрийг “Сенчири-2” бонд, 222.8 сая ам.доллартой тэнцэх үндсэн төлбөр, 4.6 сая ам.долларын хуримтлагдсан хүүгийн төлбөрийг “Сенчири-3” бондоор тус тус төлсөн;
- Мөн “Сенчири-2”, “Сенчири-3” бондын гадаад үнэт цаасны хямдруулалт буюу хүүгийн бууралтын шимтгэлийн зардалд 11.1 сая ам.доллар төлж, “Сенчири-3” бондын үлдэгдэл 119.1 сая ам.долларыг “Хуралдай” бондын 2024 оны 3 дугаар сарын 09-нд төлөх төлбөрт үлдсэн байна.

5.2.15 Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 1,939.0 тэрбум төгрөгийн ашиглалтаар нэмэгдэж, үндсэн төлбөрийн 959.8 тэрбум төгрөг, ханшийн зөрүү 358.1 тэрбум төгрөгөөр хасагдаж, жилийн эцэст 20,902.9 тэрбум төгрөг болж, нэрлэсэн үнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн багцын 67.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 27. Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл

/тэрбум төгрөг/

Зээлийн ангилал	Эхний үлдэгдэл	Ашиглалт болон буцаалт	Үндсэн төлбөр	Ханшийн зөрүү	Эцсийн үлдэгдэл	Хүүгийн төлбөр	Хуримтлагдсан хүү
Төслийн зээл	14,196.5	1,246.5	581.6	(206.8)	14,654.7	255.5	78.4
Хөтөлбөрийн зээл	5,511.0	692.5	333.7	(146.4)	5,723.4	199.1	55.2
Санхүүгийн зээл	574.3		44.5	(4.9)	524.8	5.4	1.7
<b>Дүн</b>	<b>20,281.8</b>	<b>1,939.0</b>	<b>959.8</b>	<b>(358.1)</b>	<b>20,902.9</b>	<b>460.0</b>	<b>135.3</b>

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

<sup>26</sup> Зорилт 2.Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.

<sup>27</sup> 15 дугаар зүйл.Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.2 болон 12.1.4-т заасан зориулалтаар Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.



5.2.16 Тайлант онд авсан 1,211.4 тэрбум төгрөгийн төслийн зээлийн ашиглалтыг салбараар нь авч үзвэл, уул уурхайн салбарт 23.0 хувь, засаглалын салбарт 19.9 хувь, нийгмийн халамжийн салбарт 19.5 хувь, авто замын салбарт 8.1 хувь, орон сууц нийтийн аж ахуйн салбарт 7.9 хувь, эрчим хүчний салбарт 7.5 хувь, бусад салбарт 14.1 хувийг зарцуулсан байна.

5.2.17 Гадаадын зээллэгээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн 19.9 хувь буюу 385.1 тэрбум төгрөгийг нийгэм эдийн засагт үр өгөөж багатай засаглалыг дэмжих салбарт зарцуулсан байна.

5.2.18 Тайлант онд ашиглалт гараагүй, 2014-2021 онуудад гэрээ байгуулсан, 2024-2032 онуудад үндсэн төлбөрөө төлж эхлэх 617.7 тэрбум төгрөгийн 10 гадаад зээлийн үлдэгдэлд 15.3 тэрбум төгрөгийн хүүгийн зардал төлсөн байна. Гадаад төслийн зээлийн ашиглалтыг сайжруулахгүй бол цаашид гадаад зээлийн үйлчилгээний хураамжийн зардлыг нэмэгдүүлэхээр байна. Тухайлбал,

- Азийн дэд бүтцийн хөгжлийн банкны 2021 оноос хэрэгжиж эхэлсэн Ковидын дэмжлэг үзүүлэх 21.0 сая ам.долларын төсөл 50.0 хувийн гүйцэтгэлтэй, хүүгийн зардалд 2.1 тэрбум төгрөг;
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2019 оноос хэрэгжиж эхэлсэн Улаанбаатар хотын ногоон байгууламжийн 95.0 сая ам.долларын төсөл 0.1 хувийн гүйцэтгэлтэй, хүүгийн зардалд 1.7 тэрбум төгрөг;
- БНХАУ-ын Засгийн газрын санхүүжилтээр 2020 оноос хэрэгжиж эхэлсэн Төв цэвэрлэх байгууламжийн 249.6 сая ам.долларын төсөл 58.9 хувийн гүйцэтгэлтэй, хүүгийн зардалд 10.7 тэрбум төгрөг;
- Европын хөрөнгө оруулалтын банкны санхүүжилтээр Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих 29.0 сая ам.долларын хөтөлбөр 34.5 хувийн гүйцэтгэлтэй, хүүгийн зардалд 0.8 тэрбум төгрөг;
- Франц Улсын Засгийн газрын санхүүжилтээр 2020 оноос хэрэгжиж эхэлсэн Нийслэлийн дүүжин замын 60.7 сая ам.долларын төсөл 11.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

5.2.19 Засгийн газрын өрийн баталгаа эргэн төлөлт 720.6 тэрбум төгрөг, ханшийн зөрүү 62.8 тэрбум төгрөгөөр тус тус хасагдаж, 29.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

5.2.20 "Самурай" бондын үндсэн төлбөр 782.1 тэрбум төгрөгийг бүрэн төлж барагдуулсан байна. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн авсан техник туслалцааны хөнгөлөлттэй зээлээс 0.3 тэрбум төгрөгийг эргэн төлж, ханшийн зөрүү 1.0 тэрбум төгрөг хасагдаж, 29.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

5.2.21 Эргэн төлөх концессын өрийн ашиглалт 25.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, эргэн төлөлт 251.6 тэрбум төгрөг, ханшийн зөрүү 6.5 тэрбум төгрөгөөр тус тус буурч, 230.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 28. Барих-шилжүүлэх төрлийн концесс

/тэрбум төгрөг/

№	Төсөл	Төслийн тоо	Эхний үлдэгдэл	2023 онд гүйцэтгэл гарсан	2023 оны эргэн төлөлт	Ханшийн зөрүү	Эцсийн үлдэгдэл
1	Улсын төсөв	10	463.1	25.5	251.6	6.5	230.5
2	Орон нутаг	2	0.4				0.4
	<b>Дүн</b>	<b>12</b>	<b>463.5</b>	<b>25.5</b>	<b>251.6</b>	<b>6.5</b>	<b>230.9</b>

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

5.2.22 Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн төсвийг 4 төсөлд 279.6 тэрбум төгрөгөөр баталж<sup>28</sup>, гүйцэтгэлээр 251.6 тэрбум төгрөгийг төлж, бусад 6 төсөлд эргэн төлөлт төлөвлөөгүй байна.

5.2.23 Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам төсөлд 25.5

<sup>28</sup> Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 оны төсвийн жилд 279,590.4 сая төгрөгийн эргэн төлөлт хийнэ.

тэрбум төгрөгийн ашиглалт гарч, 2023 оны эцэст 67.0 хувийн гүйцэтгэлтэй, бусад бүх ажлын ашиглалт 99.0-100.0 хувийн хэрэгжилттэй байна.

5.2.24 Орон нутгийн зээллэгийн үлдэгдэлд Зорчигч тээвэр ОНӨААТҮГ цахилгаан автобусаар парк шинэчлэл хийх 21.0 тэрбум төгрөгийн гэрээг 2020 онд Монгол Улсын Хөгжлийн банктай байгуулсан байна. Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 2022 онд 4.9 тэрбум төгрөг, 2023 онд 7.8 тэрбум төгрөгийг төлж, 4.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Сүхбаатар /Сүхбаатар/

**БҮЛЭГ 6. ДАВСАН ОРЛОГЫГ ТАЙЛАНТ ОНД ЗАРЦУУЛАХ ЖУРМЫН ЗОХИЦУУЛАЛТ НЬ ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГЫГ БОДИТОЙ ИЛЭРХИЙЛЭХГҮЙ, ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ БАЙНА**

Сангийн сайдын 2022 оны 282 дугаар тушаалаар баталсан журам нь хуулийн шалгууртай уялдсан ч, журмын зарим зохицуулалтыг өөрчлөх шаардлага байна

6.1.1 Тайлант онд нэмэлт төсвөөр 842.8 тэрбум төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн нь өмнөх оноос 389.8 тэрбум төгрөгөөр буурчээ. Нэмэлт төсвийн орлогын эх үүсвэрийн 71.4 хувийг УТЕЗ, 28.6 хувийг ОНТЕЗ бүрдүүлсэн байна.

Хүснэгт 29. Нэмэлт төсвийн санхүүжилтийн эх үүсвэр

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022 оны гүйц	2023 оны гүйц	Бууралт	
			Зөрүү	Хувь
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>1,232.6</b>	<b>842.8</b>	<b>(389.8)</b>	<b>31.6</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	50.6	43.4	(7.2)	14.2
ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	148.2	182.8	34.6	23.3
Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	557.8	358.6	(199.2)	35.7
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	468.8	252.0	(216.8)	46.2
Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	7.2	6.0	(1.2)	16.7

Эх сурвалж: Монгол Улсын 2022, 2023 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

6.1.2 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогод 252.0 тэрбум төгрөг төвлөрснөөс Сангийн сайдын 2023 оны 224 дүгээр тушаалаар 24.4 тэрбум төгрөгийг зарцуулах эрхийг ТЕЗ-дад олгосон байна.

6.1.3 Давсан орлогыг нэмэлт төсвөөр дамжуулан тухайн жилд зарцуулах эрх олгож, зарцуулж байгаа нь төсөвт байгууллагын өөрийн орлогыг бодитой илэрхийлэхгүй, үндэслэлтэй төлөвлөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

**Нэмэлт төсвийг зардлын эдийн засгийн бүх ангиллаар зарцуулж тайлагнасан нь урсгал төсвийн гүйцэтгэлтэй нэгэн адил байна**

6.2.1 Тайлант онд нэмэлт төсвийн зарлага 844.8 тэрбум төгрөг болж өмнөх оноос 401.2 тэрбум төгрөгөөр буюу 32.2 хувиар буурсан байна. Нэмэлт төсвийн нийт зарлагын 71.3 хувийг УТЕЗ, 28.7 хувийг ОНТЕЗ-ийн зардал эзэлж байна.

6.2.2 Нэмэлт төсвийг дараах зардлын эдийн засгийн ангиллаар зарцуулсан байна. Тухайлбал, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 36.9 тэрбум төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 3.2 тэрбум төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 3.1 тэрбум төгрөг, хангамж, бараа материалын зардалд 20.3 тэрбум төгрөг, нормативт зардалд 13.8 тэрбум төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 42.7 тэрбум төгрөг, томилолт, зочны зардалд 52.6 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 197.6 тэрбум төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 203.4 тэрбум төгрөг тус тус зарцуулжээ.

6.2.3 Тайлант онд нэмэлт төсвийн данснаас 82.5 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрснөөс 71.8 тэрбум төгрөг буюу 87.1 хувийг өглөгөөр бүртгэж, дараа жил буцаан олгохоор байна. Тооцоо нийлж өглөгөөр бүртгэсэн нэмэлт санхүүжилтийн шилжүүлгийг Төсвийн ерөнхийлөн захирагчаар нь авч үзвэл, БХС 40.1 тэрбум төгрөг, МУШС 8.1 тэрбум төгрөг, ЗТХС 5.6 тэрбум төгрөг, БШУС 3.9 тэрбум төгрөг, бусад ТЕЗ-ийн 14.1 тэрбум төгрөг байна.

**БҮЛЭГ 7. ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСТ БАЙРШУУЛСАН МЭДЭЭЛЭЛ ХУУЛЬД ЗААСАН ИЖ БҮРЭН, ОЙЛГОМЖТОЙ, АЧ ХОЛБОГДОЛТОЙ БАЙХ ЗАРЧМЫГ БҮРЭН ХАНГАХГҮЙ БАЙНА**

7.1 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3-т заасан төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй байна

7.1.1 Аудитад хамрагдсан байгууллагууд тайлант онд төрийн санхүү, төсвийн үйл ажиллагаатай холбоотой ил тод мэдээлбэл зохих мэдээллийн 2.8 хувийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй, 3.5 хувийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн байна<sup>29</sup>.

7.1.2 Санхүүгийн тайлангийн аудитыг нийцлийн аудиттай хослуулан гүйцэтгэж, нийт 5458 байгууллагыг түүвэрлэн хамруулж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4<sup>30</sup>, 6.8<sup>31</sup>-д заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь, ил тод байршуулаагүй дараах зөрчлийг илрүүллээ. Тухайлбал,

- Тайлант онд төсөвт байгууллага, ТБОНӨҮГ-т хамаарах 168 байгууллага нийт 29.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 393 удаагийн тендер шалгаруулалт, худалдан авалт зохион байгуулсан мэдээллийг ил тод мэдээлээгүй, 140 байгууллага 83.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 503 удаагийн худалдан авалтын үйл ажиллагааны мэдээллийг хугацаа хоцроосон;
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 342.7 тэрбум төгрөгийн 6,448 гүйлгээг 606 байгууллага мэдээлээгүй, 473.0 тэрбум төгрөгийн 5,927 гүйлгээг 261 байгууллага хугацаа хоцроосон;
- Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 525.1 тэрбум төгрөгийн 7,044 гүйлгээг 679 байгууллага мэдээлээгүй, 390.8 тэрбум төгрөгийн 3,852 гүйлгээг 320 байгууллага хугацаа хоцроосон;
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 17.3 тэрбум төгрөгийн 4,696 шийдвэрийг 474 байгууллага мэдээлээгүй, 327.4 тэрбум төгрөгийн 3,913 шийдвэрийг 317 байгууллага хугацаа хоцроосон;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани 0.5 тэрбум төгрөгийн 23 гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроосон;
- Тайлант онд 1,748 байгууллагын ил тод байдалд Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу харьяалах ТЕЗ-д дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

7.1.3 Аудитаар Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах тухай зөвлөмжийг 1,024 байгууллагад, зөрчил арилгуулах албан шаардлагыг 684 байгууллагад, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай албан шаардлагыг 56 байгууллагад тус тус хүргүүлсэн.

7.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай байна

7.2.1 Хуульд заасан орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, тендер, худалдан авалт, төсвийн хэтрэлт, хэмнэлт, төсвийн төсөл зэрэг олон удаагийн давтамжтай мэдээлэл дутуу шивэгддэг, хугацаа хоцордог зөрчил арилахгүй байгаа бөгөөд худалдан авалтын мэдээллийг ил тод бүрэн

<sup>29</sup> Сангийн яамнаас ирүүлсэн шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлэл

<sup>30</sup> Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ 6.4.3."тендерийн баримт бичиг, ...шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан"; 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ", 6.4.8."...төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

<sup>31</sup> Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ 6.8.2."худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, ... шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;"

байршуулахгүй нь залилан, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой эрсдэлийг нэмэгдүүлж байна.

7.2.2 Шинээр үүсгэсэн Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг төсвийн үйл ажиллагаанд ашигладаг системүүдтэй мэдээлэл солилцох, байршуулах үйл ажиллагаа бүрэн бус, мэдээллийг хамрах хүрээний байгууллагаар ангилаагүй, регистрийн дугаараар хайлт хийх боломжгүй, хуулийн шаардлагын дагуу иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой байх зарчмыг бүрэн хангаагүй байна.

7.2.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл байршуулах албан тушаалтнууд солигддог, мэдээлэл байршуулах ажлын зохион байгуулалт хангалтгүй, ТЕЗ-д харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлдэггүй зэрэг нь дээрх зөрчлийг үүсгэх үндсэн шалтгаан болж байна.

7.2.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил арилахгүй байгаа зэргээс шалтгаалан хууль хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай байна.


7.2.5 Төрийн аудитын байгууллагаас 2016-2023 оны хооронд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийгдсэн 8 удаагийн аудитаар төрийн санхүү, төсвийн үйл ажиллагааны ил тод байдлыг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, боловсронгуй болгох асуудлаар Засгийн газарт 17, Сангийн яаманд 1 зөвлөмж / хүргүүлсэн хэдий ч эдгээр зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна.

**БҮЛЭГ 8. ӨМНӨХ ОНЫ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ 60.9 ХУВЬТАЙ БАЙНА**

8.1.1 Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад 7, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 2, Сангийн сайдад 6, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны даргад 2, нийт 17<sup>32</sup> зөвлөмжийг хүргүүлсэн байна.

8.1.2 Аудитын зөвлөмжийн биелэлтийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 11/1068, Сангийн сайд 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 01/2005 дугаар албан бичгээр тус бүр ЯАГ-т ирүүлсэн бол Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга, Төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн зөвлөмжийн биелэлтийг ирүүлээгүй байна.

Дүрслэл 15. Нийт зөвлөмжийн хэрэгжилт /тоо, хувиар/



8.1.3 Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд 90.0 хувь, Сангийн яам 97.2 хувийн хэрэгжилттэй тайлагнасныг аудитаар хянахад Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд 65.4 хувь, Сангийн сайд 80.7 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

8.1.4 Өмнөх онд өгсөн нийт 17 зөвлөмжөөс бүрэн биелсэн 3, хэрэгжих шатандаа 11<sup>33</sup>, хэрэгжүүлээгүй 3, нийт зөвлөмжийн биелэлт 60.9 хувьтай, төсвийн сахилга бат хангалтгүй байна.

8.1.5 Өмнөх оны аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн 2, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны даргад өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

<sup>32</sup> Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд өгсөн Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн үнэлгээ нэгтгэгдээгүй, тусдаа тайлангаар хүргүүлсэн.

<sup>33</sup> Тайлбар: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт ороогүй болно.

**ХАВСРАЛТ: “УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”  
СЭДЭВТ АУДИТЫН ТАЙЛАН**

**ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ,  
ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛЖ ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ  
ШААРДЛАГАТАЙ БАЙНА**

## АГУУЛГА

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	55
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	57
БҮЛЭГ 1. ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, ОЛГОХ САНХҮҮЖИЛТИЙГ ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙГАА НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНГ БУУРУУЛЖ БАЙНА.....	58
<i>Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж байгаа нь өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрах шалтгаан болж байна.....</i>	58
<i>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухайн жилийн санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулж төлөвлөөгүй байна.....</i>	59
<i>Өмнөх оноос шилжин хэрэгжих зарим төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй орхигдуулсан ба төсөл, арга хэмжээний өртгийг нэмэгдүүлэх замаар шинэ арга хэмжээг шилжих нэрээр төлөвлөсөн байна.....</i>	60
<i>Барилга байгууламжийн төсөвт өртөг, нэмэгдэл зардлын тооцоололд тавих хяналт хангалтгүй байна.....</i>	61
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ, ХАРИУЦЛАГА ТООЦОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ДУТМАГ БАЙНА.....	63
<i>Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тухайн жилд төлөвлөсөн санхүүжилт нь 83.2 хувийн гүйцэтгэлтэй байна.....</i>	63
<i>Зарим төсөл, арга хэмжээнд илүү санхүүжилт олгосон, зураг төслөөс зөрүүтэй хийгдсэн ажлыг санхүүжүүлэхдээ бодит гүйцэтгэлд үндэслээгүй байна.....</i>	64
<i>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааг хянах, хариуцлага тооцох арга зам, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.....</i>	67
<i>Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үе шат бүрд тавих захиалагчийн хяналт хангалтгүй, ажлын гүйцэтгэлийг бодитоор баталгаажуулахгүй байна.....</i>	69
<i>Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авахдаа холбогдох дүрмийн хэрэгжилтийг хангахгүй байгаа нь хяналт хариуцлагын тогтолцоонд сөргөөр нөлөөлж байна.....</i>	73
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АЧ ХОЛБОГДЛООР НЬ ЭРЭМБЭЛЖ ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙГАА НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНГ БУУРУУЛЖ БАЙНА.....	76
<i>Төсөл, арга хэмжээг иж бүрэн байдлаар төлөвлөөгүй, барилгын ажил хугацаандаа хэрэгжээгүйгээс зарим төсөл, арга хэмжээний ашиглалт, үр дүн хангалтгүй байна....</i>	76
<i>Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагаар эрэмбэлж төлөвлөхгүй байгаа нь үр ашиг багатай арга хэмжээг санхүүжүүлэхэд хүргэж байна.....</i>	77
ДҮГНЭЛТ.....	79
ЗӨВЛӨМЖ.....	81
ХАВСРАЛТ.....	83



**ЕРӨНХИЙ ЗҮЙЛ****Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалт, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолд үндэслэн Төрийн аудитын байгууллагын хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв..

**Аудитын зорилго, зорилт**

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, аудитын дүн, дүгнэлт зөвлөмжийг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилтын хүрээнд дараах дэд асуудлуудад аудитыг чиглүүлэн хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх;
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

**Аудитын хамарсан хүрээ**

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд болон Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв зэрэг холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэсэн.

**Аудитын арга зүй**

Аудитад гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ыг баримтлан аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх, төлөвлөсөн болон хүрсэн үр дүнг харьцуулан шинжилгээ хийх, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрлэн шалгах зэрэг арга зүйг ашигласан.

**Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт**

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Эрчим хүчний тухай хууль,
- Авто замын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- "Алсын хараа" 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021- 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл",
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр

- Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”,
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”,
- Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт,
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд,
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

#### **Аудитад учирсан хүндрэл, бэрхшээл**

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн бодит байдал, барилга угсралтын ажлын чанарт хяналт хийхэд хүний нөөц хязгаарлагдмал байсан ба зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг цаасан нотлох баримтын хүрээнд хянав. Мөн зарим төсөл, арга хэмжээний захиалагчдаас нотлох баримт ирүүлэх үйл явц удаашралтай, олон жил үргэлжилсэн төсөл, арга хэмжээний баримт материал дутуу байх зэрэг хүндрэл, бэрхшээл байв.

Төсвийн ерөнхийлөн захирагчдад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээлэл дутуугаас нийт төсөл, арга хэмжээний багцын задаргаа, төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилттэй холбоотой судалгааг бодитоор гаргуулж нэгтгэхэд хүндрэлтэй байна.

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд 21 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тухайн оноос эхлэн хэрэгжих 10, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 1129, нийт 7,376.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1139 төсөл, арга хэмжээг 2,686.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ.

*Хүснэгт 1. Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө /сая.төгрөг/*

Ангилал	Шинэ ТАХ			Шилжих ТАХ			Нийт ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга, байгууламж	3	228,875.7	118,033.1	977	6,152,070.2	1,907,550.5	980	6,380,945.9	2,025,583.6
Их засвар	2	35,885.5	35,885.5	69	149,643.0	72,808.3	71	185,528.5	108,693.8
Тоног төхөөрөмж	4	366,079.3	320,299.4	67	362,618.7	171,471.1	71	728,698.0	491,770.5
ТЭЗҮ	1	40,000.0	40,000.0	16	41,072.6	19,967.4	17	81,072.6	59,967.4
<b>Нийт</b>	<b>10</b>	<b>670,840.5</b>	<b>514,218.0</b>	<b>1129</b>	<b>6,705,404.5</b>	<b>2,171,797.3</b>	<b>1139</b>	<b>7,376,245.0</b>	<b>2,686,015.3</b>

Нийт санхүүжилтийн 75.4 хувийг барилга, байгууламж, 18.3 хувийг тоног төхөөрөмж, 4.1 хувийг их засвар, 2.2 хувийг ТЭЗҮ боловсруулах төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар 1369 ТАХ-ний санхүүжилтэд 1,393.8 тэрбум төгрөг төлөвлөсөн бол 2023 онд 1139 ТАХ-нд 2,686.0 тэрбум төгрөг олгохоор төлөвлөж, санхүүжилт өмнөх онтой харьцуулахад 51.9 хувиар өссөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1139 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 77.5 хувь буюу 883 төсөл, арга хэмжээг 2023 онд, 22.5 хувь буюу 256 төсөл, арга хэмжээг дараагийн онуудад үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

*Хүснэгт 2. Төсвийн ерөнхийлөн захирагчдын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө /сая.төгрөг/*

Төсвийн ерөнхийлөн захирагч	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Эзлэх хувь
Боловсрол, шинжлэх ухааны сайд	399	1,634,388.5	529,280.9	19.7
Зам, тээврийн хөгжлийн сайд	120	1,577,015.3	408,821.8	15.2
Барилга, хот байгуулалтын сайд	169	974,575.9	345,152.9	12.8
Соёлын сайд	77	546,000.7	144,237.5	5.4
Эрчим хүчний сайд	42	482,439.0	168,999.1	6.3
Эрүүл мэндийн сайд	106	469,278.2	172,118.7	6.4
Сангийн сайд	6	451,011.0	201,894.5	7.5
Монгол улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга	3	408,523.1	339,743.2	12.6
Монгол улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга	35	162,061.6	48,823.2	1.8
Бусад	182	670,951.7	326,943.5	12.2
<b>Нийт</b>		<b>7,376,245.0</b>	<b>2,686,015.3</b>	<b>100</b>

**БҮЛЭГ I. ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, ОЛГОХ САНХҮҮЖИЛТИЙГ ОНОВЧТОЙ  
ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙГАА НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНГ БУУРУУЛЖ БАЙНА**

*Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж байгаа нь өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрах шалтгаан болж байна*

1.1. Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд барилга байгууламжийн 3, их засварын 2, тоног төхөөрөмжийн 1, ТЭЗҮ боловсруулах 1, нийт 10 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

1.2. Тухайн оноос хэрэгжиж эхлэх 60.3 тэрбум төгрөгийн 67 төсөл, арга хэмжээтэй холбоотой эрх шилжүүлэх шийдвэрийг холбогдох журамд заасан хугацаанд гаргаагүй, хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй, хуулиар баталсан ангилалд хамаарахгүй зарим төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ЭЗХС улсын хэмжээнд хэрэгжүүлэх 40.0 тэрбум төгрөгийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ТАХ-ын багцын задаргааг батлах, эрх шилжүүлэх шийдвэрийг Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан журмын 2.1.7<sup>34</sup>, 2.2.2<sup>35</sup>-д заасан хугацаанаас хоцорч 2023 оны 07 дугаар сарын 27-нд гаргаснаас шалтгаалан 15.2 тэрбум төгрөгийн зураг, төсөл боловсруулах 50 ажлын гэрээ 8-12 дугаар сард байгуулагдсанаар тухайн онд хэрэгжих боломжгүй болж дараа онд шилжсэн;
- МУСНУБХТБҮХД-аас Нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлсэн Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ ТАХ-ний 37.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Нийтийн тээврийн автопарк багцын үнэлгээний хороо тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан;
- Сангийн сайдын багцын "Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах" /Улсын хэмжээнд/ ТАХ-ний 18.0 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс 23 хувийг буюу 4.1 тэрбум төгрөгийг батлагдсан "барилга байгууламж" ангилалд хамаарахгүй БОАЖС, ЕТГД, Дархан-Уул аймгийн Засаг даргын төсвийн багцын нийт 8 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан журмын 4.1.33<sup>36</sup> дахь заалтад нийцээгүй;
- БШУС-ын багцын 5.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий Эрдэнэт Шинжлэх ухаан технологийн паркийн ТЭЗҮ /Орхон, Баян-Өндөр сум/ ТАХ-а Орхон аймгийн Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлэхдээ хөрөнгө оруулалтын ангиллыг зөрүүлж, түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр барилга барих, тоног төхөөрөмж худалдан авах тендер зарлаж гэрээ байгуулсан ба ажлын даалгаврыг дахин боловсруулаагүй, шаардагдах зардал, төсвийг тооцоогүйгээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан 1.7 тэрбум төгрөгөөр ТЭЗҮ хийлгэхээр шийдвэрлэсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 36.1<sup>37</sup>, 36.3<sup>38</sup>, 36.4<sup>39</sup>, 8.2<sup>40</sup>, Сангийн сайдын 2021 оны 103

<sup>34</sup> "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн задаргааг холбогдох шийдвэрийн хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 5 хоногт багтаан хүргүүлнэ"

<sup>35</sup> "Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн тохиолдолд шийдвэрийг тухайн жилийн 2 дугаар сарын 1-ний дотор гаргаж, ажлын 3-5 хоногт багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ"

<sup>36</sup> "Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно"

<sup>37</sup> "Захиалагч шаардагдаж байгаа үйлчилгээний зорилт, хүрэх үр дүн болон бусад шаардлагатай мэдээллийг агуулсан ажлын даалгавар бэлтгэнэ"

<sup>38</sup> "Захиалагч шаардагдаж байгаа үйлчилгээний төсөвт өртгийг тооцохдоо боловсон хүчний мэргэжлийн чиглэл, түвшин, зөвлөхийн ажлын талбайд болон төв байранд ажиллах хугацаа, бичиг хэргийн болон тухайн үйлчилгээнд шаардлагатай бусад зардалд үндэслэсэн байна"

<sup>39</sup> "Захиалагч ажлын даалгавар бэлтгэж, төсөвт өртгийг тооцоолж гаргасны дараа зөвлөхийн жагсаалтад орох саналаа ирүүлэхийг хүссэн урилгыг өдөр тутмын болон бусад хэвлэлд нийтэлнэ"

<sup>40</sup> "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ"

дугаар тушаалаар баталсан үнэлгээний хорооны журмын 4.10<sup>41</sup>, 4.11<sup>42</sup> дэх заалтыг зөрчсөнд тус тус албан шаардлага хүргүүлэв.

1.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан шинээр эхлүүлэх барилга байгууламж, их засварын 5 төсөл, арга хэмжээнээс 3 нь магадлалаар баталгаажсан зураг, төсөвтэй байх шаардлагыг хангаагүй байна. Үүнд:

- НУБХАЗТБҮХД-ын багцын 45.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ ТАХ-ний магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгосон байх шаардлагыг хангаагүй;
- НУБХАЗТБҮХД-ын багцын 45.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Түгжрэлийг бууруулах, хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцолбор барилгын дуусгал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ ТАХ нь төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй;
- ХНХС-ын багцын 0.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Өнөр бүл хүүхдийн төвийн их засварын ажил зураг төсөвтэй байх шаардлагыг хангаагүй байхад төсөвт тусгасан байна.

1.4. Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>43</sup>, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.2.2.2<sup>44</sup>, 3.2.3.4<sup>45</sup>-т заасан шаардлагыг хангахгүй байна.

1.5. Жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталж байгаа нь түлхүүр гардуулах нөхцөлөөр тендер зарлах, батлагдсан төсөвт тааруулан ажлын тоо хэмжээг багасгах, барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, тохижилтын ажил иж бүрэн хийгдэхгүй орхигдох, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг хүлээж хугацаа алдах зэргээр төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх зэрэг хүндрэлийн суурь шалтгаан болж байна.

**Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухайн жилийн санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулж төлөвлөөгүй байна**

1.6. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжих дүнг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулж төлөвлөөгүй, төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилтийг тэнцүү хуваарилах байдлаар тооцож батлаагүй байна. Үүнд:

- ХХААХҮС-ын багцад 2023-2024 онд буюу хоёр жилд хэрэгжих Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/ шинэ ТАХ-ний 2.3 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2.6 дахин багаар буюу 0.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5<sup>46</sup> дахь заалтад;
- Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 2022-2024 онд буюу 3 жилд хэрэгжих 31 төсөл, арга хэмжээний 599.1 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс эхний хоёр жилд ногдох санхүүжилтийг 66 хувиас багагүй хэмжээгээр төлөвлөх ёстой байхад 2 дахин бага буюу 29 хувийг (2022 онд 8 хувь, 2023 онд 21 хувь) санхүүжүүлэхээр баталсан байгаа нь Төрийн

<sup>41</sup> "Үнэлгээний хороо бараа, ажил, үйлчилгээний онцлогоос хамааруулан жишиг баримт бичигт нийцүүлэн тендерийн урилга, тендерийн баримт бичиг, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлт, тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл зэрэг баримт бичгийг боловсруулж, үнэлгээний хорооны гишүүдийн олонх дэмжсэн баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн батлуулахаар захиалагчид хүргүүлнэ";

<sup>42</sup> "Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг багцад хуваах, тендерт оролцогчид тавигдах чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлагын талаар санал гаргахдаа зах зээлийн тооцоо судалгаанд үндэслэх ба тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоогүй шалгуур үзүүлэлт, шаардлага тавихгүй"

<sup>43</sup> "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана"


<sup>44</sup> 3.2.2.2. "Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх";

<sup>45</sup> "Тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх";

<sup>46</sup> "Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах"

хэмнэлтийн тухай хуулийн 16.1.6<sup>47</sup>, 17.1.5<sup>48</sup> заалтад тус тус нийцэхгүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу)

Дүрслэл 1. Эхний хоёр жилд нийт төсөвт өртгийн 66 хувиас багаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн зарим төсөл арга хэмжээ



1.7. Дээрх байдлаар хөрөнгө оруулалтын ТАХ-ний тухайн жилийн санхүүжих дүнг оновчтой төлөвлөхгүй байгаа нь ТАХ-г хугацаанд нь хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж, он дамжин олон жил үргэлжлэх, өртөг нэмэгдэх эрсдэлийг дагуулж байна.

**Өмнөх оноос шилжин хэрэгжих зарим төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй орхигдуулсан ба төсөл, арга хэмжээний өртгийг нэмэгдүүлэх замаар шинэ арга хэмжээг шилжих нэрээр төлөвлөсөн байна**

1.8. Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд шинэ ТАХ-ний тоог хязгаарлаж, өмнөх онуудад эхлүүлсэн шилжих төсөл, арга хэмжээг санхүүжүүлж ашиглалтад оруулах чиглэл баримтлахаар төлөвлөжээ.

1.9. Гэтэл хуулийн төслийн дээрх үзэл баримтлал, чиглэлээ баримтлахгүйгээр, Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6<sup>49</sup> дахь заалтыг зөрчин өмнөх оноос шилжин хэрэгжих болон хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний нэр дээр 12.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй шинээр эхлэх 2 төсөл, арга хэмжээг баталсан байна. Үүнд:

- ХХААХҮС-ийн багцад 2022 оноос 2023 онд шилжин хэрэгжих Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" /Булган/ ТАХ-ний 1.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгийг 6 дахин нэмэгдүүлж Баянхонгор, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Төв, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Хөвд, Хөвсгөл аймагт хэрэгжих 10.2 тэрбум төгрөгийн өртөгтэй шинэ ажлыг;
- ХХААХҮС-ийн багцад 2023 оноос шинээр эхлэн хэрэгжих 2.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/-ыг 2022 оноос шилжих арга хэмжээ нэрээр тусгасан байна.

1.10. Өмнөх онуудад эхлүүлсэн зарим төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусаагүй, гүйцэтгэгч болон захиалагчийн үйл ажиллагаанаас шалтгаалан ажил зогссон байна. Тухайлбал,

- Хорооны цогцолбор барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9, 10 дугаар хороо/ (2020 он);

<sup>47</sup> "Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваасан хэмжээнээс багагүй байхаар батлах"

<sup>48</sup> "Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх"

<sup>49</sup> 27.6. "Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө дараах эрэмбийг баримтална: 27.6.1. шилжих буюу он дамжин хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ; 27.6.2. их засвар, засвар арчлалтын төсөл, арга хэмжээ; 27.6.3. шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ"

- Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ (2010 он);
- Нийслэлийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ (2010 он)
- Спорт заалны барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/ (2018 он);
- Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спорт танхимын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо/ (2012 он);
- Геронтологийн төвийн барилга, дэд бүтэц, 60 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ (2011 он);
- Соёлын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Наран баг/ (2019 он);
- Спорт заалны барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/ (2018 он) зэрэг байна.

1.11. Төсөвт тусгаагүй, орхигдуулсан ТАХ-ний хугацаандаа хэрэгжээгүй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, гэрээг дүгнэн үргэлжлүүлэн санхүүжүүлэх, эсвэл цуцалж хариуцлага тооцох зэргээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, шаардлагатай санхүүжилтийг ирэх онуудын төсөвт тусгах замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.

1.12. Эдгээр нь улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөөгүй, шаардлага, эрэмбэ дарааллыг баримтлаагүйг харуулж байна.

**Барилга байгууламжийн төсөвт өртөг, нэмэгдэл зардлын тооцоололд тавих хяналт хангалтгүй байна**

1.13. БХТ-ийн магадлалын ажлын дүнг нэгтгэн хүргүүлсэн БХБС-ын судалгаа, албан бичиг, магадлалын дүгнэлтүүдэд тулгуурлан улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 566 төсөл, арга хэмжээнд 297.5 тэрбум төгрөгийн бараа материалын үнийн өсөлтийн зөрүү олгохоор төсөвт тусган баталжээ.

1.14. Улсын Их Хурлын 2022 оны 88 дугаар тогтоолын дагуу бараа материалын үнийн өсөлтийн зөрүүг тооцоходоо 2020 онд улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээж авсан дараах 3 төсөл, арга хэмжээнд 0.3 тэрбум төгрөг төлөвлөж, санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Сум дундын эмнэлгийн барилга /Дундговь, Эрдэнэдалай сум/ төсөл, арга хэмжээг улсын комиссын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн БА-01/2020 дүгнэлтээр ашиглалтад оруулсан байхад 2023 оны 02 дугаар сарын 17-нд 0.2 тэрбум төгрөгийн материалын үнийн өсөлтийн зөрүүг тооцож олгохоор нэмэлт гэрээ байгуулсан;
- Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжтай жишиг гудамж төсөл /Хөвсгөл, Мөрөн сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд 2020 оны 12 дугаар 14-ний өдөр Улсын комисс ажиллаж УКД-2020/84, УКД-2020/85 тоот актаар хүлээж авсан байхад материалын үнийн өсөлтийн зөрүүд 0.05 тэрбум төгрөг төлөвлөж санхүүжүүлсэн;
- Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Мөрөн сум, 10, 11, 12, 13, 14 дүгээр баг/ төсөл, арга хэмжээний 2 барилгыг 2020 онд улсын комисс ажиллан УКД-2020/46, УКД-2020/71 тоот актаар байнгын ашиглалтад хүлээн авсан байхад материалын үнийн өсөлтийн зөрүүд 0.04 тэрбум төгрөг тус тус төлөвлөж санхүүжүүлсэнд албан шаардлага хүргүүлэв.

1.15. Энэ нь Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 75 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих барилга байгууламжийн төсөвт өртгийн /барилгын материалын үнэ/ өөрчлөлтийг тооцох түр журам"-ын 2.1<sup>50</sup> дэх заалтад нийцээгүй байна.

1.16. Төсөвт өртөг нь нэмэгдэж батлагдсан 17 төсөл, арга хэмжээний нэмэлт гэрээг байгуулахдаа гүйцэтгэгчийн тендэрт санал болгосон 0.6 тэрбум төгрөгийн хэмнэлтийг хасаж тооцоогүйд гэрээний үнийн дүнг бууруулах албан шаардлага хүргүүлж, илүү олгосон санхүүжилтийг улсын төсөвт буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу/

1.17. Дээрх байдлаар нэмэлт санхүүжилтийн гэрээг байгуулахдаа тендерийн хэмнэлтийг хасаж тооцоогүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>51</sup>, ТБОНӨХБАУХАТХ-

<sup>50</sup> "Энэ журмаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээг байгуулсан бөгөөд 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших үлдэгдэл ажилд материалын үнийн дундаж өсөлтөөр тооцоход хамаарна"

<sup>51</sup> 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"

ийн 6 дугаар зүйлийн 6.1<sup>52</sup>, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3<sup>53</sup> дахь заалтад нийцээгүй байна.

1.18. Зарим төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулсан төсвийн дүнгээс илүү тусгасан, хэсэгчилсэн болон нэгдсэн магадлалын дүнг давхардуулан тооцож нэмэлт гэрээ байгуулан санхүүжүүлсэн 3.3 тэрбум төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- ЭХС-ын багцын Сумын төвийн байгууллагуудын дулаан хангамжийн систем /Хэнтий, Баян-Овоо сум/ төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэлтэй холбоотой магадлалаар баталгаажсан зураггүй, анхны гэрээний хүрээнд төлөвлөсөн ажлууд бүрэн хийгдэж, улсын комисс хүлээн авсан байхад төсөвт өртгийг 0.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны төсөвт тусгасан;
- Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Дадал сум/ ТАХ-ний төсөвт өртгийг 2021 оны 11 дүгээр сарын 08-ны магадлалын ерөнхий дүгнэлтээр 2.2 тэрбум төгрөгөөр баталгаажуулсан байхад ажил гүйцэтгэх гэрээнд 2023 оны 05 дугаар сарын 17-нд нэмэлт өөрчлөлт оруулахдаа дээрх дүнгээс 0.2 тэрбум төгрөгөөр илүү дүнгээр гэрээ байгуулж, эмнэлгийн барилгын засварын ажлыг гүйцэтгүүлсэн;
- БШУС-ын багцын Сургуулийн барилга, 320 суудал /Хэнтий, Жаргалтхаан сум/ ТАХ-ний барилгын материалын үнийн өсөлтийн зөрүүг баталгаажуулсан БХТ-ийн 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 88-086/2022 дугаартай магадлалын дүгнэлтийн үнийн дүн 1.1 тэрбум төгрөгийг 2022 оны 08 дугаар сарын 15-ны 1448/2022 дугаартай магадлалаар баталгаажуулсан нийт төсөвт өртгийн 7.0 тэрбум төгрөгийн дүнтэй давхардуулан тооцож илүү дүнгээр гэрээ байгуулсан;
- БШУС-ын багцын Дотуур байрны барилга, 100 ор /Хэнтий, Дэлгэрхаан сум/ ТАХ-ний барилгын материалын үнийн өсөлтийн болон нийт төсөвт өртгийн магадлалын дүгнэлтийг давхардуулан 1.6 тэрбум төгрөгийг илүү тооцож, гэрээ байгуулсан зөрчилд тус тус төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүлээ.

1.19. Энэ нь Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5<sup>54</sup>, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн 6 дугаар зүйлийн 6.17<sup>55</sup>, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйл 41.1.2<sup>56</sup>, Төсвийн тухай хуулийн 6.4.1<sup>57</sup> дэх заалттай тус тус нийцээгүй байна.

1.20. Дээрх байдлаар төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний гэрээнд өөрчлөлт оруулахдаа ХАА-нд анх санал болгосон тендерийн хэмнэлтийг хасаж тооцохгүй байх, магадлалын дүгнэлтийг давхардуулан тооцож, төсөвт өртгийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж байгаа зэрэг нь төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчимд нийцэхгүй байна.

1.21. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тэргүүлэх ач холбогдол, хүрэх үр дүн, шилжих болон шинээр эхлэхээр эрэмбэлж, төлөвлөлтийн шаардлага хангасан тохиолдолд төсөвт тусгах, хэрэгжүүлэх хугацаатай уялдуулан санхүүжилтийг төлөвлөх зарчмуудыг хэрэгжүүлэхгүй байгаа нь төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй удаашрах, өртөг нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.

<sup>52</sup> 6.1. "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална";

<sup>53</sup> 13.1.3. "Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх"

<sup>54</sup> 25.5. "Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ";

<sup>55</sup> 6.17. "Магадлал хийж баталгаажсан зураг төслийг болон барилга байгууламжийн нэг маягийн зургийг давтан хэрэглэх тохиолдолд ажлын зургийн өөрчлөлт орсон хэсэгт магадлал хийлгэнэ";

<sup>56</sup> 41.1.2. "Энэ хуулийн 40.4, 40.6-д зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөхийг хориглоно";

<sup>57</sup> 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"



**БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ,  
ХАРИУЦЛАГА ТООЦОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ДУТМАГ БАЙНА**

*Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тухайн жилд төлөвлөсөн санхүүжилт нь 83.2 хувийн гүйцэтгэлтэй байна*

2.1. Хөрөнгө оруулалтын нийт төсөл, арга хэмжээний тухайн жилийн санхүүжилтэд 2,686.0 тэрбум төгрөг төлөвлөснөөс ТЕЗ нар гүйцэтгэлээр 83.2 хувь буюу 2,233.9 тэрбум төгрөгийг санхүүжүүлж, 13.8 хувь буюу 371.9 тэрбум төгрөгийг санхүүжилтийг Засгийн газрын 2023 оны 456 дугаар тогтоолоор барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан, харин үлдэх 3 хувь буюу 80.2 тэрбум төгрөг нь тендерийн хэмнэлт болон гэрээ байгуулагдаагүй төсөл, арга хэмжээний санхүүжилт байна.

2.2. ТЕЗ-дийн барьцаа хөрөнгийн дансанд жил бүр ЗГ-ын тогтоолоор төсөл, арга хэмжээний санхүүжүүлээгүй үлдэгдлийг байршуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3<sup>58</sup>, 43.1.5<sup>59</sup>-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" заалттай нийцэхгүй байна.

2.3. Тухайн жилд төлөвлөсөн ТАХ-ний санхүүжилтийг тодорхой нөхцөл, шалгуур үзүүлэлтгүйгээр барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, дараагийн онуудад санхүүжүүлж байгаа нь ТАХ-ний хэрэгжилт, санхүүжилтийн зарцуулалтад тавих хяналтыг сулруулж байна.

2.4. Тухайлбал багцад задарсан нийт 75 ТАХ-ний 2019-2022 оны санхүүжилт 21.6 тэрбум төгрөг ТЕЗ нарын барьцаа дансанд 2024 оны 4 дүгээр сар хүртэл 2-5 жилийн хугацаанд байршиж байна. Үүнд:

- ХНХС-ын барьцаа хөрөнгийн дансанд 1 ТАХ-ний 0.2 тэрбум;
- ХХААХҮС-ын барьцаа хөрөнгийн дансанд 2 ТАХ-ний 1.3 тэрбум;
- БШУС-ын барьцаа хөрөнгийн дансанд 12 ТАХ-ний 1.4 тэрбум;
- ЭЗХС-ын барьцаа хөрөнгийн дансанд 44 ТАХ-ний 13.7 тэрбум;
- БХБС-ын барьцаа хөрөнгийн дансанд 16 ТАХ-ний 5.0 тэрбум төгрөгийн хийгдээгүй ажлынсанхүүжилт тус тус байршиж байсанд төсөвт төвлөрүүлэхээр акт тогтоож, албан шаардлага хүргүүлэв.


2.5. Хуульд тусгасан тухайн жилийн санхүүжилтээс 9 ТЕЗ 23 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бууруулан 27 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар 175.8 тэрбум төгрөгийн зохицуулалтыг төсөвтөө багтаан хийсэн байна.

2.6. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийг БХС, СЗХД, УЕП нь тус тус 100 хувь буюу бүрэн ашигласан бол ЭЗХС 54 хувьтай, НУБХАЗТБҮХД 38 хувьтай буюу хэрэгжилт хангалтгүй байна.

<sup>58</sup> 43.1.3. "Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээгээр болон олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөв";

<sup>59</sup> 43.1.5. "Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан тусламж, хандив";

Дүрслэл 2. Хөрөнгө оруулалтын тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь, /ТЕЗ бүрээр/



2.7. ЭЗХС улсын хэмжээнд хэрэгжүүлэх төслийн задаргааг батлах, эрх шилжүүлэх шийдвэрийг хугацаа хоцорч гаргасан, НУБХАЗТБҮХД-ын багцад төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширч, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүйд хүргэсэн байна.

**Зарим төсөл, арга хэмжээнд илүү санхүүжилт олгосон, зураг төслөөс зөрүүтэй хийгдсэн ажлыг санхүүжүүлэхдээ бодит гүйцэтгэлд үндэслээгүй байна**

2.8. Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүйгээс ТЕЗ нар гүйцэтгэгчид илүү санхүүжилт олгосон, зураг төслөөс өөрчилж гүйцэтгэсэн тохиолдолд өөрчлөлтийн зураг төсвийг гаргуулж зохиогч, захиалагчаар хянуулаагүй, ажлын гүйцэтгэлээ өөрчлөлт оруулсан бодит гүйцэтгэлээр бус анхны зураг, төсвийн дүнгээр тооцож гаргасныг баталгаажуулж, санхүүжүүлсэн байна. Тухайлбал,

**Төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон:**

- БШУС-ын багцаас эрх шилжин хэрэгжсэн 2.8 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 43 дугаар хороо/ ТАХ-ний ажлын бодит гүйцэтгэл 48 хувьтай байхад санхүүжилтийн 98 хувийг олгосон;
- БШУС-ын багцын Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/ ТАХ-ний 7.6 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй ажлын бодит гүйцэтгэл 82 хувьтай байхад санхүүжилтийн 90 хувийг олгосон;
- БШУС-ын багцын Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, 31 дүгээр сургууль ТАХ-ний 2.6 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй ажлын бодит гүйцэтгэл 78 хувьтай байхад санхүүжилтийн 91 хувийг олгосон;
- БШУС-ын Жавахлант цогцолбор сургуулийн 2 дугаар байрны барилга /Завхан, Улиастай сум/ ТАХ-ний спорт заал болон туслах өрөөнүүдийн шал, хувцас солих өрөө, багш нарын өрөөний тохижилтын ажлыг хийж гүйцэтгээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон;
- БШУС-ын багцын Цэцэрлэгийн барилга, 150 ор /Сүхбаатар, Дарьганга сум/ ТАХ-ний 2 дугаар давхрын дотор хана, тааз, багана, дам нурууг тэгшлэх, шавардах ажил, 1 дүгээр давхрын тааз, дам нуруу тэгшлэх ажлыг гүйцэтгээгүй, бодит гүйцэтгэл 69.7 хувьтай байхад үнийн өсөлтийн нэмэгдлийг бүрэн олгож, нийт 0.1 тэрбум төгрөгийн санхүүжилт илүү олгосон;
- БШУС-ын багцын Багшийн хөгжлийн төвийн барилга /Ховд, Жаргалант сум/ ажлын бодит гүйцэтгэлийг хянаагүйгээс 0.4 тэрбум төгрөгийн санхүүжилт илүү олгосон;

- БХБС-ын багцын Цэвэрлэх байгууламжийн засвар, шинэчлэл /Дархан-Уул, Хонгор сум/ ТАХ-ний ажлаас 0.03 тэрбум төгрөгийн сургалт, зүгшрүүлэлт, туршилт тохируулгын ажлыг гүйцэтгээгүй байхад санхүүжилтийг олгосон;
- БХБС-ын багцын Соёл амралтын хүрээлэн /Сүхбаатар, Баруун-Урт сум/ ТАХ-ний дугуйн болон гүйлтийн зам, авто зогсоолын талбайн ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс 0.3 тэрбум төгрөгөөр илүү олгосон;
- ЗГХЭГД-ын багцын Засаг даргын Тамгын газрын барилга /Завхан, Шилүүстэй сум/ ТАХ-ний зураг төсөвт тусгасан тогооны барилгын оронд гадна ханыг тоосгоор өнгөлсөн, дээврийн ажил, гадна зам талбай, зүлэгжүүлэлтийн ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байхад санхүүжилтийн 98.4 хувийг олгосон;
- БОАЖС-ын багцын Дарьганга зусланг орчин үеийн стандартад нийцсэн амралт, аялал жуулчлалын цогцолбор болгон шинэчлэх /Сүхбаатар, Дарьганга сум/ ТАХ-ний барилгын ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс 0.08 тэрбум төгрөгөөр илүү олгосон;
- ОНБТСҮХД-ын багцын Спорт цогцолборын барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум/ ТАХ-ний ногоон байгууламж, талбайн тохижилтын ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс 0.1 тэрбум төгрөгөөр илүү олгосон;
- ЗТХС-ын багцын Сумын төвийн хатуу хучилттай авто зам 3.6 км, 4 замын уулзвар /Сүхбаатар, Мөнххаан сум/ ТАХ-ний 460 м автозамын болон явган хүний замын хашлага, 120 м замын асфальтан хучилтын ажлыг гүйцэтгээгүй байхад гүйцэтгэлийг баталгаажуулж, санхүүжилтийг олгосон;
- ХНХС-ын багцын Ахмадын төвийн барилга /Хөвсгөл, Баянзүрх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/ ТАХ-ний Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдын барилгын салхивчийн ажил, гадна цахилгаан хангамжийн 0.4 кв-ын кабель шугамын ажил, 0.4 кв-ын агаарын шугамын ажил, гадна гэрэлтүүлгийн ажил, ариутгах татуургын ажил, бохир усны цооногийн ажлыг гүйцэтгээгүй байхад 0.2 тэрбум төгрөгийн санхүүжилт илүү олгосон;
- Соёлын сайдын багцын Соёл, урлагийн ордон 500 хүн /Дорноговь, Замын-Үүд сум, 3 дугаар баг/ ТАХ бодит гүйцэтгэлээр 68 хувьтай байхад санхүүжилтийн 80 хувийг олгосон;
- Соёлын сайдын Олон угсаатны театрын барилга /Хөвд, Жаргалант сум/-ын ажлын бодит гүйцэтгэлийг хянаагүйгээс 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилт тус тус илүү олгосонд тус тус албан шаардлага хүргүүлэв.

**Зураг төсөвт өөрчлөлт оруулахдаа өөрчлөгдсөн төсвөөр бус анхны төсвөөр гүйцэтгэл гаргаж санхүүжилт авсан:**

- ХХААХҮС-ын багцын Хүнс, ногооны агуулахын барилга, 500 тонн /Хөвсгөл, Мөрөн сум/ болон Хүнсний ногооны зорь, 500 тонн /Хөвсгөл, Мөрөн сум/ ТАХ-ний зураг төсөвт өнгөлгөөтэй тоосгон хана, чулуун хөвөн дулаалга, гантиг чулуун шат довжоо төлөвлөснийг гүйцэтгэгч 2 компани блокон хана, хөөсөнцөр дулаалгаар, гантиггүй шат довжоо хийсэн ч зураг, төсвийн дагуу хийснээр гүйцэтгэл гарган санхүүжилт олгосон;
- БОАЖС-ын багцын Дарьганга зусланг орчин үеийн стандартад нийцсэн амралт, аялал жуулчлалын цогцолбор болгон шинэчлэх /Сүхбаатар, Дарьганга сум/ ТАХ-ний барилгыг чулуун хөвөнгөөр дулаалахаар зураг төсөлд тусгасныг хөөсөнцөрөөр, 3 давхар шилтэй вакум цонхын 2 давхар шилтэйгээр гүйцэтгэсэн;
- БШУС-ын багцын Сургуулийн барилга, 960 суудал /Сүхбаатар, Баруун-Урт сум, 5 дугаар сургууль/ ТАХ-ний барилгын зураг төсөлд коридорыг чулуун шалтайгаар төлөвлөснийг өөрчилж хулдаас дэвссэн боловч чулуун шалны материалын үнийн өсөлт тооцож олгосон;
- БШУС-ын багцын Дотуур байрны барилга, 100 ор /Сүхбаатар, Түвшинширээ сум/ барилгын дээврийг мембран хучилттай төлөвлөснийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хар цаасаар хийж гүйцэтгэсэнд албан шаардлага хүргүүлэв.

**ЭХС-ын багцын 22.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Дулааны станц /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/:**

- Дулааны станцын барилгын үйлчилгээний хэсгийн өрөөний хаалга, цонхны амлагаа болон станцын барилгын сэндвич ханануудын залгаас, уулзвар хангалтгүй, цонхны 6 тавцан угсраагүй, эвдэрч гэмтсэн хэсгүүдийг засаагүй, улсын комиссын үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй;

Сүхбаатар /Хонгор сум/ ТАХ-ний ажлаас 0.03 тэрбум төгрөгийн сургалт, зүгшрүүлэлт, туршилт тохируулгын ажлыг гүйцэтгээгүй байхад санхүүжилтийг олгосон;

- Авто зогсоолын ажлын төсөвт тусгасан асфальт бетон хольцыг бетон зуурмаг болгон өөрчилж гүйцэтгэснийг зохиогч, захиалагчтай зөвшилцөөгүй, өөрчлөлтийн зураг, төсвийг гаргуулаагүй;
- Дулааны станцын гурван зуухны утаа сорогчийн дугуйн гол дагаж их хэмжээний ус гоожиж, зэв тогтсон, ажлын дугуйн баланс тохируулаагүйгээс доргио зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрч эвдрэх, үүнээс улбаалан осол гарах эрсдэл үүсэхээр байгаа зэрэг зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлэв.

**БХБС-ын багцын 23.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Үерийн усны хамгаалалтын далан /Баян-Өлгий, Өлгий сум/:**

- Үерийн сувгийн ёроолыг угсармал төмөр бетон хавтангаар гүйцэтгэхээр зураг төсөлд тусгасныг цементэн зуурмагт чулуу шигтгэж хийсэн,
- Шороон сувгийн ёроолын өргөнийг зураг төсөлд тусгасан хэмжээнээс 1-2 метрээр багасгаж нарийсгасан,
- Сувгийн улны бетон бэлтгэлийн дээр хар цаас дэвсэхээр зураг төсөлд тусгасныг хийгээгүй,
- Угсармал бетон хавтан болон бусад хийцийг цутгахдаа зураг, төсөлд тусгасан арматурын хэмжээнээс нарийн диаметр тэйгээр, арматур хоорондын зайг ихэсгэж гүйцэтгэсэн, зарим цутгамал бетон хийцийн бат бэх чанар буюу бетоны марк зураг төсөлд тусгаснаас бага буюу шаардлага хангаагүй,
- Сувгийн хажуу налуугийн бэхлэгээний цутгамал бетоны ирмэгийн өргөний хэмжээг зураг төсөлд тусгаснаас зөрүүтэй хийснийг тоо хэмжээний зөрүүг тооцож гэрээний үнийн дүнг өөрчлөх, зарим чанаргүй ажлыг дахин гүйцэтгүүлэхээр албан шаардлага хүргүүлэв.

**НУБХАЗТБҮХД-ын багцаас Нийслэлийн Засаг даргад эрх шилжин хэрэгжсэн 318.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Нийтийн тээврийн автобус /Улаанбаатар/:**

- Нийслэлийн ЗДТГ-аас нийт 810 автобус, цахилгаан автобусны 41 цэнэглэгчийг худалдан авахаар 272.2 тэрбум төгрөгийн гэрээг байгуулж, урьдчилгаа болон 4 удаагийн гүйцэтгэлийн санхүүжилтээр нийт 134.6 тэрбум төгрөгийг гүйцэтгэгчид олгосон боловч стандартад заасан шаардлага, техникийн тодорхойлолтод нийцээгүй автобус нийлүүлсэн зөрчил илэрснийг хууль хяналтын байгууллага шалгаж хүлээлгэн өгсөн 125 автобус, 41 цэнэглэгчийн бодит гүйцэтгэлийг 46.1 тэрбум төгрөгөөр үнэлж, төсөвт учруулсан хохирлын хэмжээг 76.5 тэрбум төгрөгөөр тогтоон, 12.0 тэрбум төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2.9. Дээрх байдлаар захиалагч болон үе шатны хяналт хэрэгжүүлэгч нь ТАХ-ний гүйцэтгэлийг баталгаажуулж санхүүжүүлэхдээ бодит гүйцэтгэлд үндэслэхгүй байгаа нь Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 4.8.12-д "Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгоно" гэж заасныг зөрчсөн байна.

2.10. Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн зарим машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үзүүлэлтүүд стандарт, техникийн тодорхойлолт заасан шаардлагад нийцээгүй байна. Тухайлбал,

- НУБХАЗТБҮХД-ын багцаас Нийтийн тээврийн автобус /Улаанбаатар/ ТАХ-ний гүйцэтгэгчийн нийлүүлсэн их, дунд багтаамжийн 135ш автобус тэргэнцэртэй иргэнд зориулсан хэсэгтэй байх, зорчих тавцангийн налуу 12 градусаас ихгүй, гишгүүр болон шалны өндөр 30см-ээс ихгүй, хаалга бүрийн гадна талд гэрэлтүүлэгтэй, жолоочийн хэсэг бүхээгтэй, хажуугийн шил нь бууралттай, давхар байх, зорчигчдын суудал бүрд гар утас, нэмэлт төхөөрөмж цэнэглэгч байршуулсан байх, босоо зорчигчдын тоо 40-өөс дээш, зааланд 6-аас доошгүй халаалтын төхөөрөмжтэй, мөнгөний хайрцаг, хогийн сав, камер, хянах системтэй, жолоочийн суудлыг сайжруулсан савхин материалаар хийсэн байх зэрэг шаардлагыг хангаагүй, 2 автобус тээвэрлэх явцад эвдэрч гэмтсэн байхад хүлээн авсан;
- ХХААХҮС-ын багцын 3.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Бэлчээрийн усан хангамж /Улсын хэмжээнд/ ТАХ-ний хүрээнд инженерийн хийцтэй 88 худаг гаргах, барих ажилд аймгуудын ХХААХҮГ захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 4 худгийн барилга, цонх, хаалга, шал, усан сан, мотор, цахилгааны үүсвэр, мал услах талбайг зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй байхад байнгын ашиглалтад хүлээн авсан байна.

2.11. Тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан байгууллага нь техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагын талаарх мэдээллээр хүлээн

авах комиссын бүрэлдэхүүнийг бүрэн хангаагүй, техникийн үзүүлэлт, шалгуур бүрээр комиссын гишүүд хянаагүй, хүлээлцсэн акт, хурлын тэмдэглэлд дурдаагүй байгаа нь шаардлагад нийцээгүй хөрөнгийг хүлээн авч санхүүжүүлэх эрсдэлийг дагуулж байна.

2.12. Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо барьцаа хөрөнгийг суутган тооцоогүй, зарцуулагдаагүй магадалшгүй ажлын зардлыг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй, норм, нормативын зардлыг холбогдох байгууллагад шилжүүлээгүй, холболтын зураг төслийг иж бүрэн зураг төслийн үнээр тооцож гэрээ байгуулан илүү санхүүжилт олгосон байна. Үүнд:

- ХНХС-ын багцын Өнөр бүл хүүхдийн төвийн их засвар /Улаанбаатар/ ажлыг гүйцэтгүүлэх 0.3 тэрбум төгрөгийн гэрээний сүүлийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгохдоо чанарын баталгааны 0.01 тэрбум төгрөгийг суутган тооцоогүй зөрчил илэрсэнд албан шаардлага;
- ЭХС-ын багцын 1 ТАХ-ний 0.01 тэрбум төгрөгийн магадалшгүй ажлын зарцуулагдаагүй санхүүжилтийг төсөвт төвлөрүүлээгүй байсанд төлбөрийн акт;
- ХХААХҮС-ын багцын Хүнсний ногооны зорь, 500 тонн /Хөвсгөл, Мөрөн сум/ барилгыг нэг маягийн зургаар төлөвлөн холболтын зураг, төсвийг гүйцэтгүүлэхдээ иж бүрэн зураг төслийн үнээр гэрээ байгуулан гүйцэтгэгчид 0.02 тэрбум төгрөг илүү олгосныг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.13. Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах, журам”-ын 2.3.2.5<sup>60</sup> дахь заалтыг зөрчсөн байна.

2.14. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, барилга байгууламжийн ажлын үе шат бүрд тавих хяналт хангалтгүйгээс гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон, зураг төслөөс зөрүүтэй гүйцэтгэсэн ажлыг бодит гүйцэтгэлээр бус анхны зураг, төсвөөр санхүүжүүлсэн байна.

**Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааг хянах, хариуцлага тооцох арга зам, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна**

2.15. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 1139 ТАХ-ээс 883 төсөл, арга хэмжээг 2023 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсний 62.5 хувь буюу 552 ТАХ хэрэгжсэн, 37.5 хувь буюу 331 ТАХ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна.

2.16. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад үүссэн хүндрэл бэрхшээл, тулгарсан асуудлын шалтгаан, үр дагаврыг судлаагүй, шийдвэрлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлээгүй, зарим тохиолдолд албан бичгээр харилцаагүй нь хугацаа алдах, удаашрах, хэрэгжихгүй зогсонги байдалд хүргэхэд нөлөөлж байна. Тухайлбал,

- Соёлын сайдын багцад 2011 оноос эхлэн хэрэгжсэн 10.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Төв халх” дуулалт жүжгийн театр /Дундговь, Сайнцагаан сум/ ТАХ-ний гүйцэтгэгч гэрээний үүргээ хэрэгжүүлээгүйгээс шалтгаалан барилгын ажил зогссон;
- БШУС-ын багцад 2014 оноос эхлэн хэрэгжсэн 0.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сэлэнгэ, Мандал сум/ ТАХ-ний гүйцэтгэгч 2020 оноос төсөвт өртөг хүрэлцээгүй шалтгаанаар ажлаа гүйцэтгээгүй зогсоосон, 2023 онд гэрээг цуцлах албан тоот хүргүүлсэн;
- ЭМС-ын багцад 2011 оноос эхлэн хэрэгжсэн 1.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Төрөх эмнэлэг, 50 ор /Дорноговь, Сайншанд/ ТАХ-ны санхүүжилтийг гүйцэтгэгчид бүрэн олгосон боловч барилга угсралтын явцад барилгын норм, дүрмийг зөрчсөн, 2014 оноос төсвийн норм дүрэм шинэчлэгдсэн, бараа материалын үнэ өссөн зэрэг шалтгаанаар барилгын ажил зогссон, Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн нэхэмжлэлтэй шүүхэд шилжсэн боловч шийдэгдээгүй;
- Соёлын сайдын багцад 2013 оноос эхлэн хэрэгжсэн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Соёл, урлагийн ордон, 500 суудал /Дорноговь, Замын-Үүд сум, 3 дугаар баг/ ТАХ-ний захиалагчийн хяналтыг БХТ-өөс хэрэгжүүлэн 2.8 тэрбум төгрөгийн

<sup>60</sup> 2.3.2.5. “Барилга байгууламжийн зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх”;

санхүүжилт олгосон, барилга угсралтын явцад гал гарч зарим ажлыг шинэчилж хийсэн боловч 2015 оноос барилгын ажил зогссон зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн боловч тодорхой шийдвэр гараагүй;

- Соёлын сайдын багцад 2021 оноос эхлэн хэрэгжсэн 2.3 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Соёлын төвийн барилга, 300 суудал /Сүхбаатар, Баяндэлгэр сум/ ТАХ-ний барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьтай, гүйцэтгэгч 2023 онд дуусгах гэрээний үүргээ гүйцэтгэгч хэрэгжүүлээгүй;
- БШУС-ын багцад 2019 оноос хэрэгжсэн 2.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Баяндэлгэр сум/ болон 2.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/ ТАХ-ний гүйцэтгэгч компаниуд гэрээний үүргээ хэрэгжүүлээгүйгээс шалтгаалан 2022 оноос хойш ажил зогссон, гэрээний хариуцлага тооцох, гэрээ цуцлуулах талаар Сүхбаатар аймгийн Засаг даргаас Боловсролын ерөнхий газарт 2022 оны 9 дүгээр сард албан бичиг хүргүүлсэн байна.

2.17. Мөн гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь хэрэгжүүлээгүй тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа, үе шат дараалал, захиалагч талаас гаргах шийдвэр, хариуцах байгууллага, албан тушаалтан, хүлээлгэх хариуцлагатай холбоотой нарийвчилсан зохицуулалт хангалтгүй, гэрээг сунгах шалгуур, эрх зүйн зохицуулалт заавар журамд тодорхой бус байна.

2.18. Үүнээс шалтгаалан гэрээний үүргээ хугацаанд нь хэрэгжүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцох, хугацаатай үүрэг чиглэл өгөх, гэрээг цуцлах, гүйцэтгэлийн баталгааг төсөвт төвлөрүүлэх чиг үүрэг хэрэгжихгүй байна. Тухайлбал,

- ХХААХҮС-ын багцад 2021 оноос эхлэн хэрэгжсэн Малын тэжээл тариалах, нөөц бүрдүүлэх төсөл /Хөвсгөл, Жаргалант, Галт, Цэцэрлэг, Цагаан-Уул, Улаан-Уул, Их-Уул сум/ ТАХ-ний 0.9 тэрбум төгрөгийн гэрээг 2023 оны 3 дугаар сард цуцалсан боловч гэрээг дүгнэж, захиалагчид учирсан хохирол алдангийг тооцоогүй, гүйцэтгэлийн баталгаагаар хангуулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй;
- Соёлын сайдын багцын Хан-Хэнтий чуулгын барилга /Хэнтий, Хэрлэн сум/ ТАХ-г 2011-2012 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч гэрээний хэрэгжилт удааширнаас 0.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгөөр хийгдсэн заслын ажлыг дахин засварласан;
- Соёлын сайдын багцад 2022 оноос эхлэн хэрэгжсэн 4.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолборын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/ ТАХ-ний гүйцэтгэгч 2022 онд урьдчилгаа төлбөрийн баталгаа гарган 0.5 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан боловч 2 жилийн хугацаанд гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй байхад захиалагч гэрээг дүгнээгүй, учирсан хохирол алдангийг тооцоогүй, урьдчилгаа төлбөрийн баталгааг гаргуулаагүй зөрчилд тус тус албан шаардлага хүргүүлэв.

2.19. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх "техник, эдийн засгийн үндэслэл" боловсруулах ажлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, зарцуулах зардал, төсвийг тооцож төлөвлөхөд баримтлах жишиг үнэ, ажлын даалгавар боловсруулахад тавигдах шаардлага, хүлээн авахтай холбоотой эрх зүйн зохицуулалт, заавар журам хангалтгүй байна. Тухайлбал,

- Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл /Орхон, Баян-Өндөр сум/ ТАХ-ний гэрээнд 2023 оны 12 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт оруулан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын үнийн дүнг 1.8 тэрбум төгрөгөөр тусгасан боловч гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын даалгаврыг боловсруулж батлаагүй, гүйцэтгүүлэх ажлын өртгийг тооцоогүй, гэрээний үнийн дүнгийн үндэслэл, үнэлгээ нь тодорхойгүй байхад 2023 оны 12 дугаар сард Орхон аймгийн ГХБХБГ, Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн паркийн захиргаа нь гүйцэтгэгчээс ирүүлсэн материалыг шалгуур үзүүлэлтгүйгээр хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосонд албан шаардлага өгөв.

2.20. Түүнчлэн хөрөнгө оруулалтын ТАХ-ний тендерийн баримт бичигт ажиллах хүчний дотоодын давуу эрх тооцуулж, шалгарсан тохиолдолд түүний хэрэгжилтийг тайлагнах, хянах арга зам, хариуцах байгууллага, албан тушаалтан, гүйцэтгэгчид хүлээлгэх хариуцлагатай холбоотой зохицуулалтыг тусгаагүй нь худалдан авах ажиллагаанд баримтлах өрсөлдөх тэгш боломжтой, хариуцлагатай байх зарчмыг алдагдуулж байна. Тухайлбал,

- ХХААХҮС-ын багцын 1.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Хүнсний ногооны зорь 500 тонн /Хөвсгөл, Мөрөн сум/ ТАХ-ний тендэрт оролцогч нь Хөвсгөл аймгийн ХХҮЕГ-тай гэрээ байгуулан 56 хүнийг 0.2 тэрбум төгрөгөөр ажиллуулахаар тендэрт санал ирүүлж, ажиллах

хүчний дотоодын давуу эрх тооцуулснаар хамгийн бага үнийн саналаар шалгарсан боловч гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй байхад ХХААХҮЯ хянахгүйгээр санхүүжилтийг олгосон, захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулахдаа хяналт хийлгэхээр тусгасан ч аймгийн ГХБХБГ-ыг шаардлагатай мэдээллээр хангаагүйгээс хяналтгүй орхигдсон байна.

2.21. Дээрх байдлаар төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөх, хэрэгжүүлэх явцад тулгарсан асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг, хариуцах байгууллага, албан тушаалтан, хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа, үе шат дараалал, хүлээлгэх хариуцлагыг заавар журамд тодорхой тусгаагүй, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.

2.22. Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ны 278 дугаар тогтоолоор "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ыг шинэчлэн баталснаар төсвийн хөрөнгө оруулалтын гэрээний удирдлага, оролцогчдын чиг үүрэг, багцыг хуваарилах, тайлагнах хугацаа, цахим систем удирдлага, зохицуулалтыг сайжруулах заалтуудыг нарийвчлан тусгасан нь эрхзүйн зохицуулалтын хувьд тодорхой ахиц гарсан байна.

**Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үе шат бүрд тавих захиалагчийн хяналт хангалтгүй, ажлын гүйцэтгэлийг бодитоор баталгаажуулахгүй байна**

2.23. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа инженерүүд ажлын талбайн журналыг бүрэн хөтлөөгүй, үүрэг даалгавар өгсөн тэмдэглэгээг ажлын талбарт үйлдээгүй, гэрээний хугацаанд тавих хяналт хангалтгүй, гүйцэтгээгүй ажлын санхүүжилтийг баталгаажуулсан, зохиогчтой зөвшилцөхгүйгээр зураг төсөвт өөрчлөлт оруулах, өөрчлөлтийн төсвийг гаргуулахгүй орхигдуулах зэрэг зөрчил нийтлэг байна. Тухайлбал,

- ЗГХЭГД-ын багцын 4.8 тэрбум төсөвт өртөгтэй, Нийслэлийн ЗДТГ-т эрх шилжин хэрэгжсэн Хорооны барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан, 39, 43 дугаар хороо/ ТАХ-ний зарим гүйцэтгээгүй ажлын санхүүжилтийг олгосон;
- Соёлын сайдын багцын Соёл, спортын төвийн барилга, 300 суудал /Төв, Борнуур сум/ ТАХ-ний заалны 0.03 тэрбум төгрөгийн өртөгтэй акустик хавтан, гадна зогсоолын талбайг хийгээгүй;
- ЭМС-ын багцын Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Дорноговь, Даланжаргалан сум/ ТАХ-ний авто машины дулаан зогсоолын дотор засал, шалны будаг, ногоон байгууламжийн ажлыг хийгээгүй, хана цуурсан, явган зам, барилгын хаявч цөмөрсөн, агааржуулалтын систем, цахилгаан доголдолтой;
- НУБХТБҮХД-ын багцын 45.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ болон ХНХС-ын багцын 2.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Иргэдийн хөгжлийн төвийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо/ ТАХ-г барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөлгүйгээр гүйцэтгүүлсэн;
- Зураг төслийн ажилд тавих хяналт хангалтгүйгээс БХБС-ын багцын Сумын төвийн доторх авто замын их засвар /Дархан-Уул, Орхон сум/ ТАХ-ний зураг төслийн гүйцэтгэгч хуурай хөрстэйгөөр тооцоолсон боловч ажил гүйцэтгэх явцад хийсэн инженер геологийн дүгнэлтээр цэвдэгтэй хөрс гэж гарснаас шалтгаалан 2 жилийн хугацаанд хэрэгжээгүй;
- Соёлын сайдын багцын Соёл, спортын төвийн барилга, 250 суудал /Төв, Сэргэлэн сум/ ажлын гүйцэтгэгч урлагийн тайзны болон дотор халаалтын 0.07 тэрбум төгрөгийн ажлыг захиалагчийн зөвшөөрөлгүйгээр өөрчилж гүйцэтгэсэн, зураг төсөл зохиогчоор өөрчлөлтийн зураг төсвийг гаргаж хянуулаагүй;
- Соёлын сайдын багцын Соёлын төвийн барилга, 240 суудал /Сүхбаатар, Уулбаян сум/-ын гадна талбайн 150м<sup>2</sup> бетон хучилт, ногоон байгууламж, зүлэгжүүлэлтийн ажлыг хийгээгүй, дээврээс ус нэвчсэн, цонх дулаан алдагдал ихтэй;
- БШУС-ын багцын Сургуулийн барилга, 320 суудал /Дорноговь, Хатанбулаг сум, 5 дугаар баг/ ТАХ-ний цахилгааны тохируулгыг хийгээгүй, гадна шилэн фасад болон хүзүүвч завсартай, дээврээс ус нэвчсэн, сагсны шийтийг зураг төслөөс багасгаж хийсэн;
- БШУС-ын багцын Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/ ТАХ-ний барилгын суурьт ус чийгээс хамгаалах түрхлэг түрхээгүй, суурьт цасны ус нэвчсэн, төмөр бетон, арагт бүтээцийн ажлыг зургийн дагуу гүйцэтгээгүй;

- БШУС-ын багцын Сургуулийн дотуур байрны барилга, 50 ор /Сүхбаатар, Наран сум/ цонхонд чулуун тавцан хийхээр зураг төсөлд тусгасныг хуванцраар хийсэн, тавцан нь хагарсан, цонхны амлагаа чанаргүй, дулаан алдагдал ихтэйгээс өвлийн улиралд өрөөний температур 7-9 градустай байгаа, дээврээс борооны ус нэвчсэн, аваарын гарц буюу тагтны вакум хаалга, цонх дулаан алдагдалтай, гал тогооны агааржуулагч ажиллагаагүй, үүдний хэсгийн гадна хананд металл фасад хийхээр төлөвлөснийг өөрчилж, шавардаж эмульсдсэн;
- БШУС-ын багцын Сургуулийн спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, 2 дугаар сургууль/ бохирын шугам хөлддөг гэх шалтгаанаар ариун цэврийн өрөө ашиглалтгүй;
- БШУС-ын багцын Сургуулийн спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, 3 дугаар сургууль/ суурилуулсан хяналтын камер ажилладаггүй, борооны усны хаялга салхинд унасан, дээврээс бороо, цасны ус нэвчсэн;
- БШУС-ын багцын Сургуулийн спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, 1 дүгээр сургууль/ ариун цэврийн өрөөний цэвэр усны шугам хөлдсөн, агааржуулалтын системийн ажиллагаа хангалтгүй;
- БШУС-ын багцын Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Завхан Сонгино сум/ гадна бохирын шугам хөлдсөн, агааржуулалтын системийн ажиллагаа хангалтгүй, агааржуулалтын хоолойн жийргэвчийг угсраагүй;
- БШУС-ын багцын Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Завхан, Тэлмэн сум/ дээврийн дулаан алдагдал их, цанталт үүссэн, барилгын суурийн хаяаг зарим газарт ховхорсон, барилгын гадна бохирын цооног амархан дүүрдэг шалтгаанаар усны хэрэглээг хязгаарлаж бие засах газрууд хэвийн ажиллах боломжгүй болсон, бохирын 40 м3-ын багтаамжтай цооногийн хийцийг зураг төсвөөс өөрчилсөн;
- БШУС-ын багцын Сургуулийн барилга буулгаж, барих, 160 суудал /Сүхбаатар, Онгон сум, 2 дугаар байр/ сантехникийн шугам хоолойг угсрахдаа зураг төслийг өөрчилсөн, хана зарим газар цуурсан, бохирын худаг бөглөрсөн, дээврээс ус нэвчсэн;
- БШУС-ын багцын Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сүхбаатар, Наран сум, 3 дугаар баг/ гадна суурилуулсан хүүхдийн тоглоом зураг төсөөт тусгаснаас зөрүүтэй, цонх цантсан, явган замын хавтан хагарсан;
- ЭМС-ын багцын Эрүүл мэндийн төвийн барилга, 17 ор /Сүхбаатар, Мөнххаан сум/ холбоо дохиоллын систем ажилладаггүй, зарим өрөөний дотор температур өвлийн улиралд 9 градус орчим байгаа, халаалтын системийн болон гүний худгийн насос эвдэрсэн, хяналтын 4 камер дутуу суулгасан;
- БШУС-ын багцын Сургуулийн урлаг заалны өргөтгөлийн барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум, 2 дугаар сургууль/ дулаан алдагдал ихтэй, өвлийн улиралд үйл ажиллагаа явуулах боломжгүй, дээврийн сэндривч хавтан, хана хоёрын завсар хоорондын чигжээс, дулаалгыг дутуу хийснээс зай завсар ихтэй;
- ОНБТСҮХД-ын багцад Спорт цогцолборын барилгын /Хэнтий, Баянмөнх сум/ агааржуулалтын системийн болон шалны лакан өнгөлгөөг хийгээгүй, волейбол болон сагсны тоноглолыг суурилуулаагүй;
- БШУС-ын багцын Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/ цахилгааны зарим разеткуудыг хүчдэлд холбоогүй, биеийн тамирын залны таазнаас дусаал гоождог;
- БХБС-ын багцын Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал сум, Батноров сум, Бэрх тосгон/ ТАХ-ний Дэлгэрхаан сумын цэвэр усны эх үүсвэрийн худгийг хамгаалалтын хашааны гадна гаргасан;
- БШУС-ын багцын Сургуулийн барилга, урлаг заал, 320 суудал /Хэнтий, Батноров сум/ ангиудын хаалга болон спорт заалны цонхны материалыг зураг төсвөөс өөрчилж гүйцэтгэсэн;
- БШУС-ын багцын Цэцэрлэгийн барилга /Завхан, Тосонцэнгэл сум/ гадна цэвэр усны шугам хөлдсөн, урлагийн танхимын тохижилтыг дутуу хийсэн зөрчлүүд илэрсэнд албан шаардлага хүргүүлэв.



2.24. Энэ нь Барилгын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1<sup>61</sup>, 37 дугаар зүйлийн 37.1<sup>62</sup>, 40 дүгээр зүйлийн 40.1.1<sup>63</sup>, 40.1.16<sup>64</sup>, 48 дугаар зүйлийн 48.5<sup>65</sup>, 48.7<sup>66</sup>, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.12<sup>67</sup> дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

2.25. ЭХС-ын багцад 2020-2023 онд хэрэгжсэн 22.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Дулааны станц /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/ ТАХ-ний зураг төслийн гүйцэтгэгч нь тухайн ажлын ТЭЗҮ-д заасан ерөнхий нөхцөлийн 7 шаардлагаас 4 нөхцөлийг зураг төсөлд тусгаагүйгээс дулааны станцын хэвийн ажиллагаанд дараах эрсдэл, хүндрэл үүсэхээр байна. Үүнд:

- Шингэн түлшний асаагуурын системийг тусгаагүйгээс анхдагч агаар, хоёрдогч агаарын зарцуулалтууд, галын хотлын үеийн түвшин, тухайн эгшинд авч буй зуухны ачаалал зэрэг галлагааны гол үзүүлэлтүүд дэлгэц дээр харагдахгүй, тогтмол хянах боломжгүйгээс шуурхай ажиллагааны горим алдагдах эрсдэлтэй;
- Шохойн чулууны системийг тусгаагүйгээс хүхрийн ислийн агууламж хэмжээ стандартад заасан хүлээн зөвшөөрөх дээд хэмжээ 400 мг/м<sup>3</sup>-ээс 2.6 дахин их буюу 1024 мг/м<sup>3</sup> байгаа;
- Түлшийг жинлэн хэмжих хэрэгсэл суурилуулахаар заасныг тусгаагүйгээс нүүрсний бодит зарцуулалт, техник, эдийн засгийн үзүүлэлтүүдийг тооцох, алдагдлын хэмжээг тодорхойлох боломжгүй;
- Тортгог үлээлгийн цэвэрлэгээний төхөөрөмжийг тусгаагүйгээс халах гадаргуу дээр хуримтлагдсан үнс, хөв тортгийг цэвэрлэхэд хүндрэлтэй;
- Зуухны янданг тоосгон ба төмөр бетон материалаар төлөвлөснийг зураг төсөлд металл яндангаар өөрчилснөөр их, бага ачааллын дулааны алдагдлыг тооцох шаардлага тулгарсан;
- Тоног төхөөрөмжийн задлах, засварлах орон зайг тусгаагүйгээс их засвар, урсгал засвар, ослын үед моноглолыг салгахад ашиглах зай талбай хангалтгүй, өргөх механизм суурилуулагдаагүй, ажлын байрнаас гаргах боломжгүй, засварын цех төлөвлөөгүйгээс засвар үйлчилгээ хийхэд хүндрэл үүсэхээр байгаа зөрчлүүд илэрсэнд албан шаардлага хүргүүлэв.

2.26. БХБС-ын багцын 23.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Үерийн усны хамгаалалтын далан /Баян-Өлгий Өлгий сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч зарим ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй байхад зохиогч, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага, улсын комисс хяналт тавиагүй байна. Үүнд:

- Бетон хийц, сувгийн ёроол, ажлыг зураг төслийн дагуу хийгээгүй, лабораторийн шинжилгээгээр бетон марк шаардлага хангаагүй байхад зураг төслөөс зөрүүтэй хийсэн ажлын ил, далд ажлын акт болон хийгээгүй ажлын гүйцэтгэлийг зохиогч, захиалагч баталгаажуулж, санхүүжилтийг олгосон;
- Захиалагчийн болон зохиогчийн нэгдсэн дүгнэлт гараагүй байхад ажлын хэсэг үерийн усны хамгаалалтын байгууламжийн зарим хэсгийг ашиглалтад хүлээн авсан;
- Гүйцэтгэгчийн хүсэлтээр зохиогч зураг төсөлд удаа дараа өөрчлөлт оруулсан боловч захиалагчид мэдэгдээгүй, тухайн өөрчлөлтэй холбоотойгоор төсөвт өртөг, хийц бүтээцэд орох өөрчлөлтийг тооцоолоогүй;
- Зохиогчийн хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ үндсэн ажилтнаар бус гэрээт инженерээр гүйцэтгүүлсэн, ажил гүйцэтгэх явцад үерийн сувагтай бохир усны даралттай хоолой

<sup>61</sup> "Энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжид дараах төрлөөр барилгын ажлын зөвшөөрөл олгоно: 26.1.1.барилга байгууламжийг шинээр барих; 26.1.2.барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэн барих; 26.1.3.барилга байгууламжийг буулгах"

<sup>62</sup> "Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.1.барилга байгууламжийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу бүрдүүлэх";

<sup>63</sup> "Барилгын ажлыг зөвшөөрөл, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих";

<sup>64</sup> "Барилгын ажлыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэхгүй байх";

<sup>65</sup> "Захиалагч энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагад барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар хүсэлт гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана: 48.5.3.зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт; 48.5.4.захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт; 48.5.6.барилга байгууламжийн өөрчлөлтийн зураг төсөл";

<sup>66</sup> "Барилга байгууламжийг энэ хуулийн 48.5-д заасан баримт бичгийг бүрдүүлээгүй тохиолдолд ашиглалтад оруулахаас татгалзана";

<sup>67</sup> "Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох"

огтлолцсон нөхцөл байдал илрэхэд зураг төсөл зохиогчийн зүгээс инженерийн шийдэл гаргаагүй, зураг төслийн шатанд тэгш өнцөгт сугийн материалын түүвэрт алдаа гаргаснаас төсвийг илүү тооцсонд хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргаж ирүүлэх албан шаардлагыг захиалагчид хургуулэв.

2.27. Захиалагчийн хяналтын инженерүүд барилгын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахдаа бодит гүйцэтгэлтэй уялдуулахгүй, зураг төсөл, төсвийн тооцоонд илэрсэн асуудлыг тухай бүр шийдвэрлээгүй, захиалагч, зохиогч нарын ажлын уялдаа холбоогүй байдал зарим ТАХ-ний хэрэгжилт удаашрахад нөлөөлж байна.

2.28. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа 3,766.3 тэрбум төгрөгийн 768 барилга байгууламж, их засвар, зураг төслийн ажилд БХТ-ийн Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн 34, аймаг, нийслэлийн ГХБХБГ-ын Барилга, хот байгуулалтын хэлтсийн 87, захиалагчийн хяналт гүйцэтгэх чиг үүрэг бүхий ОНӨААТҮГ-ын 47, нийт 168 инженер үе шатны хяналтыг хэрэгжүүлж, нэг инженер дунджаар 44.5 тэрбум төгрөгийн 9 ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулж байна.

Дүрслэл 3. Орон нутагт захиалагчийн хяналт гүйцэтгэгч инженерийн мэдээлэл (тэрбум.төг)



2.29. Захиалагчийн хяналтын байгууллагуудын нэг инженерт ногдох ачаалал их, зөвлөх болон мэргэшсэн инженерийн эзлэх хувь хангалтгүй байгаа нь барилга байгууламж, их засварын ажлын үе шат бүрд захиалагчийн хяналтыг бодитоор хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

2.30. Цаашид барилгын захиалагчийн хяналтын тогтолцооны үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эрчим хүч, авто замын салбарт хэрэгжиж буй төр, хувийн хэвшлийн түншлэл хэлбэрээр гэрээгээр гүйцэтгүүлэх боломж, нөхцөл зэргийг судалж барилга байгууламжийн ажлын үе шатны хяналтыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авахдаа холбогдох дүрмийн хэрэгжилтийг хангахгүй байгаа нь хяналт хариуцлагын тогтолцоонд сөргөөр нөлөөлж байна**

2.31. Аймаг, нийслэлийн Засаг дарга нар барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжийн дарга, захиалагчийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн нэгдүгээр хавсралтын 1<sup>68</sup> дэх заалтыг зөрчсөн байна.

2.32. Барилга байгууламжийг хүлээн авах улсын комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг бүрэн хангуулахгүйгээр комиссын дүгнэлтийг баталгаажуулсан, гадна тохижилт, ногоон байгууламжийн ажил, бетон хаяавч зэрэг зураг, төсөвт тусгасан ажлыг бүрэн гүйцэтгээгүй байхад ашиглалтад хүлээн авсан байна. Тухайлбал:

- ХНХС-ын багцын Иргэдийн хөгжлийн төвийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо/-ын улсын комиссын 13 гишүүний, мөн Өнөр бүл хүүхдийн төвийн их засвар /Улаанбаатар/-ын улсын комиссын 5 гишүүний өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй байхад комиссын актыг баталгаажуулсан,
- БШУС-ын багцаас эрх шилжин хэрэгжсэн 2.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Багшийн хөгжил, судалгааны арга зүйн төвийн барилга /Архангай/-ын улсын комиссоос өгсөн 2 үүрэг даалгавар, 1.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Архангай, Ихтамир сум/-ын улсын комиссоос өгсөн 5 үүрэг даалгаврын биелэлтийг гүйцэтгэгч компаниуд хэрэгжүүлээгүй байхад комиссын актыг баталгаажуулсан,
- БШУС-ын багцын Сургуулийн дотуур байрны барилга, 50 ор /Сүхбаатар, Наран сум/ ажлыг хүлээн авах аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 20 хүний бүрэлдэхүүнтэй улсын комиссоос зөрчилтэй 65 ажлыг засах, дутуу ажлыг гүйцээх үүрэг даалгавар өгсөн боловч гүйцэтгээгүй,
- БШУС-ын багцын Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Завхан, Тэлмэн сум/, Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Завхан, Сонгино сум/, Цэцэрлэгийн барилга /Завхан, Тосонцэнгэл сум/ 3 ТАХ-г 2023 онд хүлээн авсан комиссын өгсөн 74 үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй, Цэцэн-уул сумын хүүхдийн цэцэрлэг 2021 онд ашиглалтад орсон ч хүлээн авах комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгавар хэрэгжээгүй 2 жилийн хугацаа өнгөрсөн,
- ОНБТСҮХД-ын багцын Спорт цогцолборын барилга /Хэнтий, Баянмөнх/ ТАХ-г улсын комисс хүлээн авсан боловч агааржуулалтын систем, шалны лakan давхаргын ажлыг хийгээгүй, волейбол болон сагсны тоноглолыг суурилуулаагүйгээс ашиглаагүй,
- ЭМС-ын багцын Эрүүл мэндийн төвийн өргөтгөл /Хэнтий, Дархан сум/, Сум дундын эмнэлгийн барилга, 20 ор /Хэнтий, Биндэр сум/, Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга, 15 ор /Өвөрхангай, Бат-Өлзий сум, 5 дугаар баг/, Зооноз өвчин судлалын төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/-д улсын комисс ажиллан дүгнэлтийг баталгаажуулж хүлээн авсан боловч зарим ажлуудыг хийж гүйцэтгээгүй, комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй,
- ЭМС-ын багцын Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Архангай, Цахир сум/, Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Ховд, Мянгад сум/ ТАХ-ний гадна тохижилтын ажлыг хийгээгүй байхад комиссын дүгнэлтийг баталгаажуулсан,
- ЭМС-ын багцын Эрүүл мэндийн төвийн барилга /Баянхонгор, Хүрээмарал сум/-д цэвэр, бохир усны шугам, ариун цэврийн өрөө ашиглалтад ороогүй, цонхны битүүмж муу, далий муруй суулгаснаас өрөөнүүдийн цонхоор шороо ордог, гадна талбайн тохижилт, явган хүний зам, машины зогсоолын ажлыг хийгээгүй,
- ЭМС-ын багцын Эрүүл мэндийн төвийн барилга, 17 ор /Сүхбаатар, Мөнххаан сум/-д холбоо дохиолол ажиллахгүй, халаалтын түрэлтийн насос, гүнийн худгийн ус татах насосууд эвдэрсэн, 7 камер суулгахаас 4 камер дутуу байхад улсын комисс хүлээн авсан байна.

<sup>68</sup> "Барилгын тухай хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан түвэгшлийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан байгууллагын барилгын асуудал хариуцсан нэгжийн даргыг комиссын даргаар, захиалагч байгууллагын төлөөллийг нарийн бичгийн даргаар, гишүүнээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл оролцуулна"

2.33. Эдгээр нь Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 7.6<sup>69</sup>, 8.1<sup>70</sup> 8.2.1<sup>71</sup> дахь заалтад нийцэхгүй байх тул зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмж хүргүүлэв.

2.34. Барилга байгууламжийн төсөвт өртгөөс тодорхой хувийг норм, нормативын сангийн дансанд төвлөрүүлж норм, нормативын баримт бичиг боловсруулах, судалгаа хийх, шинэчлэхэд зарцуулахаар Барилгын тухай хуулийн 5.8<sup>72</sup>-д заасан байна.

2.35. Барилгын хөгжлийн төв ТӨҮГ олон нийтийн барилга байгууламжийн, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ эрчим хүчний барилга байгууламжийн, Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ авто замын байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгийг төвлөрүүлэн, зарцуулж байна.

Дүрслэл 4. Нормчлолын сангийн мэдээлэл /сая төгрөг/



2.36. Барилгын салбарт мөрдөж байгаа норм дүрмийн шинэчлэл хийгдэхгүй удааширдаг, цалин, тариф, үнийн индекс, нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ хуучирсан зэргээс шалтгаалан барилга угсралтын ажил удааширч зураг төслийн дагуу гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүсэж байна. Харин норм, нормативын санд төвлөрсөн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

2.37. Барилга байгууламжийн гүйцэтгэлд тулгарч байгаа нийтлэг асуудалд тулгуурлан зураг төслөөс өөрчлөх, чанаргүй гүйцэтгэх шалтгаан нөхцөлийг судалж, холбогдох норм, дүрмийг шинэчлэх шаардлага үүссэн байна.

2.38. Тухайлбал барилга байгууламжийн салхивчийн системд өндөр хүчин чадлын сэнс байрлуулснаас дуу чимээ үүсэж ажлын байрны орчин нөхцөл алдагдах, салхивчийн хоолой нь барилгын дотор интерьертэй уялдахгүй байх, агаар орох системийг төлөвлөөгүйгээс дотор агаарын чанар гадна агаараас шууд хамаарах, дулаан алдагдал ихсэх зэрэг зөрчил илэрч байна. Тухайлбал:

- Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/,
- Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Завхан Сонгино сум/,
- Сургуулийн дотуур байрны барилга, 50 ор /Сүхбаатар, Наран сум/,
- Спорт цогцолборын барилга /Хэнтий, Баянмөнх сум/,
- Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/

<sup>69</sup> 7.6. “Комисс ажилласны дараа комиссын гишүүд өгсөн санал, үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж, биелэлт хангагдсан тохиолдолд энэ дүрмийн 4 дүгээр хавсралтад заасан үүрэг даалгаврын биелэлтийн хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулна”

<sup>70</sup> 8.1. “Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 өдөрт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ”

<sup>71</sup> 8.2.1. “Барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт”

<sup>72</sup> 5.8. “Барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгийг салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг боловсруулах, судлах, сурталчлах, хэвлэн олшруулах болон эдгээрийг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулна”

2.39. Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.11-д “зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх” чиг үүргийг БХБЯ хэрэгжүүлэхээр заасан боловч орон нутагт улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа барилга байгууламж, их засварын ажилд үе шатны хяналт хийж, зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдийн бүртгэлгүй, Засгийн газрын 2021 оны 343 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам”-ын шаардлагыг хангаж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

2.40. Төсөвчдийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар, хандлагаас шалтгаалж барилга байгууламжийн төсвийн тооцооллыг зураг төслийн дагуу, үнэн зөв хийхгүй, ажлын тоо хэмжээг орхигдуулах, үндэслэл, материалын орц, үнийг алдаатай тооцоолох, өндөр үнээр тусгах зэрэг зөрчил гарсаар байгаа нь барилгын үйл ажиллагаанд оролцогчдод хүлээлгэх хариуцлагын тогтолцоо бүрдээгүйг харуулж байна.

Handwritten signature or stamp on the right margin.

**БҮЛЭГ 3. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АЧ ХОЛБОГДЛООР НЬ ЭРЭМБЭЛЖ ТӨЛӨВЛӨХГҮЙ  
БАЙГАА НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНГ БУУРУУЛЖ БАЙНА**

*Төсөл, арга хэмжээг иж бүрэн байдлаар төлөвлөөгүй, барилгын ажил хугацаандаа хэрэгжээгүйгээс зарим төсөл, арга хэмжээний ашиглалт, үр дүн хангалтгүй байна*

3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлээр 2023 онд нийт 552 төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссаны үр дүнд боловсрол, соёл, спортын 209, эмнэлгийн 49 барилга, цэвэр бохир усны 345 км шугам, худаг, насос, цэвэрлэх байгууламж 36, цахилгаан, дулааны дамжуулах, түгээх 42 байгууламж, 70.4 км дулааны шугам сүлжээ, 71.4 км ЦДАШ, 74.6 км авто зам, 598.2 урт/метр гүүр тус тус ашиглалтад орсон байна.

3.2. ОУВС-ийн 2023 оны тайланд тусгагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээ"-ээр Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийн үзүүлэлт 14% сайжирч, зарим чиглэлд тодорхой ахиц дэвшлүүд гарч байгааг үнэлж дүгнэсэн байна.

3.3. Эрүүл мэндийн салбарт оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, дотооддоо оношлох эмчлэх боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд 2021-2023 онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээр зарим ТАХ-г хэрэгжүүлсэн нь тодорхой үр дүнд хүрсэн байна. Тухайлбал:

- Улсын Нэгдүгээр төв эмнэлэгт цусны үүдэл эс шилжүүлэн суулгах 9 ортой иж бүрэн нэгжийг 1.4 тэрбум төгрөгөөр байгуулснаар эрүүл мэндийн чиглэлээр гадаад улс руу урсах мөнгөн урсгалыг бууруулсан;
- Нүдний мэс заслын 0.7 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлж суурилуулснаар Монгол Улсад эмчлэх боломжгүй 26 өвчний жагсаалтыг бууруулан 2022-2024 онд нийт 46 хүүхдийн нүдэнд торлог шилэнцэрийн мэс заслыг амжилттай хийсэн;
- Удам зүйн лабораторийн хүчин чадлыг 1.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж хүүхэд, насанд хүрээгчдийн дунд удамшлын хромосомын эмгэгийг цитогенетик, молекул биологийн аргаар оношилж эхэлсэн;
- Цагт 20 м.куб хүчилтөрөгч үйлдвэрлэх хүчин чадалтай Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэрийг 26 эмнэлэгт 15.1 тэрбум төгрөгөөр байгуулснаар жилд 0.05-0.1 тэрбум төгрөг хэмнэсэн үр дүнтэй байна.

3.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж, хүлээн авсан зарим барилга угсралтын ажлын инженерийн шугам сүлжээний холболт, дэд бүтцийн асуудлыг иж бүрэн байдлаар төлөвлөж хэрэгжүүлээгүйгээс хүлээн авсан барилга байгууламж ашиглалтгүй, мөн зарим барилга байгууламжийн ажил хугацаандаа ашиглалтад ороогүйгээс бэлтгэсэн тавилга, тоног төхөөрөмж нь ашиглалтгүй хадгалагдаж байна. Тухайлбал:

- БШУС-ын багцын 1.5 тэрбум төгрөгийн өртөгтэй Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Архангай, Ихтамир/ барилгын инженерийн шугам, сүлжээний ажлыг иж бүрнээр төлөвлөж хэрэгжүүлээгүйгээс улсын комисс хүлээн авсан боловч ашиглалтгүй;
- БХБС-ын багцын 3.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажил /Баян-Өлгий, Өлгий/ улсын комисс хүлээн авсан боловч нэгдсэн шугам, сүлжээний эх үүсвэрт холбоогүйгээс ашиглалтгүй;
- Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2019 оны 08-07-033/07/13 дугаартай дүгнэлтээр "ашиглах боломжгүй" гэж дүгнэлт гаргасан барилгад БШУС-ын багцын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 3 дугаар цэцэрлэг/-ын ажлыг 0.3 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлэн хүлээн авсан бөгөөд уг барилгын дээврийн хэсэгт нуралт үүссэн, ашиглахад эрсдэлтэй;
- БХБС-ын багцын Төрийн албан хаагчдын орон сууцны барилга, 14 айл /Өмнөговь, Баян-Овоо сум/ ТАХ-г 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдөр Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпорац хүлээн авснаас хойш барилгын гадна талын зарим хэсэг өнгөө алдсан, халцарсан, хаалга гажсан, цоож эвдэрсэн, өрөөний дотор шаврын хагарал үүссэн, тааз хананы заагаар шороо, тоос ордог, паркет шаланд зай завсар үүссэн, хөндийрсөн зөрчлүүд илэрснээс шалтгаалж ашиглаж эхлээгүй;
- БОАЖС-ын багцын Хэнтий аймагт Дэлгэрхаан, Жаргалтхаан, Өмнөдэлгэр сумдын гадна цэвэр усны шугам сүлжээний ажилд зураг төсөв боловсруулах даалгаварт заасан аж ахуйн нэгж болон

төрийн байгууллагуудын холболт хийх ажлыг төсөвт тусгаагүй, зарим аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудыг цэвэр усан хангамжид холбох ажлыг хийгээгүй, Их хуралдай цогцолборыг ажиллуулах байгууллага тодорхойгүйгээс шалтгаалан ашиглалтгүй;

- БШУС-ын багцын Батноров сумын ЕБС-ийн барилгын спорт заал, урлаг заалны тавилга тоног төхөөрөмж, Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн барилгын ширээ, сандлыг төсөвт тусгаагүйгээс сургуулийн 3 дугаар давхрыг ашиглаагүй;
- ХХААХҮС-ын багцын Хүнс, ногооны агуулахын барилга, 500 тн /Хөвсгөл, Мөрөн сум/ болон Хүнсний ногооны зорь, 500 тонн /Хөвсгөл, Мөрөн сум/ ТАХ-ний 2.3 тэрбум төгрөгийн 2 барилгыг хүлээн авсан боловч ашиглагч байгууллага тодорхойгүйгээс шалтгаалан ашиглалтгүй;
- ХХААХҮС-ын багцын Бизнес хөгжлийн төвийн барилга /Хөвсгөл, Мөрөн сум/ болон, Бизнес хөгжлийн төвийн өргөтгөлийн барилга /Хөвсгөл, Мөрөн сум/, Ахуй үйлчилгээний төвийн барилга /Хөвсгөл, Мөрөн/ ТАХ-ны 3 барилгыг нийт 2.8 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлэн хүлээн авсан боловч холболтын ажлаас шалтгаалан ашиглалтгүй;
- ХХААХҮС-ын багцын орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд нийлүүлсэн 9.2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг эзэмшиж, ашиглах иргэн, аж ахуй нэгж тодорхойгүйгээс ашиглалтгүй хадгалагдаж байна.

3.5. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж, ашиглалтгүй хөрөнгийн тоог нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

**Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагаар эрэмбэлж төлөвлөхгүй байгаа нь үр ашиг багатай арга хэмжээг санхүүжүүлэхэд хүргэж байна**

3.6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсвийг тэлсэн, эдийн засгийн үр ашиг багатай зарим төсөл, арга хэмжээг судалгаа, тооцоогүйгээр төлөвлөж хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- ХНХС-ын багцад 1.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр Хөвсгөл аймгийн Баянзүрх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумын төв тус бүрд 1 ахмадын төвийн барилга, Мөрөн сумын 10-14 дүгээр багт ахмадын өргөөний 2 барилга, нийт 5 барилгын ажлыг төлөвлөсөн;
- ХНХС-ын багцад Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо буюу Биокомбинатад 2.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Иргэдийн хөгжлийн төвийн барилга болон 1.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Хүүхэд, залуучууд, ахмадын хөгжлийн барилга барихаар тус тус төлөвлөсөн;
- ЗТХС-ын багцад 2.1 тэрбум төгрөгийн Хорооллын авто замын шинэчлэл, өргөтгөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 13, 14, 15 дугаар хороо/ болон 1.0 тэрбум төгрөгийн Хорооллын доторх авто зам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 15 дугаар хороо/ ТАХ-ны хүрээнд гол болон туслах замтай холбогдохооргүй, гудамж дунд зам барихаар төлөвлөж хэрэгжүүлсэн;
- БХБС-ын багцын 0.4 тэрбум төгрөгийн өртөгтэй Халуун усны барилгын /Баян-Өлгий, Бугат/ ТАХ-г хэрэгжүүлэхдээ зардал, үр ашиг, хэрэгцээ, шаардлагыг тооцохгүй төлөвлөснөөс түрээслүүлэх боломжгүй, зардлыг хариуцах байгууллагагүй, 2022 онд хүлээн авснаас хойш ашиглаагүй;
- БШУС-ын багцын Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Завхан, Тэлмэн сум/ ТАХ-г төлөвлөж хэрэгжүүлэхдээ урсгал зардлыг тооцоогүйгээс бохирыг соруулахын тулд 120 км буюу аймгийн төвөөс тусгай зориулалтын машинаар нэг удаад 8 рейс, сард дунджаар 32 удаа соруулж тээвэрлүүлэх шаардлага тулгарсан байна.

3.7. Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т "Төсвийн хөрөнгө оруулалт гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ" гэж заасан ч БХБС-ын багцад уг заалтыг хангаагүй 50.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй нийтийн орон сууцны дээвэр, фасад засвар, дулаалгын ТАХ-г 25.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлж хэрэгжүүлж байна.

3.8. Мөн ХХААХҮС-ын багцад Малчид болон Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл, Олон талт түншлэлийн хүрээнд "Үйлдвэрлэгч баг" төсөл, Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих, тоног төхөөрөмж, Малын үүлдэр, угсааг сайжруулах төсөл зэрэг нэршлээр нийт 39.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 29.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий ТАХ-ний хэрэгжилт, үр дүн нь хангалтгүй байна. Үүнд:

- Малчид болон орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл, орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж ТАХ-ний төсвөөс Ховд, Увс, Сүхбаатар, Төв аймаг нийт 1.5 тэрбум төгрөгийн 265 ш зөөврийн компьютер болон 2,260ш таблет худалдан авахаар гэрээ байгуулсан, үүнээс 0.7 тэрбум төгрөгийн 25ш зөөврийн компьютер, 600ш таблетыг хүлээн аваагүй дутуу, хүлээн авсан зөөврийн компьютерыг багийн Засаг дарга, төрийн байгууллагын мэргэжилтнүүдэд, таблетыг аймаг, сумдын өрөнхий боловсролын сургуулийн сурагчдад тараан олгож ашиглуулж байгаа;
- Малын түүхий эд боловсруулах болон оёдлын, тавилгын, хүнсний, савлагааны, үсчин, гоо сайхны тоног төхөөрөмж, жижиг хэрэгсэл, дагалдах химийн бодис зэрэгт 2.6 тэрбум, хөргүүр, хүлэмж, усалгааны систем, хашаа зэрэгт 6.6 тэрбум, үржлийн мал, зөгийн бүл худалдан авахад 3.2 тэрбум, трактор, комбайн, газар тариалангийн бусад техник хэрэгсэлд 9.8 тэрбум, нийт 22.2 тэрбум төгрөг зарцуулсан ба үүнээс 5.5 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хүлээн аваагүй дутуу, 5.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг ашиглаж эхлээгүй, 11.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг эзэмшүүлж ашиглуулахдаа иргэд, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулаагүй, түрээсээр эсвэл үнэ төлбөргүй олгосон, эзэмших ашиглах гэрээ байгуулаагүй зэргээр харилцан адилгүй нөхцөл журмаар олгосон;
- Тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагыг нарийвчлан боловсруулаагүйгээс Булган, Төв, Ховд, Говь-алтай аймагт ижил хүчин чадал бүхий тракторыг харилцан адилгүй үнээр худалдан авсан, "Багц 22. Говьсүмбэр-Ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмж"-ийн техникийн тодорхойлолтын "Оёдлын үйлдвэрийн тоног төхөөрөмж, хэрэгсэл" жагсаалтад оёдлын үйлдвэрлэлийн зориулалттай бус өрдийн оёдлын машин худалдан авахаар тусгасан,
- Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газраас ХАА-г зохион байгуулсан Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Орхон/ ТАХ-ний техникийн тодорхойлолтод хөрөнгө оруулалтын бус шинж чанартай бараа материал, техник хэрэгсэл тусган, худалдан авч иргэдэд үнэ төлбөргүй ашиглуулсан байна.

3.9. Дээрх байдлаар улсын төсвөөс тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй нийт 75.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөн хэрэгжүүлж 2023 онд нийт 54.7 тэрбум төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24<sup>73</sup>, Төрийн болон орон нутгийн нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5<sup>74</sup>, 6 дугаар зүйлийн 6.4.2<sup>75</sup>, 21 дүгээр зүйлийн 21<sup>76</sup>, 30 дугаар зүйлийн "Төрийн өмчийн эд хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэх" зүйлийн 30.3<sup>77</sup> дахь заалтад тус тус нийцэхгүй байна.

3.10. Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, ач холбогдол, эдийн засгийн үр өгөөжөөр нь эрэмбэлж хэрэгжүүлэхгүй, санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой ашиглахгүй байгааг харуулж байна.

<sup>73</sup> 4.1.24. "Төсвийн хөрөнгө оруулалт гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг"

<sup>74</sup> 5.5. "Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ"

<sup>75</sup> 6.4.2. "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх"

<sup>76</sup> 21. "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно"

<sup>77</sup> 30.3. "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно"



## ДҮГНЭЛТ

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн өмнөх оноос 36.0 хувиар өсөж 23,294.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 24.0 хувиар өсөж 22,509.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 785.9 тэрбум төгрөгийн ашигтай буюу эерэг үзүүлэлттэй байна.
- Төсвийн тухай хуулийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай бүрд Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуулийг өөрчилж байгаа нь эдийн засгийн үзүүлэлтүүдийг урьдчилан тооцсон төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.
- Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсөв нь төсвийн бодлогын зорилт, Улсын Хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн боловч улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар санхүүжих төсөл, арга хэмжээг төсөвт бүрэн тусгаагүй байна.
- Уул уурхайн салбараас хэт хамааралтай төсвийн тэлэлт нь эрдэс баялгийн бүтээгдэхүүний эрэлт, зах зээлийн үнэ буурснаар төсвийн орлого тасалдах, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах эрсдэлийг бий болгож байна.
- Татварын бус орлого тасарсан нь гадаад тусламжаар хэрэгжих зарим төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, навигаци, газрын тосны бүтээгдэхүүний орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүйтэй холбоотой байна.
- Төсвийн нийт зарлага тэлж байгаа ч нийгэм эдийн засагт үр өгөөж бий болгох нэмүү өртөг шингэсэн, бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэхгүй байна.
- Орон нутгийн ТЕЗ нар Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэг, уралдаан тэмцээн, шагнал урамшуулал зэрэгт зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээнд батлагдсан санхүүжилтээс гүйцэтгэгчид 260.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, хөрөнгийн зардлын санхүүжилтийг 76.5 тэрбум төгрөгөөр бууруулан тайлагнасан байна.
- Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тухайн жилийн 2,686.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэл 83.2 хувь, тухайн онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн 883 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 62.5 хувьтай байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд нийт 552 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, боловсрол, соёл, спортын 209, эмнэлгийн 49 барилга, цэвэр, бохир усны шугам хоолой 345 км, дулааны шугам 70.4 км, цахилгаан дамжуулах агаарын шугам 71.4 км, авто зам 74.6 км, гүүр 598.2 урт/метр, их засварын 44 ажил тус тус ашиглалтад орсон байна.
- Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулж төлөвлөхгүй байгаа зэрэг нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болж байна.
- Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардлын үндэслэл, тооцоололд тавих Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хяналт хангалтгүй байгаад дотоод аудит хийж, хариуцлага тооцох шаардлагатай байна.
- Барилга байгууламжийн ажилд үе шатны хяналт гүйцэтгэж байгаа байгууллагуудын хүний нөөцийн хүрэлцээ, мэргэжлийн чадавхад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж захиалагчийн хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тулгарсан асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг, хариуцах байгууллага, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа, шат дараалал тодорхойгүй, гэрээний хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, зогсонги байдалд хүргэхэд нөлөөлж байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, тэргүүлэх ач холбогдол, эдийн засгийн үр өгөөжөөр нь эрэмбэлж төлөвлөхгүй, санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой ашиглахгүй байна.
- Эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, аргачлалыг бодитой тодорхойлоогүйгээс сангийн эх үүсвэр хүрэлцэхгүй, 218.3 тэрбум төгрөгийн өртэй байна.
- Нийгмийн даатгалын сангийн 162.9 тэрбум төгрөгийн түргэн хөрвөх хөрөнгө эрсдэлтэй, Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээн авсан 15.9 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг борлуулж, түргэн хөрвөх хөрөнгөнд шилжүүлэх ажил удаашралтай байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан зарим арга хэмжээний холбогдох дүрэм журмыг боловсруулаагүй, байгууллагуудаас татан төвлөрүүлсэн, шилжүүлсэн автомашины бүртгэл, ашиглалт, улсын дугаарын шилжилт хөдөлгөөн, худалдан борлуулалтын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.
- Гэрэгэ болон Хуралдай бондын тайлант хугацаанд төлөх эргэн төлөлт, хүүгийн зардлын тодорхой хэсгийг “Сенчири-2”, “Сенчири-3” гадаад бонд гаргах замаар өрийг дахин санхүүжүүлж, гадаад өрийн хугацааг уртасгасан байна.
- Давсан орлогыг тайлант онд зарцуулах журмын зохицуулалт нь төсөвт байгууллагын өөрийн орлогыг бодитой илэрхийлэхгүй, үндэслэлтэй төлөвлөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.
- Шилэн дансны нэгдсэн шинэчилсэн цахим хуудсыг төсвийн үйл ажиллагаанд ашигладаг системүүдтэй мэдээлэл солилцох, байршуулах үйл ажиллагаа бүрэн бус, мэдээллийг хамрах хүрээний байгууллагаар ангилаагүй, регистрийн дугаараар хайлт хийх боломжгүй, хуулийн шаардлагын дагуу иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой байх зарчмыг бүрэн хангаагүй байна.
- Өмнөх онд хийсэн аудитаар нийт 17 зөвлөмж хүргүүлснээс бүрэн хэрэгжүүлсэн 3, хэрэгжих шатандаа 11, зөвлөмж хэрэгжүүлээгүй 3, нийт зөвлөмжийн биелэлт 60.9 хувьтай байгаа нь төсвийн сахилга бат хангалтгүй байгааг харуулж байна.

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:**

1. Засгийн газраас тайлагнасан Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн 23,294.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 22,509.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг аудитаар баталгаажууллаа.
2. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд тусгасан эдийн засгийн үзүүлэлтүүдийг тухайн жилийн төсвийг батлахдаа өөрчлөлт оруулж байгаад анхаарал хандуулахыг толилуулж байна.

## **ЗӨВЛӨМЖ**

### **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД-д:**

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн төсөл, арга хэмжээнд тавих шаардлагыг Төсвийн тухай хуулийн шаардлагатай нийцүүлж, Улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан улсын төсөв, гадаадын зээл тусламжийн эх үүсвэрээр санхүүжих төсөл арга, хэмжээг тухайн жилийн төсөвт бүрэн тусгуулах
2. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан зарим арга хэмжээний холбогдох дүрэм журмыг боловсруулж батлуулах
3. Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг хэрэгжүүлж, шийдвэрийн биелэлтийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар хянаж Үндэсний аудитын газарт ирүүлэх
4. Барилга байгууламжийн ажлын үе шат бүрийг хянах үйл ажиллагаа, захиалагчийн хяналтын тогтолцооны үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх
5. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын эрх үүрэг, хоорондын харилцааг зохицуулах, тулгарсан асуудлыг шийдвэрлэх, гэрээ цуцлах, хохирлыг тооцож нэхэмжлэх, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг төвлөрүүлэхтэй холбоотой зохицуулалтыг холбогдох журамд нэмж тусгах

### **МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД-д:**

1. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийн хариуцах эзэн, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг бодитой төлөвлөж, хуулийн шаардлагыг хангасан төлөвлөгөөг батлуулах
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан боловч гадна шугам сүлжээ, эх үүсвэрийг иж бүрэн төлөвлөөгүйгээс зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй барилга байгууламж, тоног төхөөрөмжийн санхүүгийн болон бусад эх үүсвэрийг шийдвэрлэх замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх
3. Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцох жишиг үнийг тогтоож мөрдүүлэх

### **САНГИЙН САЙД-д:**

1. Төсвийн орлого уул уурхайн салбараас хэт хамааралтай, эрсдэл бүхий байгаа тул цаашид санхүүгийн хуримтлалыг тогтвортойгоор үүсгэж, үр дүнтэй удирдах
2. Татварын бус орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, орлогын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах
3. Төсвийн зардлын хэмжээ болон бүтцийг тодорхойлохдоо богино хугацааны макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, урт хугацааны үр ашгийг нэмэгдүүлэх зарчмыг баримтлах, төсвийн ачааллыг дунд, урт хугацаанд бууруулах бодлого баримтлан ажиллах
4. Дотоодын зах зээлд Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг иргэд, аж ахуйн нэгжид зориулан хөгжүүлж, Засгийн газрын өрийн дүнд эзлэх гадаад өрийг үе шаттайгаар бууруулах

5. Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөнөөс давж биелсэн орлогын зарцуулах эрхийг төсвийн дараагийн жилд олгодог байхаар журамд өөрчлөлт оруулах.
6. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг төсвийн үйл ажиллагаанд ашигладаг системүүдтэй мэдээлэл солилцох, байршуулах боломжийг бүрэн бүрдүүлж, хяналтыг сайжруулах
7. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын эх үүсвэртэй уялдуулж, даатгалын сангаас санхүүжих эмнэлгийн тусламж үйлчилгээний төрөлд дүн шинжилгээ хийж, оновчтой болгох
8. Нийгмийн даатгалын сангийн Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 68.2 тэрбум төгрөгийн авлага, Чингис хаан Банканд байршиж буй 94.9 тэрбум төгрөгийн сангийн хөрөнгийн эрсдэлийг бууруулах
9. Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журамд төсвийн сахилга батыг сайжруулах, нөөц хөрөнгийн зориулалтыг тодорхой оновчтой болгож өөрчлөлт оруулах.
10. Худалдан авах ажиллагаанд давуу эрх тооцуулан шалгарсан тохиолдолд түүнд хяналт тавих, хэрэгжилтийг үнэлэх, хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг холбогдох заавар, журамд тусгах
11. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд Төсвийн ерөнхийлөн захирагч бүр төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн мэдээллийг бүрэн байршуулсан эсэхэд хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хийх

#### **ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДАД:**

- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд төсөл, арга хэмжээний төлөвлөлт, багцын задаргаа, хэрэгжилт, санхүүжилтийн мэдээллийг бүрэн байршуулах, бүрэн байршуулсан эсэхэд хагас жил тутам дотоод аудит хийж хэрэгжилтийг хянах

#### **БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД-д:**

- Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн чиглэл, арга зүйгээр хангах
- Барилга байгууламжийн зураг төсөл, ажлын чанар, гүйцэтгэлд илэрч байгаа нийтлэг зөрчил, тулгарч байгаа асуудалд судалгаа, шинжилгээ хийж барилгын норм, дүрэм, стандартыг өөрчлөн шинэчлэх, сайжруулах ажлыг зохион байгуулан, норм нормативын сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулахад анхаарч ажиллах

#### **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД-д:**

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон үйлдвэр, агуулах, зоорь, хүлэмж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үржлийн мал зэргийн ашиглагчийг нээлттэй, ил тод, өрсөлдөөнт зарчмаар сонгон шалгаруулах, оновчтой, үр ашигтай ашиглахад чиглэсэн журам, заавар боловсруулан баталж, нэгдсэн арга зүйгээр хангах, хэрэгжилт үр дүнг бүртгэх, тайлагнах, хянах, хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх

#### **БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД-д:**

1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ширээ, сандалд тавигдах чанар, эдэлгээтэй холбоотой нарийвчилсан шаардлагыг боловсруулан мөрдүүлэх, бүсчилсэн хэлбэрээр орон нутагт үйлдвэрлэх, нийлүүлэх нөөц боломжийг судалж худалдан авах ажиллагааг чанартай, үр ашигтай, хэмнэлттэй байхаар зохион байгуулах

**ХАВСРАЛТ**

**Хавсралт 1. Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл**

/Тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн		Улсын		О Нутаг		ЭМДС		НДС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	23,039.5	24,387.0	16,226.2	17,177.3	4,616.5	4,891.3	1,603.5	1,586.8	4,175.2	4,271.6
<b>ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН</b>	501.6	675.9	501.6	675.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1. УТ - Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	87.4	92.2	87.4	92.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2. УТ - Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	414.2	583.7	414.2	583.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>ИРЭЭДҮЙН ӨВ САН</b>	540.0	416.2	540.0	416.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>НИЙТ ТЭНЦЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	21,997.9	23,294.9	15,184.6	16,085.2	4,616.5	4,891.3	1,603.5	1,586.8	4,175.2	4,271.6
<b>1 Татварын орлого</b>	19,760.7	21,484.2	12,459.0	13,715.0	3,459.6	3,818.3	1,603.5	1,586.8	3,400.8	3,507.3
1.1. Орлогын албан татвар	4,712.9	5,702.6	2,086.0	2,716.7	2,626.9	2,985.8	0.0	0.0	0.0	0.0
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	1,671.0	1,884.6	0.0	0.0	1,671.0	1,884.5	0.0	0.0	0.0	0.0
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	3,106.6	3,882.5	2,086.0	2,716.7	1,020.6	1,165.8	0.0	0.0	0.0	0.0
1.1.3. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.1.4. Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-64.7	-64.5	0.0	0.0	-64.7	-64.5	0.0	0.0	0.0	0.0
<b>1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж</b>	3,842.2	3,950.8	0.0	0.0	0.0	0.0	1,603.5	1,586.8	3,400.8	3,507.3
1.3. Хөрөнгийн албан татвар	382.1	394.8	0.0	0.0	382.1	394.8	0.0	0.0	0.0	0.0
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	4,771.9	4,777.0	4,771.9	4,777.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.5. Онцгой албан татвар	972.0	790.1	972.0	790.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.6. Тусгай зорцуулалтын орлого	20.0	21.6	20.0	21.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.7. Гадаад үйл ажиллагааны орлого	1,644.0	1,465.4	1,644.0	1,465.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	3,415.6	4,381.9	2,965.1	3,944.2	450.6	437.7	0.0	0.0	0.0	0.0
<b>2 Татварын бус орлого</b>	2,237.2	1,810.7	2,725.6	2,370.2	1,156.9	1,073.0	0.0	0.0	774.4	764.3
2.1. Нийтлэг татварын бус орлого	1,618.7	1,451.7	1,137.0	1,024.1	481.7	427.6	0.0	0.0	0.0	0.0
2.2. Хөрөнгийн орлого	19.4	8.2	0.0	0.0	19.4	8.2	0.0	0.0	0.0	0.0
2.3. Тусламжийн орлого	599.1	350.8	572.6	335.9	28.6	17.2	0.0	0.0	774.4	764.3
2.4. Төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0	1,016.0	1,010.2	627.2	620.0	0.0	0.0	0.0	0.0

## Хавсралт 2. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

	Нэгдсэн		Улсын		О Нутаг		ЭМДС		НДС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
<b>ҮЗҮҮЛЭЛТ</b>										
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	24,211.0	22,509.0	16,949.9	16,079.7	5,240.1	4,336.3	1,518.4	1,598.0	4,084.3	4,034.9
<b>А УРСГАЛ ЗАРЛАГА</b>	18,057.6	17,091.4	12,574.1	11,960.5	3,309.2	3,031.8	1,603.4	1,602.8	4,152.7	4,036.1
1 Бараа, үйлчилгээний зардал	5,471.5	5,085.4	3,821.2	3,614.4	1,770.1	1,580.2	50.2	50.0	46.0	42.1
1.1. Цалин, хөлс	2,421.9	2,327.5	1,943.3	1,875.6	437.4	413.4	6.3	6.2	34.9	32.3
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	155.0	145.1	55.7	51.5	0.8	0.8	4.5	4.0
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	3,049.6	2,757.9	1,722.9	1,593.7	1,277.0	1,115.3	43.1	43.0	6.6	5.8
2 Хүү	1,154.5	1,150.0	1,093.5	1,092.6	61.0	57.4	0.0	0.0	0.0	0.0
3 Тагаас ба урсгал шилжүүлэг	11,431.6	10,856.0	7,659.4	7,253.5	1,478.1	1,394.2	1,553.2	1,552.8	4,106.7	3,994.0
3.1. Тагаас	797.8	579.7	1,240.9	1,033.1	241.2	220.9	90.0	90.0	0.0	0.0
3.2. Урсгал шилжүүлэг	10,633.8	10,276.3	6,418.5	6,220.4	1,236.9	1,173.3	1,463.2	1,462.8	4,106.7	3,994.0
<b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	6,216.8	5,188.2	4,381.4	3,951.9	1,835.4	1,236.3	0.0	0.0	0.0	0.0
1 Барилга байгууламж	4,242.9	3,730.3	3,553.0	3,263.3	689.9	467.0	0.0	0.0	0.0	0.0
2 Их засвар	203.7	172.3	106.1	104.8	97.6	67.5	0.0	0.0	0.0	0.0
3 Хөрөнгийн бусад зардал	1,770.2	1,285.6	722.3	583.8	1,047.9	701.8	0.0	0.0	0.0	0.0
5 Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	-63.4	229.4	-5.6	167.3	95.5	68.2	-85.0	-4.8	-68.4	-1.2
1 Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-346.4	-53.0	-288.6	-115.1	95.5	68.2	-85.0	-4.8	-68.4	-1.2
2 Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	283.0	282.4	283.0	282.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

**Хавсралт 3. Нэгдсэн төсвийн тэнцэл**

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Нэгдсэн		Улсын		О Нутаг		ЭМДС		НДС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	23,039.5	24,387.0	16,226.2	17,177.3	4,816.5	4,891.3	1,803.5	1,596.8	4,175.2	4,271.6
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	501.6	675.9	501.6	675.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ИРЭЭДҮЙН ӨВ САН	540.0	416.2	540.0	416.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	21,997.9	23,294.9	15,184.6	16,085.2	4,816.5	4,891.3	1,803.5	1,586.8	4,175.2	4,271.6
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	24,211.0	22,509.0	16,949.9	16,079.7	5,240.1	4,336.3	1,518.4	1,598.0	4,084.3	4,034.9
<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	-1,171.5	1,878.0	-723.7	1,097.6	-823.6	555.0	85.1	-11.2	90.9	236.7
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	-2,213.1	785.9	-1,765.3	5.5	-823.6	555.0	85.1	-11.2	90.9	236.7
<b>АЛДАГЦЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР:</b>	2,213.1	-785.9	1,765.3	-5.5	823.6	-555.0	-85.1	11.2	-90.9	-236.7
1. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	623.6	-1,028.4	175.8	-246.4	623.6	-556.7	-85.1	11.2	-90.9	-236.7
3. ЗГ-ын бонд	670.4	-704.1	670.4	-704.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1. Урт хугацаат	670.4	-704.1	670.4	-704.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.1. Дотоод	1,136.1	-801.4	1,136.1	-801.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.1.1. Шинээр гаргах	2,273.6	0.0	2,273.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.1.2. Үндсэн төлбөр	-1,137.5	-801.4	-1,137.5	-801.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.2. Гадаад	-485.7	97.3	-485.7	97.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.2.1. Шинээр гаргах	0.0	3,455.2	0.0	3,455.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.2.2. Үндсэн төлбөр	-465.7	-3,357.9	-465.7	-3,357.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4. ЗГ-ын зээл	417.5	944.1	417.5	944.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2. Гадаад	417.5	944.1	417.5	944.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.1. Төслийн зээл	67.5	251.6	67.5	251.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.1.1. Шинээр авах	1,224.5	1,211.4	1,224.5	1,211.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.1.2. Үндсэн төлбөр	-1,157.0	-959.8	-1,157.0	-959.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.2.1. Шинээр авах	350.0	692.5	350.0	692.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
7. Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
8. Тогтворжуулалтын сангийн хуригтлагдсан үлдэгдэл	501.6	0.0	501.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
9. Өмч хувьчлал	0.0	2.5	0.0	0.9	0.0	1.7	0.0	0.0	0.0	0.0
10. НДС-ийн арилжааны банкнаас авах шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

## Хавсралт 4. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, хэрэгжилт

/тэрбум төгрөг/

№	Аймаг, нийслэл	ТАХ		ТАХ				Хэрэгжээгүй		Хэрэгжилт хувь /дундаж/
		Тоо	Төсөв	Бүрэн хэрэгжсэн		Дутуу хэрэгжсэн		Тоо	Дүн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн			
1	Архангай	446	16.1	344	11.9	12	0.3	92	2.3	77.1
2	Баян-Өлгий	704	11.6	587	8.2	44	0.5	73	2.9	83.4
3	Баянхонгор	596	25.3	474	18.8	50	2.1	72	2.0	79.5
4	Булган	443	14.0	325	9.5	39	1.4	79	2.2	73.4
5	Говь-Алтай	614	19.7	400	12.6	90	3.8	124	1.8	65.1
6	Говь-сүмбэр	108	6.8	76	2.9	19	1.3	13	1.4	70.4
7	Дархан-Уул	275	17.5	227	11.3	35	5.2	13	1.0	82.5
8	Дорноговь	279	38.3	241	57.7	12	1.1	26	0.8	86.4
9	Дорнод	419	31.2	356	23.0	30	5.1	33	1.3	85.0
10	Дундговь	404	18.5	329	19.8	27	2.3	89	3.1	81.4
11	Завхан	854	19.7	693	15.5	45	0.9	121	2.3	81.1
12	Өвөрхангай	468	18.8	330	14.2	46	0.8	94	2.7	70.5
13	Өмнө-говь	384	45.4	269	35.0	32	2.7	82	7.7	70.1
14	Сүхбаатар	417	56.4	266	17.5	38	12.5	114	26.4	63.8
15	Сэлэнгэ	356	30.9	232	16.8	36	5.2	87	4.2	65.2
16	Төв	665	32.5	501	24.0	42	1.9	92	4.6	75.3
17	Орхон	286	29.9	200	11.7	8	3.7	78	4.1	69.9
18	Хэнтий	278	15.8	238	13.8	1	0.0	39	0.9	85.6
19	Увс	502	14.1	405	9.0	40	1.4	57	2.0	80.7
20	Хөвсгөл	643	20.7	511	13.7	35	1.4	97	3.2	79.5
21	Ховд	735	32.4	581	19.9	77	6.1	77	6.1	79.0
<b>Аймгуудын дүн</b>		<b>9876</b>	<b>515.6</b>	<b>7585</b>	<b>366.9</b>	<b>758</b>	<b>59.8</b>	<b>1552</b>	<b>82.7</b>	<b>76.4</b>
22	Улаанбаатар	463	59.7	282	34.1	87	15.7	114	11.5	60.9
<b>Улсын хэмжээнд нийт</b>		<b>10339</b>	<b>575.3</b>	<b>7867</b>	<b>401.0</b>	<b>845</b>	<b>75.5</b>	<b>1666</b>	<b>94.3</b>	<b>68.7</b>



## Хавсралт 5. Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулбал:

/тэрбум төгрөг/

№	Аймаг, нийслэл	Өмнөх оны гүйцэтгэл		2023 оны төлөвлөгөө		2023 оны гүйцэтгэл		Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад	
		TAX тоо	санх/ гүйцэтгэл	TAX тоо	санх/ төсөв	TAX тоо	санх/ гүйцэтгэл	TAX тоо	санх/ гүйцэтгэл
1	Архангай	21	2.3	446	16.1	356	12.2	335	9.9
2	Баян-Өлгий	133	6.1	704	11.6	631	8.7	498	2.6
3	Баянхонгор	42	4.6	596	25.3	524	20.9	482	16.3
4	Булган	14	3.1	443	14.0	364	10.9	350	7.8
5	Говь-Алтай	78	7.5	614	19.7	490	16.4	412	8.9
6	Говьсүмбэр	0	1.5	108	6.8	95	4.2	95	2.7
7	Дархан-Уул	73	6.9	275	17.5	262	16.5	189	9.6
8	Дорноговь	0	14	279	38.3	253	58.8	253	44.8
9	Дорнод	37	7	419	31.2	386	28.1	349	21.1
10	Дундговь	0	9.1	404	18.5	356	22.1	356	13.0
11	Завхан	45	3.1	854	19.7	738	16.5	693	13.4
12	Өвөрхангай	0	0	468	18.8	376	15.0	376	15.0
13	Өмнөговь	108	4.9	384	45.4	301	37.7	193	32.8
14	Сүхбаатар	414	18.6	417	56.4	304	30.0	(110)	11.4
15	Сэлэнгэ	38	5.3	356	30.9	268	22.0	230	16.7
16	Төв	22	6	665	32.5	543	25.9	521	19.9
17	Орхон	80	5.7	286	29.9	208	15.4	128	9.7
18	Хэнтий	0	9.6	278	15.8	239	13.8	239	4.2
19	Увс	359	8.1	502	14.1	445	10.4	86	2.3
20	Хөвсгөл	35	3.9	643	20.7	546	15.1	511	11.2
21	Ховд	50	3.7	735	32.4	658	26.0	608	22.3
<b>Аймгуудын дүн</b>		<b>1549</b>	<b>131</b>	<b>9876</b>	<b>515.6</b>	<b>8,343</b>	<b>426.7</b>	<b>6,794</b>	<b>295.7</b>
22	Улаанбаатар	194	12.8	463	59.7	369	49.8	175	37.0
<b>Улсын хэмжээнд нийт</b>		<b>1,743</b>	<b>143.8</b>	<b>10,339</b>	<b>575.3</b>	<b>8,712</b>	<b>476.5</b>	<b>6,969</b>	<b>332.7</b>

## Хавсралт 1

Тендерийн хэмнэлтийг хасаж тооцохгүйгээр нэмэлт гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээ  
/сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	ТЭЗ	Магадлалын төсөвт өртөг	Байгуулсан гэрээний дүн	Тендерийн хэмнэлт	Тендерийн хэмнэлтээр бууруулах гэрээний дүн
1	Спорт заалны барилга /Увс, Хяргас сум/	ОНБТ СҮХД	2,535.8	2,535.8	18.2	2,517.6
2	Багшийн хөгжлийн төвийн барилга /Ховд, Жаргалант сум/	БШУС	7,227.3	7,226.7	283.1	6,943.6
3	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, Улаанбайшинт боомт/	БШУС	1,388.5	1,388.5	4.0	1,384.5
4	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Булган сум, Сайхан баг/	БШУС	1,924.0	1,924.0	14.0	1,910.0
5	Сүхбаатар дүүргийн хүүхэд, залуучуудын ногоон бүсийн зуслан /Улаанбаатар, Налайх дүүрэг/	ХНХС	4,562.7	4,562.7	7.1	4,555.6
6	Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	ХНХС	3,090.8	3,090.8	18.3	3,072.5
7	Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	ХНХС	6,803.9	6,803.9	20.0	6,783.9
8	Хүүхэд, залуучууд, ахмадын хөгжлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо/	ХНХС	1,310.3	1,310.3	24.1	1,286.2
9	Ахмадын төвийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/	ХНХС	2,207.8	2,207.8	11.7	2,196.1
10	Цэцгийн тос үйлдвэрлэх сүүний ферм /Булган, Тэшиг сум/	ХХААХҮС	3,715.9	3,715.9	20.0	3,695.9
11	Спорт цогцолборын барилга, 150 суудал /Улаанбаатар, Багахангай дүүрэг, 2 дугаар хороо/	ОНБТ СҮХД	2,412.9	2,412.9	14.4	2,398.5
12	Соёлын төвийн барилга, 300 суудал /Хэнтий, Галшар сум/	Соёлын сайд	3,068.6	3,068.6	4.1	3,064.5
13	Соёлын төвийн барилга, 300 суудал /Баян-Өлгий, Толбо сум/	Соёлын сайд	2,763.1	2,763.1	6.4	2,756.8
14	Ахмадын урлаг, соёлын төвийн барилга /Хөвсгөл, Мөрөн сум/	Соёлын сайд	779.5	779.5	11.1	768.4
15	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/	ЭМС	28,656.3	28,656.2	57.3	28,598.9
16	Эрүүл мэндийн төвийн барилга, 20 ор /Баян-Өлгий, Өлгий сум, Хотгор баг/	ЭМС	1,003.32	1,003.3	5.0	998.3
17	Зооноз өвчин судлалын төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	ЭМС	2,680.4	2,680.0	54.0	2,626.0
	<b>Нийт</b>		<b>76,131.1</b>	<b>76,130.0</b>	<b>572.8</b>	<b>75,557.3</b>

**Хавсралт 2**  
**Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хэмжээгээр хуваарилж батлаагүй төсөл, арга хэмжээ**  
**/сая төгрөг/**

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	ТЭЗ	Хэрэгжих хугацаа (3 жил)	Төсөвт өртөг	Төлөвлөсөн санхүүжилт, өртөгт эзлэх хувь (сая төгрөг)					
					2022 онд		2023 онд		Хоёр жилд	
					Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Аймгийн төвийн 1800 айлын орон сууцны хорооллын цахилгаан хангамж, инженерийн шугам сүлжээ (Дорнод, Хэргэн сум)	БХБС	2022-2024	9,749.6	192.0	2.0	193.8	2.0	385.8	4.0
2	Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо, 2, 30, 31 дүгээр байр/	БХБС	2022-2024	2,100.0	160.0	8.0	50.0	2.0	210.0	10.0
3	Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай/	БХБС	2022-2024	26,964.8	1,390.6	5.0	6,387.6	24.0	7,778.2	29.0
4	Хабитат, Мангирт чиглэлийн дулаан хангамжийн 2 дугаар жонтур /Дархан-Уул, Дархан сум, 15 дугаар баг/	БХБС	2022-2024	7,646.5	420.0	5.0	2,018.8	26.0	2,438.8	32.0
5	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/	БХБС	2022-2024	25,328.3	2,400.0	9.0	6,425.6	25.0	8,825.6	35.0
6	Аймгуудын шинэ суурьшлын бүсэд баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтэц /Улсын хэмжээнд/	БХБС	2022-2024	100,000.0	13,680.0	14.0	23,340.2	23.0	37,020.2	37.0
7	Хуучин орон сууцны дахин төлөвлөлт, дэд бүтэц, хотын инженерийн шугам сүлжээний засвар, шинэчлэл /Өвөрхангай, Арвайхээр сум/	БХБС	2022-2024	5,200.0	250.0	5.0	1,000.0	19.0	1,250.0	24.0
8	Төвийн болон гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ, тохижилт /Төв, Сэргэлэн, Эрдэнэ, Баянчандмань, Борнуур сум/	БХБС	2022-2024	15,792.9	2,100.0	13.0	4,368.1	28.0	6,468.1	41.0
9	"Залуус-1" орон сууцны хорооллын төслийн гадна инженерийн 1 дүгээр хэлхээний шугам сүлжээ, барилга байгууламж, авто зам /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	БХБС	2022-2024	28,834.6	3,642.2	13.0	8,460.6	29.0	12,102.8	42.0
10	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан автобус /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	БШУС	2022-2024	5,400.0	210.0	4.0	200.0	4.0	410.0	8.0
11	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/	БШУС	2022-2024	3,200.0	300.0	9.0	100.0	3.0	400.0	13.0
12	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Завхан, Баянтэс сум/	БШУС	2022-2024	6,179.9	238.1	4.0	1,000.0	16.0	1,238.1	20.0

13	Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Хөвсгөл, Галт сум, 5 дугаар баг/	БШУС	2022-2024	14,447.9	300.0	2.0	3,199.2	22.0	3,499.2	24.0
14	Сургуулийн барилга, 960 суудал, спорт заал /Хөвсгөл, Мөрөн, 8 дугаар баг, Дэлгэрмөрөн цогцолбор сургууль/	БШУС	2022-2024	13,055.0	216.2	2.0	3,270.3	25.0	3,486.5	27.0
15	Сургуулийн барилга, 960 суудал /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/	БШУС	2022-2024	11,000.0	500.0	5.0	2,622.2	24.0	3,122.2	28.0
16	Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Хөвсгөл, Жаргалант сум, 5 дугаар баг/	БШУС	2022-2024	15,105.5	400.0	3.0	3,158.7	21.0	3,558.7	24.0
17	Сургуулийн барилга, 640 суудал /Завхан, Улиастай сум, 5 дугаар баг/	БШУС	2022-2024	11,550.0	220.0	2.0	3,152.2	27.0	3,372.2	29.0
18	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 300 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 24 дүгээр хороо/	БШУС	2022-2024	4,800.0	1,216.8	25.0	583.2	12.0	1,800.0	38.0
19	Багшийн хөгжлийн төвийн барилга /Ховд, Жаргалант/	БШУС	2022-2024	7,227.3	1,000.0	14.0	1,816.9	25.0	2,816.9	39.0
20	"Алтанбулаг" чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөл /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	ЭЗХС	2022-2024	15,634.1	200.0	1.0	3,193.8	20.0	3,393.8	22.0
21	Сэргээн засах эмнэлгийн барилга, 40 ор /Өмнөговь, Даланзадгад сум, 6 дугаар баг/	ЭМС	2022-2024	4,692.0	140.0	3.0	600.0	13.0	740.0	16.0
22	Эх хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төвийн "Хүүхдийн зөвлөх поликлиник"-ийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	ЭМС	2022-2024	20,674.5	468.0	2.0	3,992.3	19.0	4,460.3	22.0
23	Нисэх буудлын өргөтгөлийн барилга /Баян-Өлгий, Өлгий/	ЗТХС	2022-2024	4,495.3	500.0	11.0	350.0	8.0	850.0	19.0
24	Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн хатуу хучилттай авто зам, 68.3 км /Хэнтий, Норовлин, Дорнод, Баян-уул /	ЗТХС	2022-2024	75,380.7	1,260.0	2.0	21,856.7	29.0	23,116.7	31.0
25	Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх хатуу хучилттай авто зам, 50 км /Дорнод, Баян-Уул сум/	ЗТХС	2022-2024	89,360.3	1,080.0	1.0	5,000.0	6.0	6,080.0	7.0
26	Хадлангийн талбайг сэргээх "Борбулан" төсөл /Булган, Баяннуур сум/	ХХААХҮС	2022-2024	3,000.0	300.0	10.0	300.0	10.0	600.0	20.0
27	Үр тариа хадгалах агуулах /Увс, Дорнод/	ХХААХҮС	2022-2024	4,930.8	400.0	8.0	1,049.8	21.0	1,449.8	29.0
28	10/35/6 кв-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэл /Баянхонгор/	ЭХС	2022-2024	13,296.7	2,453.6	18.0	3,530.4	27.0	5,984.0	45.0
29	Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж /Улаанбаатар/	ЭХС	2022-2024	29,912.8	5,882.6	20.0	7,996.6	27.0	13,879.2	46.0
30	Хилийн анги шинээр байгуулах /Хөвсгөл, Цагаан-Уул/	ХЗДХС	2022-2024	8,339.1	2,000.0	24.0	1,892.0	23.0	3,892.0	47.0
31	Олон угсаатны театрын барилга /Ховд, Жаргалант сум/	СоС	2022-2024	15,758.5	4,200.0	27.0	3,400.2	22.0	7,600.2	48.0



Монгол Улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: +976 51-261585. Факс: +976 11-323266, 11-324853  
И-мэйл: [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)